

# БИДНИЙ ТУРШЛАГА-2020

Нийслэлийн цэцэрлэг, сургуулийг засварлаж, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэхэд эцэг эх, иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлсэн сайн туршлагын эмхэтгэл

**2020 он**

# НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 152 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ



## БИДНИЙ ТУХАЙ

Тус цэцэрлэг нь анх 1984-1994 онд 3 дугаар цэцэрлэг нэртэйгээр байгуулагдсан. Нийт 3 бүлэгт 75 хүүхэдтэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. 2005-2010 онд "Шинэ үе-Гэгээ" цогцолбор цэцэрлэгийн 3 дугаар байр, 2010 оны 4 дүгээр сард Нийслэлийн Засаг даргын 185 тоот захирамжаар бүтцийн өөрчлөлтөд орж 152 дугаар цэцэрлэг болон өргөжиж биеэ даасан бөгөөд нийт 28 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж эхэлсэн.

2013 оны 9 дүгээр сарын 1-ээс эрхлэгчээр Ж.Алтан-Од ажиллаж байна. Манай цэцэрлэгт арга зүйч 1, багш 7, ажилтан 22 буюу нийт 31 хүний бүрэлдэхүүнтэй дүүргийн алслагдсан гэр хорооллын 3, 4 дүгээр хорооны 278 хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгож байна. 2015 оны 9 дүгээр сарын 9-ээс НҮБ-ын хөрөнгө оруулалтаар 30 хүүхдийн хүчин чадалтай "Гэр бүлэг" шинээр нээж хамран сургалтыг 3 хувиар нэмэгдүүлсэн. Бид Нийслэлийн жишиг "Галерей" цэцэрлэг болох зорилт тавин ажиллаж байна.

## ХҮҮХДҮҮДИЙН АМЖИЛТ

- Налайх дүүргийн ЗДТГ, Замын цагдаагийн хэлтэстэй хамтран зохион байгуулсан "Замын хөдөлгөөний цагаан толгой" тэмцээнд I байр

- МҮОНТ-ийн “Тоглоомын тойрог” нэвтрүүлэгт 40 хүүхэд бэлтгэн оролцуулж, I байр, СӨБ-ын байгууллагын цомын эзэн
- “Уянгаар хөглөгдсөн миний нутаг” урлагийн наадамд нийт дүнгээр I байр
- Дүүргийн “Уран хөдөлгөөнт гимнастикийн аварга шалгаруулах” тэмцээний 2 удаагийн аварга

## БАЙГУУЛЛАГЫН АМЖИЛТ

- Багш нарын баярыг тохиолдуулан явуулсан “Спорт-2015” наадамд оролцон СӨБ-ын байгууллагын цомын эзэн
- 2016 онд дүүргийн “Шилдэг тохижилттой байгууллага”-аар шалгарсан.
- 2017 онд дүүргийн “Хүүхдэд ээлтэй цэцэрлэг”
- Налайх дүүргийн засаг даргын тамгын газраас 2015, 2016, 2017, 2018 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт үнэлгээгээр амжилттай дүгнүүлж “бүрэн хангалттай” буюу “А” үнэлгээтэй үнэлэгдсэн.
- “Уянгаар хөглөгдсөн миний нутаг” урлагийн наадамд нийт дүнгээр I байр эзэлсэн.

## “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хэрэгжилт манай цэцэрлэгт



**Ж.Алтан-Од (Нийслэлийн Налайх дүүргийн 152 дугаар цэцэрлэгийн эрхлэгч):**
Тус цэцэрлэгийн барилга 1984 онд ашиглалтад орсон бөгөөд уурын зуухны галлагаатай, зөөврийн устай, барилгын гадна хийцэд огт засвар хийж байгаагүйгээс элэгдэж хуучирсан, дэлгүүрийн зориулалтаар ашиглах явцдаа хаалгуудыг хааж, цонхнуудыг тоосгодож, аврах гарц шатуудыг хаасныг иж бүрнээр засварлаж, цэцэрлэгийн стандартад нийцүүлсэн. Өвлийн улиралд, багш ажилтнууд компьютер дээр сууж ажиллахад хурууны үзүүр хүртэл даардаг, хүүхдүүд төдийгүй багш, ажилтнуудын дунд өвлийн улиралд өвчлөл эрс нэмэгдэж, хүүхдийн ирц 50 хүртэлх хувиар буурдаг. Өрөө тасалгаа нь 13$^0$С хэмээс хэтрэхээргүй хүйтэн байдаг.

Өвлийн улиралд түлшний зардалд нийт 11.2 сая төгрөг зарцуулж, зуухны хүчин чадлын дагуу халаалтын үйл ажиллагааг хэвийн явуулж, дулааны шугамд гарсан гэмтлийг цаг алдалгүй засварлах арга хэмжээг авч ажиллаж байсан ч

барилгын доторх тасалгааны дулааны хэм маш бага буюу хүйтэн байсан нь гадна хийцийн элэгдэлтэй холбоотой байлаа.

Цахилгааны монтажийг огт шинэчлээгүйгээс хуучирч муудсан, цахилгааны утаснууд хайлах, буудах, цахилгааны масс үүсэх, улмаар хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүд шатах явдал тогтмол гардаг байсан. Өрөө тасалгаануудын 80 хувь нь цахилгааны ил монтажтай учраас хүүхдийн аюул осолгүй байдлыг хангахад хүндрэлтэй. Цахилгааны хүчдэлээс шалтгаалж гал тогооны тоног төхөөрөмж шатах асуудал гарч хүүхэд хүлээж авах боломжгүй болох эрсдэл үүсдэг байсан. Мэргэжлийн хяналтын байгууллага болон дүүргээс цэцэрлэгийн орчны аюулгүй байдлын чиглэлээр хийсэн шалгалтуудад цахилгааны монтажны асуудлаас болж хангалтгүй үнэлэгддэг байсан бол төсөл хэрэгжсэнээр цэцэрлэгийн цахилгаан монтажийг бүрэн засварлаж, хүүхдэд аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлж чадсан юм.

Дулаалгын ажил хийгдсэнээс хойш ангиудын дулаан 8-9 хэмээр нэмэгдэж тогтмол 22-23 хэмийн дулаантай байх болсон. Ингэснээр хүүхдүүд анги танхимдаа хөнгөн нимгэн хувцастай ирж, хичээлд оролцох идэвх эрс сайжирсан.

Багш, ажилтнууд ажлаа хэвийн явуулах, үр бүтээлтэй ажиллах боломжийг нээж, нийгмийн асуудлыг олон талаар шийдвэрлэж чадсан энэхүү төсөл гэр хорооллын тусламж дэмжлэг шаардлагатай цэцэрлэгт хэрэгжсэнээрэй олон эцэг эх, асран хамгаалагч багш, ажилтнуудын талархлыг хүлээж байна. Мөн төслийн хүрээнд Нийслэлийн цэцэрлэг, сургуулийн хөрөнгө оруулалтын цахим бүртгэлийн мэдээллийн санг бий болгож, хөрөнгө оруулалтыг нээлттэй, ил тод байх боломжийг бүрдүүлсэнд гүнээ талархаж байна.

**Б.Баярмаа (Нийслэлийн Налайх дүүргийн 152 дугаар цэцэрлэгийн арга зүйч, дэмжих багийн ахлагч):**



Энэ төсөл хэрэгжсэнээр маш олон зүйлийг сурсан.
Үүнд:

- Хяналтын хуудас боловсруулах, тохиргоо хийх, хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх арга зүйд суралцсан.
- Зөвшилцлийн хуудас боловсруулан хэрэгжүүлэх чадвар эзэмшсэн.
- Харилцан бие, биеэ хүндэтгэх, багийн гишүүд бие биеэ сонсох, хүлээцтэй хандах, тулгамдаж буй асуудлыг илрүүлэн, шийдлийг хамтдаа эрэлхийлж багаар ажиллах чадварт суралцсан.

- Бичиг баримт, тайлан, зөвшилцлийн хуудас боловсруулах, зөвшилцөх зэрэг чадварууд сайжирсан.
- Барилгын дулаалгыг стандартын дагуу хийж, гүйцэтгэх талаар мэдлэг, төсөөлөлтэй болж, өөрийн амьдралд хэрэгжүүлэх чадвар дадлыг эзэмшсэн.
- Барилгын их засвар, дулаалгын стандарт, барилгын материалын чанар, орц нормын талаар мэдлэгтэй болсон.



**Б.Баасанпүрэв (Нийслэлийн Налайх дүүргийн 152 дугаар цэцэрлэгийн бүлгийн багш):**

Төсөл хэрэгжихэд цэцэрлэгийн удирдлага, багш, эцэг эх, нэгдэн цэцэрлэгийн бодлого, хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийхэд багийн зохион байгуулалтад орж, харилцан дэмжлэг үзүүлж, нэгэн зорилгын төлөө нэгдэж ажиллалаа. Энэ төсөлд оролцсоноор хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ нь ямар үр дүнтэй ажил болохыг ойлгож авлаа. Энэ ажил цэцэрлэгийн үйл ажиллагаанд олон талаар нөлөөлж сургалт, танин мэдэхүйн орчны өөрчлөлтийг бий болгож байна.

**Б.Мөнгөнцэцэг (Нийслэлийн Налайх дүүргийн 152 дугаар цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл):**

Энэ зун хүүгийнхээ цэцэрлэгийн засварын ажилд хяналт тавьж, дэмжих багт орж ажилласан. Цэцэрлэгийн өдөр тутмын үйл ажиллагаа, орчин нөхцөл өмнө нь ямар байсан засварын дараа хэрхэн өөрчлөгдсөн зэрэг нь эцэг эхчүүд бидний нүдэнд ил харагдахуйц тод томруун байна. Эцэг эхийн оролцоо, хамтын ажиллагаа цэцэрлэгийн үйл ажиллагаанд ямар ач тустай болохыг энэхүү төслийн дэмжих багт орж ажилласнаараа мэдэж авлаа.



## ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦОО

| | |
|---|---|
| Зорилго | Бага насны хүүхэд байгальтай зүй зохистой харьцах, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах үзлийг төлөвшүүлэх зорилго бүхий орчныг бүрдүүлэхэд эцэг эхийн зүгээс тавих хяналт, оролцоог нэмэгдүүлэх |
| Нөхцөл байдал, тулгамдсан асуудал | Бага насны хүүхдэд экологийн боловсрол олгох нь хамгийн чухал байдаг. Экологийн боловсрол эзэмшсэн хүүхдүүд байгальтайгаа зүй зохистой харьцах, амьдрах орчноо тэтгэн сайжруулах, эрүүл амьдрах арга ухаанд суралцах, байгалийн нөөц баялгийн үр өгөөжийг зохистой, хэмнэлттэй ашиглах соёл эзэмших, байгаль орчны гоо сайхныг таашаах, хүн байгальтайгаа зохицон амьдрах сэтгэлгээгээ хөгжүүлж чадсан байдаг.<br>• “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд 2020 оны эрхлэгчийн тушаалаар дэмжих баг байгуулагдаж, барилгын их засвар болон цэцэрлэгийн гадна, дотор орчинд эцэг эхийн оролцоонд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж эцэг эхээс санал асуулга авсны үр дүнд сайжруулах шаардлагатай зүйлсийн жагсаалтыг гаргасан. Тоглоомын талбай, байгалийн буланг нэн тэргүүнд сайжруулах шаардлагатай хэмээн жагсаалтын эхний байранд эрэмбэлэгдсэн.<br>• Тоглоомын талбай нь зөөлөвч шалгүй, 2 гулсуур, 2 дүүжин, бусад тоглоом шаардлага хангахгүй байсан.<br>• Байгалийн булан ор нэр төдий хүүхдийн танин мэдэхүйг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулдаггүй, хүүхдүүдийн хувьд байгалийн буланд ажиллах боломж хомс байсан. Олон төрлийн цэцэг байгаа ч хүүхдүүд нэрлэж чадахгүй үзмэр төдий байна.<br>Дээр дурдсан нөхцөл байдал нь бага насны хүүхдэд экологийн боловсрол олгох сургалтын таатай, ээлтэй орчин бүрдээгүй гэсэн асуудлыг үүсгэж байв. |
| Зорилтот бүлэг | Цэцэрлэгийн 270 хүүхэд, тэдний эцэг эх, 31 багш, ажилтан |
| Шалгуур үзүүлэлт | • Байгалийн булантай бүлгийн тоо;<br>• Суурилуулалт хөдөлгөөнгүй суурилагдаж, аюулгүй байдлыг хангасан байгалийн булангийн тоо<br>• Хүүхдийн хөдөлгөөнд саад учруулахааргүй зохион байгуулагдсан байгалийн булантай бүлгийн тоо |

| | |
|---|---|
| | • Туршилт хийх боломжтой байгалийн булантай бүлгийн тоо;<br>• Байгалийн булангийн талбай $м^2$;<br>• Үйл ажиллагаанд шаардагдах багаж хэрэгслүүд болон ахуйн хэрэглээний эд зүйлсийн тоо;<br>• Байгалийн буланд ашиглагдаж байгаа багаж хэрэгслийг аюулгүй хадгалах хайрцаг, савтай бүлгийн тоо;<br>• Хүүхдэд юмсын учир шалтгаан, холбоо хамаарлын талаар таамаглал дэвшүүлэх, турших үзэх, дүгнэж ярилцах боломж бүрдсэн байдал;<br>• Хүүхдүүд ангидаа цэцэг, ургамал тарьж арчлан, өсөлт өөрчлөлтийг ажиглаж судлах боломж бүрдүүлсэн байдал; Жишээ нь: Цаг агаарын өөрчлөлтийг тэмдэглэх, ярилцах боломж олгох.<br>• Амьдарч буй орон нутаг, хүмүүсийн ажил үйлс, мал, тэжээмэл амьтдын ашиг тус, ургамал, цаг агаарын онцлог, ургамлын амьдралд гарч буй өөрчлөлт зэрэгтэй танилцах аяллын тоо;<br>• Хүмүүс байгальд болон орчиндоо эерэг, сөрөг хандаж буй байдал, түүний үр дагаврыг илэрхийлсэн үлгэр, зохиол, бичлэг, зургийн тоо |
| Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат | • Эрхлэгчийн тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй “дэмжих баг” байгуулсан.<br>• Дэмжих багийн гишүүд цэцэрлэгийн гадна орчинд 1 удаа, дотор орчинд 2 удаа ажиглалт хийж, эцэг эхийн оролцоонд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.<br>• Сайжруулах шаардлагатай 2 чиглэлийг сонгон авсан.<br>• Дэмжих багийн гишүүд хийх ажлын төлөвлөгөө боловсруулсан.<br>• Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаа цэцэрлэгийн нийт эцэг эхэд танилцуулж, хэн юу хийхэд туслах талаар ярилцаж, шийдэлд хүрсэн.<br>• Бүлэг бүр багаараа байгалийн булангийн зураглал гаргасан.<br>• Цэцэрлэгийн багш ажилтнууд “Бичил музей”-н зураглал гаргаж, хийх ажлаа хуваарилан авсан. |
| Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд) | • Хүүхэд байгалийн буландаа өдөр бүр ажиллах боломж бүрдсэн.<br>• Хүүхдэд бага наснаасаа эхлэн амьд байгальтай зохистой харьцах, хайрлах, хамгаалах, үзлийг төлөвшүүлэх, өөрийн насны онцлогт тохирсон хөдөлмөрийг хийх, |

| | |
|---|---|
| | тоглох, суралцах явцдаа мэдлэг эзэмших боломжтой болсон.<br>Орчин бүрдүүлэх ажилд, багш, ажилчид, эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж хамтран ажиллах замаар эко боловсролыг дэмжих зорилгоор дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн.<br>• Анги танхим өрөө тасалгааны өнгө үзэмж ногоон байгууламжийн талбайг 4м$^2$ байсныг 5м$^2$-аар нэмэгдүүлсэн.<br>• Хүүхэд хөгжих аюулгүй, эко орчин бүрдүүлэхэд цэцэрлэгийн ажилтан нэг бүр санаачилгатай ажиллаж бүлэг бүр ангидаа загас тэжээж, тасалгааны 80 төрлийн цэцгийн савыг сольж хаягжуулсан.<br>• 10 нэр төрлийн 56 цэцэг шинээр тарьж эко ногоон орчин бүрдүүлж ажилласан.<br>• Бичил музейгээр дамжуулж дүүргийн онцлог болон тус хороонд амьдардаг казах үндэсний онцлогийн талаар хүүхдэд мэдлэг олгож, цаг үеийн байдал болон улирлын онцлогт тохируулан үзмэрүүдийг шинэчилж, хүүхэд болон эцэг эхийн мэдлэгт хувь нэмэр оруулж тэднийг хөгжүүлэх экологийн боловсролыг нэмэгдүүлэх сайн эхлэлийг тавиад байна. Мөн бичил музейд амьтан танилцуулах хэсэг ажиллуулж байна. Үгээр дамжуулан туулай, зараа, загас зэрэг амьтдыг танилцуулах, хайрлан хамгаалах, арчлах, тэдний онцлогийн талаар танилцуулж байна.<br>• Гялгар уутан нэг удаагийн улавчнаас татгалзан, даавуун улавч өмсдөг болсон.<br>• Бүлэг бүр хог хаягдлыг ангилан ялгаж, хүүхэд бүрд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах дадал, хэвшлийг эзэмшүүлэхээр ажиллаж байна. |
| Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд | • Эцэг эх, олон нийтийг хамарсан бүтээлч ажлуудыг зохион байгуулсан.<br>• Хүүхдэд ээлтэй эко орчин бүрдүүлсэн багш ажилтнуудыг урамшуулсан.<br>• Цэцэрлэгийн дотоод журмын 7.2-т “Эцэг эхийн оролцоот хяналт, шинжилгээ-үнэлгээг жилд 2 удаа зохион байгуулна” гэсэн заалтыг оруулж өгсөн.<br>• Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрт хүүхэд бүрд үе шаттайгаар эко боловсрол олгоход багш, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлэн 2020-2021 оны хичээлийн жилд хэрэгжүүлэн ажиллаж байна. |

| | |
|---|---|
| Тулгарсан бэрхшээл, эрсдэл | • Дэмжих багийг ажиллуулах хүндрэлтэй байсан. Бүлэг бүрээс 1, 1 эцэг эхийг дэмжих багт оруулсан байсан нь хүндрэлтэй байсан.<br>• Эцэг эхчүүдийн цаг зав хомс байсан тул оройн цагаар ирж үнэлгээ хийх тохиолдлууд их гарч байсан. Заримдаа дэмжих багийн эцэг эхчүүд өөрсдөө үнэлгээ хийх боломжгүй гэсэн шалтгаанаар бусад эцэг эхийг орондоо явуулж, үнэлгээ хийлгүүлж байсан нь эцэг эхчүүд чухам юу хийгээд байгаа талаар мэдээлэлгүй байх, үнэлгээг дутуу дулимаг хийх зэрэг бэрхшээл үүсэж байсан. Тиймээс бүлэг бүр “дэмжих баг”-ийг байгуулж, эцэг эхийн оролцоонд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тулгамдаж буй асуудлаа илрүүлж, засан сайжруулах шаардлагатай. |
| Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс | • Цэцэрлэгийн гадаад болон дотоод орчны үнэлгээг хийхдээ хэрэгцээг тодорхойлон хэрэгжүүлэх, бүтээлч санал, санаачилга гарган оролцохыг эрмэлзэж байсан нь цэцэрлэгийн үйл ажиллагаа эцэг эхэд нээлттэй, ил тод болоход ихээхэн түлхэц үзүүлсэн.<br>• Цэцэрлэгийн дэмжих баг болон төслийн баг, гүйцэтгэгч компани хоорондоо харилцан ойлголцож, бие биеэ хүндэтгэн, засах шаардлагатай зүйлийг харилцан зөвшилцсөний үндсэн дээр сайжруулж ажилласан.<br>• Мөн барилгын их засварын талаарх сургалт, уулзалт зохион байгуулж, зөвлөгөө зөвлөмж өгч, хяналтын инженер ажиллаж байсан нь амжилтад нөлөөлсөн. |
| Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс | • Нөлөөллийн ажлыг олноор зохион байгуулж, эцэг эхчүүдийн ойлголтын зөрүүг арилгах;<br>• Эцэг эх, асран хамгаалагчдаа бусад цэцэрлэгийн сайн туршлагатай танилцуулах боломжоор хангах, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;<br>• Эцэг эхийг цэцэрлэгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга барилд биечлэн эсвэл дагуулж, үйлдэн сургах;<br>• Эцэг эхийн санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэр гаргахад оролцуулж, тэдний оролцоо дэмжлэг зайлшгүй шаардлагатайг ойлгуулах, нөлөөлөх, хандлагыг өөрчлөх |
| Холбоо барих хаяг | **Нийслэлийн Налайх дүүргийн 152 дугаар цэцэрлэг**<br>Эрхлэгч Ж.Алтан-Од, Утас: 99088049, jaltanod@yahoo.com<br>Арга зүйч Б.Баярмаа, Утас: 88023351, ama3315@yahoo.com |

| | |
|---|---|
| | Багш Б.Баасанпүрэв, Утас: 99717135, BSK717135@gmail.com |

## ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭН БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДУЛААЛГЫН ЯВЦ ДАХЬ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

| | |
|---|---|
| Зорилго | 2-5 хүртэлх насны хүүхдүүдэд эрүүл, аюулгүй, тохь тухтай, дулаан орчинд сургуулийн өмнөх боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх |
| Нөхцөл байдал, тулгамдсан асуудал | • Цэцэрлэг нь 980 м$^2$ талбай бүхий 2 давхар барилга, гадаа хашаандаа гэр цэцэрлэгийн салбар болох 2 гэр бүхий 1 бүлэгтэй, Солонгос улсад үйлдвэрлэгдсэн КРС-300 маркийн ялтсан бойлер уурын зуухаар галладаг.<br>• Цэцэрлэгийн барилга 1984 онд ашиглалтад орсноос хойш цахилгааны монтажийг огт шинэчлээгүйн улмаас хуучирч муудсан цахилгааны утаснууд хайлах, буудах, цахилгааны масс үүсэх, улмаар хүүхдийн хоолны тоног төхөөрөмж шатах явдал байнга үүсэж байсан. Бүлгүүд болон бусад өрөөнүүдийн 80 хувь нь цахилгааны ил монтажтай төдийгүй 2015 оны 8 дугаар сард аянга бууснаас болж цахилгааны томоохон гэмтэл гарсан болон тогтмол үүсэж буй гэмтлийг өөрсдийн нөөц бололцоогоор засварласаар ирсэн ч цаашид цахилгааны монтаж нь эдэлгээ даах болон засварлах боломжгүй болоод байсан.<br>• 1996-2003 оны хугацаанд одоогийн үйл ажиллагаа явуулж буй барилгыг цэцэрлэгийн зориулалтаар бус худалдааны байгууллага болох дэлгүүрийн зориулалтаар ашиглаж байсан. Энэ хугацаанд анх барилга баригдах үед хийсэн аврах гарцуудыг хааж битүүлэн, шатуудыг тайрч авсан нь Монгол улсын “Галын аюулгүй байдал”-ын тухай хуулийн *21 дүгээр зүйл буюу “Барилга байгууламж, объектын зураг төсөл зохиох, хянахад галын аюулгүй байдлыг хангах шаардлага”-ыг ноцтой зөрчиж байсан.* Ингэснээр гарч болзошгүй гэнэтийн аюулын үед хүүхдүүдийг гадагш гаргах боломжгүй нөхцөл байдал үүсэж томоохон эрсдэл учрах аюултай болоод байсан.<br>• Цэцэрлэгийн барилга ашиглалтад орсноос хойш барилгын гадна хийцийн засвар хийж байгаагүйгээс шалтгаалан элэгдэж хуучирсан бөгөөд 2012 оны нэгдүгээр сард дулааны алдагдлыг багасгах зорилгоор төсөвт тусгагдсаны дагуу хуучин модон цонхыг вакум |

| | |
|---|---|
| | цонхоор сольж шинэчлэх ажил хийгдсэн ч цонхны амлагааг хийгээгүй орхигдуулснаас жавар хурган жилээс жилд дулааны алдагдал нэмэгдэж, өвөлдөө нарны тусгалын эсрэг талд байрлах ангиудын дулаан $13^0C$ хэмээс хэтрэхээргүй хүйтэн байдаг болсон.<br>• Түлшний зардалд нэг улиралд дунджаар нийт 11.2 сая төгрөг зарцуулж, зуухны хүчин чадлын дагуу халаалтаа хэвийн байлгаж, дулааны шугамд гарсан гэмтлийг цаг алдалгүй засварладаг ч барилгын доторх тасалгааны дулааны хэм бага буюу хүйтэн байгаа нь гадна хийцийн элэгдэлтэй холбоотой байлаа.<br>• Ангиудын дулаан $13^0C$ хэмээс хэтрэхээргүй хүйтэн байдгаас шалтгаалан хүйтний улиралд хүүхдийн өвчлөл нэмэгдэж, ирц 50 хүртэлх хувиар буурдаг.<br>Дээрх нөхцөл байдал нь 2-5 хүртэлх насны хүүхдүүдэд эрүүл, аюулгүй, тохь тухтай, дулаан орчинд сургуулийн өмнөх боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх зорилгыг хэрэгжүүлэхэд томоохон бэрхшээл болон тулгамдаж байсан. |
| Зорилтот бүлэг | Цэцэрлэгийн 270 хүүхэд, тэдний эцэг эх, 35 багш, ажилтан |
| Шалгуур үзүүлэлт | • 2019-2020 оны хичээлийн жилийн эхэнд цэцэрлэгийн багш, ажилтан, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн 9 хүний бүрэлдэхүүнтэй "Дэмжих баг" байгуулж, цэцэрлэгийн гадаад орчинд эрсдэл аюулгүй байдлын хяналт үнэлгээ хийсэн байх.<br>• Гадаад орчны эрсдэл, аюулгүй байдлын үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн цэцэрлэгийн эргэн тойронд эрсдэл, аюулгүй байдлыг 45 хувиар бууруулсан байх<br>• Цэцэрлэгийн барилга байгууламжийн өнөөгийн байдал, засвар үйлчилгээ, дулаалгын нөхцөл байдлыг Нийслэл, дүүргийн ЗДТГ болон холбогдох байгууллагуудад танилцуулж, 2020-2021 оны хичээлийн жилд цэцэрлэгийн багш, ажилтан, эцэг эхийн "Дэмжих баг"-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тогтмолжуулсан байх<br>• Цэцэрлэгийн гадаад болон дотоод орчинд хийсэн хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд түшиглэн цэцэрлэгт тулгамдаад байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх шийдлийг дэмжих баг боловсруулсан байх |
| Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат | • Дэмжих баг цэцэрлэгийн бодлого, эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийж, үр дүнгээ цэцэрлэгийн удирдлага, багш ажилтанд танилцуулах ярилцлага зохион байгуулсан. |

| | |
|---|---|
| | • Ярилцлагын үр дүнд цэцэрлэгээс гаргасан санал хүсэлтийн шийдвэрийг эцэг эхэд эргэн танилцуулах, ажлаа төлөвлөхдөө дэмжих багийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, эцэг эхийн санал санаачилгыг тусгах, энэ талаар эргэн мэдэгдэж байх зохицуулалтыг цэцэрлэгийн дотоод дүрэм журамд тусган эрхлэгчийн тушаалаар баталгаажуулсан.<br>• Багш ажилтан, эцэг, эхийн төлөөллөөс бүрдсэн “Дэмжих баг" зохион байгуулалтад орж, цэцэрлэгийн гадаад, дотоод орчинд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тулгамдсан асуудлуудыг тодорхойлсон.<br>• Цэцэрлэгийн нийт эцэг, эхээс хүүхдийнхээ сурч, хүмүүжиж буй цэцэрлэгийн сургалтын орчны талаарх санал асуулга үр дүнг нэгтгэн цаашид хийх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулав.<br>• Боловсруулсан төлөвлөгөөгөө батлахын өмнөх цэцэрлэгийн багш ажилтан, эцэг эхийн дунд 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж зохих өөрчлөлтийг хийсэн. Ийнхүү сайжруулсан үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар баталгаажуулан ажилласан.<br>• Цэцэрлэгийн удирдлага, багш, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн дэмжих баг "Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь" төслийн зөвлөх инженерийн сургалтад хамрагдаж барилгын дулаалга, стандарт, материалын онцлогийн талаар ойлголт, мэдлэгтэй болсон.<br>• Төслийн багаас барилгын дулаалга, засвар үйлчилгээний явцад хөндлөнгийн хяналт үнэлгээ хийхээр боловсруулсан ”Хяналтын хуудас”-ыг ашиглан засварын ажлын эхэн, дунд, эцсийн үнэлгээ хийлээ.<br>• Үнэлгээний үр дүнд тулгуурлан зөвшилцлийн хуудас боловсруулан, гүйцэтгэгч компанидаа шаардлага тавин ажилласны зэрэгцээ төслийн баг, цэцэрлэгийн удирдлагад тухай бүрд нь тайлан боловсруулан илгээсэн. |
| Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд) | • 2020-2021 оны хичээлийн жилийн эхэнд цэцэрлэгийн барилгын засвар бүрэн дуусаж, барилгын дулаан өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7-9 хэмээр нэмэгдэж, бага насны хүүхдийн сурч хөгжих, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлж чадлаа.<br>• Цэцэрлэгийн нийт эцэг эх, багш, ажилтнууд хүүхдэд ээлтэй, таатай орчин бүрдүүлэхэд идэвх санаачилга |

| | |
|---|---|
| | гарган, бүлгүүдийн байгалийн буланг тохижуулж ногоон орчин бүрдүүлж гадна тоглоомын талбайг тохижуулахаар ажиллаж байна.<br>• Цэцэрлэгийн удирдлагаас эцэг эхийн хурал зохион байгуулах арга зүйгээ шинэчлэн, тэмдэглэл хийж хэвшсэнээр тэдний оролцоонд хяналт тавих, хамтын ажиллагааг хөгжүүлэх гол үндэс болсон. Эцэг, эх цэцэрлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож үйл ажиллагааны туршид хуримтлуулсан туршлагаа үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бодлого боловсруулсан. |
| Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд | • Эцэг эхийн зөвлөл, дэмжих баг цэцэрлэгийн орчны стандарт, аюулгүй байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг багш, ажилтан, эцэг эхчүүдэд танилцуулсан.<br>• Эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээ нь цэцэрлэгийн үйл ажиллагааг сайжруулахад үр өгөөжөө өгч байгаа учир жилдээ 2 удаа “Эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээ”-г хийж, түүний дагуу төлөвлөгөө боловсруулан хүүхдэд ээлтэй, таатай сургалтын орчин бүрдүүлэх, хүүхдийн хөгжил, төлөвшилд хувь нэмэр оруулах зорилгоор цэцэрлэгийн дотоод журам болон гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна. |
| Тулгарсан бэрхшээл, эрсдэл | • Цэцэрлэгийн үйл ажиллагаа дахь эцэг эхийн оролцоо бага, хамтын ажиллагааны мэдлэг ойлголт харилцан адилгүй байсан нь багагүй бэрхшээл үүсгэсэн. Тиймээс цэцэрлэгийн багш, ажилтан, эцэг эхийг бие биеэ ойлгож, эерэг уур амьсгал бүрдүүлэхийн тулд танилцах уулзалт зохион байгуулж, тэдний харилцаа хандлагад өөрчлөлт гаргах нь зөв юм.<br>• Эцэг эхийн мэдлэг боловсрол харилцан адилгүй, өмнө нь цэцэрлэгийн бодлого эрх зүйн баримт бичгийн өөрчлөлт, төлөвлөлтийн үйл явцад оролцож үзээгүй учир удирдах ажилтны амыг харах, санал бодлоо илэн далангүй солилцож чадахгүй, хуулиар хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагаа хангалттай түвшинд сайн мэдэхгүй байсан. Эрхлэгч, арга зүйч цэцэрлэгийн дотоод зохицуулалт, үйл ажиллагааны онцлог, эцэг эхийн эрх, үүрэг хариуцлагын талаар мэдээлэл бэлтгэн эцэг эхэд хүргэсэн нь энэ бэрхшээлийг шийдвэрлэхэд зохих нөлөө үзүүлсэн.<br>• Цэцэрлэгийн удирдлага, багш, ажилтан, эцэг эхчүүд барилгын засвар үйлчилгээ, дулаалгын ажлын явцын |

<table>
<tr><td></td><td>талаар мэдлэг дутмаг, гүйцэтгэгч компани ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, ур чадвар харилцан адилгүй учир засвар болон явцын хяналт үнэлгээний ажил эхлэхийн өмнөх ойлголт, төсөөлөл харилцан адилгүй нь нэлээд бэрхшээлийг үүсгэсэн. Харин хяналтын зөвлөх инженер тусгайлан сургалт зохион байгуулсан нь бүгд нэг ойлголт, мэдэгдэхүүнтэйгээр ажлаа эхлэхэд ихээхэн дэмжлэг болсон</td></tr>
<tr><td>Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс</td><td>Цэцэрлэгийн зүгээс:<ul><li>Энэ ажлыг хэрэгжүүлэх явцдаа эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээний аргыг ашиглаж сурсан бөгөөд аль болох цэцэрлэгийнхээ бусад үйл ажиллагаатай уялдаж, зохицуулахыг хичээн ажиллах нь зүйтэй юм.</li></ul>Эцэг эхийн зүгээс:<ul><li>Цэцэрлэгийн гадаад болон дотоод орчны үнэлгээг хийхдээ хэрэгцээг тодорхойлон хэрэгжүүлэх, бүтээлч санал, санаачилга гарган оролцохыг эрмэлзэж байсан нь цэцэрлэгийн үйл ажиллагаа эцэг эхэд нээлттэй, ил тод болоход ихээхэн түлхэц үзүүлсэн.</li></ul>Бусад байгууллагын зүгээс:<ul><li>Эцэг эх, иргэд, олон нийтийг цэцэрлэгийн үйл ажиллагаанд татан оролцуулах, хамтын ажиллагааг сайжруулах, сургалт сурталчилгаа хийх, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн.</li></ul></td></tr>
<tr><td>Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс</td><td><ul><li>Нийт багш, ажилтан, эцэг эх, иргэдийн хувьд хамтын ажиллагаа, бага насны хүүхдэд зориулсан эрсдэл аюулгүй орчин, хамгаалалт, түүний ач холбогдлын талаарх ойлголт харилцан адилгүй. Иймд багш, ажилтан, эцэг эх, иргэдийг нэгдсэн мэдээллээр хангаж орчны зургийг хэрхэн хийх, хяналт үнэлгээний онцлог, анхаарах асуудлыг үйл ажиллагаа эхлэхийн өмнө ухуулан танилцуулах</li><li>Орчны зураглал хийх, хяналтын хуудсаар үнэлэх, дүгнэх арга зүйд багш, ажилтан, эцэг эхийг суралцуулах</li><li>Цэцэрлэгээс эцэг эх, олон нийтийн оролцоот үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, бүхий л талаар дэмжиж ажиллах</li><li>Эцэг эх олон нийтийн ажиллагааны тайланг нийтэд хүргэх, сурталчлах</li></ul></td></tr>
</table>

| | |
|---|---|
| | • Байгаль, цаг агаарын болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг сайн төлөвлөх нь учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлнэ. |
| Холбоо барих хаяг | **Нийслэлийн Налайх дүүргийн 152 дугаар цэцэрлэг**<br>Эрхлэгч Ж.Алтан-Од, Утас: 99088049, jaltanod@yahoo.com<br>Арга зүйч Б.Баярмаа, Утас: 88023351, ama3315@yahoo.com<br>Багш Б.Баасанпүрэв, Утас: 99717135, BSK717135@gmail.com |

## БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДУЛААЛГЫН АЖЛЫН ЯВЦАД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

Дүүрэг: Налайх Байгууллага: 152 дугаар цэцэрлэг

Огноо: 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр

| **БАРИЛГЫН ЗАСВАРЫН АЖЛЫН ҮЙЛ ЯВЦ ЭХЭЛСНЭЭС ХОЙШ ЦУГЛУУЛАХ МЭДЭЭЛЭЛ** | | | |
|---|---|---|---|
| **Шалгуур** | | **Тэмдэглэгээ** | **Тайлбар/дэлгэрэнгүй** |
| 3.1 | Барилгын зураг төсөлд тэмдэглэгдсэн бүх цонх, гадна хаалгыг шинэчлэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>★ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | 9 хаалга суурилуулсан. Амлагаа хийгдээгүй байна. |
| 3.2 | Цонх, хаалганы байрлал түүний ус тусгаарлалт, битүүмжлэлийн үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>★ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | • Цонхны рамын өргөн: 72 Давхар шилний тоо: 3<br>• Цонхны хүрээний таславчийн тоо: 6 |
| 3.3 | Гадна ханыг иж бүрэн, зохих зузаанаар дулаалах үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>★ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | • Хөөсөнцрийн зузаан 15 см<br>• Нягт: 20<br>• Грунт Орос, солонгос<br>• Хөөсөнцрийн цавуу Хятад<br>• Чулуут замаскийн гарал үүслийн гэрчилгээ Гарал үүслийн гэрчилгээтэй. |

| | | | |
|---|---|---|---|
| 3.4 | Дээврийн дулаалгыг иж бүрэн хийх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>★ **Ажил дуусах шатандаа** | Ажлын явц 90%-тай байна. Малгай төмөр, 3 сэндвичин хавтан дутуу байна. |
| 3.5 | Цонхны амлагаа болон дотор тавцангууд бүрэн хийгдэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>★ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | Цонхнууд бүрэн суусан. Тавцан бүрэн суусан. Анхан шатны амлагаа хийгдэж байна. Ажлын явц 75%-тай байна. |
| 3.6 | Халаалтын системийг зургийн дагуу гүйцэтгэх үйл явц | ★ **Огт тусгагдаагүй**<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 3.7 | Сантехникийн тоноглолууд иж бүрэн, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан эсэх | ★ **Огт тусгагдаагүй**<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 3.8 | Дээвэрт ус нэвтрэхгүй битүүмжлэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>★ **Ажил дуусах шатандаа** | Хуучин хар цаасыг ус, уур тусгаарлагчаар ашигласан. |
| 3.9 | Цэвэр, бохир усны шугам шаардлагатай стандартын дагуу хийгдэх үйл явц | ★ **Огт тусгагдаагүй**<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 1. | **Ажиглагдсан зөрчил, дутагдал:**<br>• Ажиллах хүч дутмаг байна.<br>• Ажлын явц удаашралтай байна. | | |
| 2. | **Цаашид анхаарах зүйлс:**<br>• Ажиллах хүчээ нэмэгдүүлэх, хэд хэдэн бригад ажиллуулах | | |

| | |
|---|---|
| 3. | **Барилгын их засвар, дулаалгын явцын талаарх ерөнхий дүгнэлт:**<br>• Барилгын их засварын явцын үнэлгээг дэмжих багийн 8 гишүүн хийсэн.<br>**Явцын үнэлгээгээр:**<br>• Барилгын засварын ажил 60 хувьтай явагдаж байна. Гадна фасад удаашралтай. Ганц бригад ажиллаж байна.<br>• Цонх бүрэн суурилагдсан. Амлагаанууд дутуу байна. Цонхны амлагааг нэмэлтээр цэцэрлэгийн 2 ажилтан хийж байна.<br>• Аваарын гарц, хаалгыг нээсэн. Гадна хаалга бүрэн суурилуулсан. Дотор модон хаалга ирээгүй байна. Дотор хаалга сууж, амлагаа явагдана. Ажлын явц 60%-тай байна.<br>• Дээвэр ажлын явц дуусах шатандаа явагдаж байна. Малгай төмөр, 3 сэндвичин хавтан дутуу байна.<br>• 2 давхарт 1 цонх налуу суусан, зүүн жигүүрт 1 цонх хэмжээ бага байсныг тохиролцож янзлуулсан. Мөн үүдний 2 саарал хаалгыг бор хаалгаар солиулсан.<br>• Төслийн зүгээс цэцэрлэгийн цахилгааны (бүрэн шинэчлэх) засварыг хийж өгөхөөр болсон. |

| |
|---|
| Нэгтгэл гаргасан хүний нэр, холбоо барих хаяг, утас |
| Арга зүйч Б.Баярмаа |

**ЗӨВШИЛЦЛИЙН ХУУДАС**

| |
|---|
| *Нийслэлийн НАЛАЙХ дүүргийн 152 дугаар цэцэрлэгийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа БАТ КОМПЛЕКТ компани нь “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд зохион байгуулалтад орсон “Дэмжих баг”-ийн гишүүдийн барилгын засвар, дулаалгын ажлын явцад хийсэн эцэг эхийн оролцоот, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, санал дүгнэлттэй танилцлаа.* |
| **Дэмжих багийн гишүүдийн тайланд туссан дараах зүйлсийг гүйцэтгэгч их засвар, дулаалгын явцад тусгаж ажиллахаа талууд харилцан зөвшилцлөө.** |
| 1. Барилгын засвар удаашралтай байгаа тул хүн хүчийг нэмэгдүүлэх;<br>2. Цэцэрлэгийн 2 ажилтан цонхны амлагаа хийж байгаа тул цалин хөлсийг тохирсны дагуу олгох;<br>3. Цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг зөв боловсон ашиглах;<br>4. Цэцэрлэгийн ойр орчим бие засахгүй байх;<br>5. Бүлэгт орой орж амрахдаа цэвэрхэн байх;<br>6. Ажилчдынхаа аюулгүй ажиллагааг хангаж ажиллах;<br>7. Ажлыг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх, ажлын цагийг баримтлах; |

8. ХАБЭА-н шаардлагыг мөрдөж ажиллах;
9. Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, тамхи татахгүй байх;
10. Дэмжих багийн гишүүд хуваарийн дагуу хяналт тавьж ажиллах;
11. Хяналт тавих ажлын явцад харилцан бие биеэ хүндэтгэж хамтран ажиллах;

| Дэмжих багийн ахлагч 152 дугаар цэцэрлэгийн арга зүйч Б.Баярмаа | Хяналтын инженер<br><br>С.Сарантуяа | Компанийн захирал<br><br>Ц.Цэрэнбат<br> |
|---|---|---|



## ДҮГНЭХ ХУУДАС

*Нийслэлийн Налайх дүүргийн 152 дугаар цэцэрлэгийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа “Баткомплект” ХХК компани болон “Дэмжих баг”-ийн гишүүдийн харилцан зөвшилцсөн ажил үйлчилгээ нь дор дурдсан байдлаар биелэгдсэн байна.*

| Харилцагч талууд | № | Зөвшилцсөн ажлууд | Ажлын биелэлт |
|---|---|---|---|
| Гүйцэтгэгч компанийн зүгээс | 1 | Барилгын засвар удаашралтай байгаа тул хүн хүчийг нэмэгдүүлэх; | Барилгын засварын ажлыг чанартай гүйцэтгэж, хугацаандаа хүлээлгэн өгөхийн тулд хүн хүчийг нэмэгдүүлж ажилласан.<br>Гүйцэтгэл: 100% |
| | 2 | Дээврийн ус зайлуулах шугамыг стандартын дагуу шаардлага хангасан материалаар хийж гүйцэтгэх | Дээврийн ус зайлуулах шугамыг зураг төслийн дагуу хийж битүүмжлэлийг бүрэн хангахаас гадна хуучин бөглөрсөн байсан шугамуудын бөглөөг гаргаж нөхөн сэргээж ажилласан.<br>Гүйцэтгэл: 100% |
| | 3 | Цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг зөв боловсон ашиглах;<br>Цэцэрлэгийн ойр орчим бие засахгүй байх; | Цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг боловсон ашиглаж, тогтмол цэвэрлэж байсан. |

| | | | |
|---|---|---|---|
| | | Бүлэгт орой орж амрахдаа цэвэрхэн байх; | Цэцэрлэгийн ойр орчим болон амарч байсан бүлэгтээ цэвэр нямбай байж, цэвэрлэгээг тогтмол хийж байсан. Гүйцэтгэл: 100% |
| | 4 | Ажилчдынхаа аюулгүй ажиллагааг хангаж ажиллах;<br><br>Ажлыг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэхийн тулд ажлын цагийг баримтлах; | Барилгын даамал ажилчдынхаа аюулгүй байдлыг байнга хангаж ажилласан. Барилгын ажлыг хугацаанд нь чанартай хийж, ажлын цагийг баримталж ажилласан. Мөн цэцэрлэг болон дэмжих багийн зүгээс тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлж, харилцан бие биеэ хүндэтгэн ажилласан. Гүйцэтгэл: 100% |
| | | ХАБЭА-н шаардлагыг мөрдөж ажиллах; Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, тамхи татахгүй байх; | ХАБЭА-н шаардлагыг бүрэн биелүүлж ажилласан. Ажлын байранд архи согтууруулах ундаа хэрэглэлгүй ажлын цагийг баримтлан барилгын их засвар, дулаалгын ажлыг хугацаанд нь хүлээлгэн өгөх тал дээр анхаарч ажилласан. Гүйцэтгэл: 100% |
| Цэцэрлэгийн зүгээс | 1 | Дэмжих багийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үед саад болохгүй, харилцан бие биеэ хүндэтгэж ажиллах | Дэмжих багийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажилласан. Гүйцэтгэл: 100% |
| **Дүгнэлт:** | | | |
| Барилгын гүйцэтгэгч “Бат комплект” ХХК-тай Дэмжих багийн гишүүд харилцан зөвшилцсөн 11 ажлаас 11 ажил 100% бүрэн биелж, 100%-ийн гүйцэтгэлтэй байна. | | | |
| **Биелэлтийг дүгнэсэн хүний нэр, холбоо барих хаяг, утас:** | | | |
| Дэмжих багийн ахлагч : Аргазүйч Б.Баярмаа Утас: 88023351<br>Э-шуудан: ama3315@yahoo.com | | | |

# ЗУРГИЙН ЦОМОГ










# НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 79 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ



## БИДНИЙ ТУХАЙ

Одоогоос 42 жилийн өмнө Улаанбаатар хотын Мах консерв комбинатын дарга н.Батжаргал ажилчдынхаа хүүхдүүдэд зориулан 150 хүүхдийн хүчин чадалтай 6 бүлэгтэй цэцэрлэгийн барилга бариулан, дотоод тоног төхөөрөмжийн хамтаар иж бүрэн өгч ашиглалтад оруулж байлаа. Тухайн үед Хүүхдийн төлөө төв фонд (А.И Филатова)-оос цэцэрлэгийн хүүхдийн ширээ, сандал, ор, хөнжил, матраас, шүүгээ, тоглоом наадгай, сургалтын хэрэгсэл гээд бүхий л зүйлийг өгч манай хамт олон 7 багш, 23 ажилтантайгаар нээлтээ хийж байсан түүхтэй.

2014 оны 8 дугаар сараас эхлэн цэцэрлэгийн эрхлэгчээр Т.Ундармаа ажиллаж байна. 2015-2016 оны хичээлийн жилээс 2 гэр цэцэрлэг нэмж, хамран сургах тойргийнхоо хүүхдийн хүртээмжийг нэмэгдүүлж, 320 хүүхдийн хүчин чадалтай ажиллаж байна. Хүүхдийн хүчин чадал нэмэгдэхийн хэрээр тоног төхөөрөмж болон ажиллах хүч нэмэгдэж нийт 34 багш ажилтантай ажиллаж байна.

## БИДНИЙ АМЖИЛТ

Манай хамт олон 42 дахь хичээлийн жилээ Нийслэл, дүүргийн уралдаан тэмцээнд идэвхтэй оролцсон амжилт бүтээлээр дүүрэн угтаж байна.

- 2000 онд Сонгинохайрхан дүүргийн тэргүүний цэцэрлэг
- 2002 онд Сонгинохайрхан дүүргийн цэцэрлэгүүдийн ажлын амжилтаар II байр
- 2015 онд Сонгинохайрхан дүүргийн шилдэг тохижилттой цэцэрлэг
- 2015 он, 2016 оны УИХ гишүүн Д.Сумьяабазарын нэрэмжит спортын тэмцээнд
  "Гар бөмбөг"-ийн төрөлд тусгай байр
- 2016 онд "Бүтээлч цэцэрлэг" хүндэт өргөмжлөл
- 2016 онд "Хууль дээдлэгч аж ахуйн нэгж" хүндэт өргөмжлөл
- 2017 оны "Ногоон гэрэл цагаан шугам" СХД-н цэцэрлэгүүдийн тэмцээнд тус цэцэрлэгийн "Дөл" баг II байранд шалгарсан.
- 2000 он, 2014 оноос Сургуулийн Өмнөх Боловсролын Сургуулийн оюутан багш нартай хамтран ажиллаж клиник цэцэрлэгээр ажиллаж байна.

### "Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь" төслийн хэрэгжилт манай цэцэрлэгт



**Т.Ундармаа (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 79 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч):**

Манай цэцэрлэг нь 1978 онд байгуулагдаад эдүгээ 42 дахь жилийнхээ намартай золгож байна. Үүсэн байгуулагдсанаас хойш нэг ч удаа бүрэн засвар үйлчилгээ хийгдэж байгаагүйн улмаас барилгын чанар муудаж, дээврээс ус гоождог, дулаан алдалт их, сантехникийн цэвэр бохирын шугам байнга хагарч хөлддөг, агааржуулалтын систем муу, гал тогооны уурын таталт ажиллахгүй өвөлдөө ангиудын цонх их цантаж хүйтэн байсан. Энэ талаар зохих байгууллагуудад хүсэлт гаргаж явуулснаар 2020 онд "Монгол дахь барилга байгууламжийн эрчим, хүчний үр ашгийг дээшлүүлэх нь" төсөлд хамрагдаж барилгын дулаалга, засвар үйлчилгээний асуудлаа шийдэж чадсандаа манай хамт олон баяртай байна.

Энэхүү төслийн онцлог нь "дэмжих баг" байгуулж, багийн гишүүдийг чадавхжуулах сургалтад үе шаттай хамруулан, засварын явцад хяналт тавих, үнэлгээ дүгнэлт өгч, үр дүнг нь тооцож ажилласан нь барилгын засварын явцыг

чанартай хийхэд гол түлхэц өгсөн гэж бодож байна. Монгол улсын гэрэлт ирээдүй болсон хүүхдүүдийн хувьд сурч боловсрох, хөгжих таатай орчин бүрдэж байгаад талархаж байгаагаа энэ дашрамд илэрхийлж байна.



**М.Алтайхүү (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 79 дүгээр цэцэрлэгийн багш):** Би цэцэрлэгтээ 29 дэх жилдээ ажиллаж байна. Манай цэцэрлэгийн анги танхим, өрөө тасалгаанууд цонхоороо дулаан алддаг, дээврээс ус гоождог, мөөгөнцөр үүссэн байдалтай байсан. Жил бүр өөрсдийн нөөц бололцоогоор урсгал засварын ажлыг хийдэг боловч асуудлыг бүрэн шийдэж чаддаггүй байлаа. 2020-2021 оны хичээлийн жилд 42 жилийн түүхэнд анх удаа их засварт орж бидний ажиллах нөхцөл бололцоо сайжирсанд сэтгэл ханамжтай байна. Цэцэрлэгийн гадна фасад, дээвэр, цонх, хаалга, аваарын шат, цонхны тавцан бүгд шинэчлэгдэн солигдож, цэцэрлэг маань шинэ өнгө төрхтэй болсонд бид хувьд туйлын их талархаж байна. Ийм сайхан эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгсөнд баярлалаа.

**Б.Сэргэлэн (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 79 дүгээр цэцэрлэгийн Бэлтгэл “Б” бүлгийн туслах багш):**



Манай цэцэрлэгийн дээврийн хучилт олон жил болсон учир энэ тэндээ урагдаж цоорсон, бороо цастай үед дотогшоо чийг цохидог, дээд давхрын ангиудын тааз нь өнцгөөрөө мөөгөнцөртсөн байсан. Дээврийн хар цаасыг хуулахад завсраараа хавсарсан чийгтэй байлаа. Энэ төслийн хүрээнд ман  ай цэцэрлэг дээврийн хүндрэлтэй асуудлыг бүрэн шийдэж чадлаа. Мөн өрөө тасалгаа бүрийн цонхнууд суулт өгч хагарсан, салхи сийгдэг, өвөлдөө хүйтэн байдаг байсан. Энэ төслийн хүрээнд бүх өрөөний цонх солигдож, байгалийн гэрэлтүүлэг сайтай болж, хүүхдүүдийн хувьд эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих боломж бүрдлээ.



**Н.Оюун-Эрдэнэ (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 79 дүгээр цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл):**

Анх 2012 онд том хүү маань тус цэцэрлэгт элсэн орсноос хойш энэ сайхан хамт олонтой холбоотой болсон. Өөдлөх айл үүднээсээ гэдэг хаалгыг татаад ороход цэвэрхэн, дулаан, найрсаг хамт олон угтдаг. Жил бүр шаардлагатай засвар үйлчилгээг хийж ирсэн. Энхрий бяцхан үрсийн минь сурч хөгжих орчныг бүрдүүлэхэд бие сэтгэлээ зориулж байгаа эрхлэгч, багш, ажилчид нь маш их баярлаж явдаг. Манайх дөрвөн хүүхэдтэй бүгд энэ цэцэрлэгээр дамжин сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна. Энэ жил цэцэрлэгийн гадна фасад, дээврийн дулаалга, анги бүрд аваарын гарц хаалга хийж, цэвэр усны шугам солих, гадна ногоон байгууламжийн тохижилт, хүлэмж зэргийг барьж цэцэрлэгийн гадаад болон дотоод орчны тохижилтод өнгө үзэмж нэмж тохилог дулаахан болсон.

**Н.Ариунбат (Сонгинохайрхан дүүргийн 79 дүгээр цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл):**

Эцэг эхчүүд хамтран хүүхдийнхээ ангид эрүүл аюулгүй, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх ажлыг гүйцэтгэлээ. Ангид байгаа эд хогшил бүрийг хананд тогтоож, булантай эд хогшилд хамгаалалт хийлээ. Цэцэрлэгийн захиргаа болон багш нарын зүгээс эцэг эх бидэнд хүүхдийн сурч хөгжих эрсдэлгүй таатай орчны талаар мэдлэг мэдээлэл олгох сургалтыг зохион явуулсан. Эцэг эхчүүд бид энэ сургалтад хамрагдсанаар хүүхдийн хөгжилд цэцэрлэгийн гадаад, дотоод орчин ямар чухал болохыг мэдэж авсан. Эцэг эхчүүд хамтран энэ ажилд оролцсоноор өмнө нь мэддэггүй, чаддаггүй байсан олон зүйлээ сурч авлаа. Одоо орчны аюулгүй байдлыг анзаарч үр хүүхдэдээ байнга анхааруулан хэлж хэвшээд байна.

## БОДИТ ОРЧИН - СУРГАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

| | |
|---|---|
| **Зорилго** | Бодит орчныг бүрдүүлэх байдлаар сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд байгаль орчин, экологийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх |
| **Нөхцөл байдал, тулгамдсан асуудал** | **Нөхцөл байдал:**<br>• Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн насны онцлог, эрэлт хэрэгцээнд тулгуурлан байгаль орчин, экологийн |

| | |
|---|---|
| | талаар мэдлэг эзэмшүүлэх бодит орчин байхгүй байсан.<br>• Хүүхдийг орчны осол эрсдэлээс өөрийгөө хамгаалахын тулд тэмдэг, тэмдэглэгээг таниулж мэдүүлэх шаардлага гарч ирсэн.<br>• Туршилтын талбай байгуулах зай бага байсан.<br>• Сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаан дахь эцэг эхийн оролцоо муу байсан.<br><br>**Тулгамдсан асуудал:**<br>• Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд байгаль орчин, экологийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх боломж тааруу байсан. |
| **Зорилтот бүлэг** | 2-5 насны 260 хүүхэд, 560 орчим эцэг эх, асран хамгаалагч, 34 багш, ажилтан |
| **Шалгуур үзүүлэлт** | • Цэцэрлэгийн гадаад талбайд хүлэмж байгуулах, цэцгийн мандлын тоо, бут сөөгийн тоог нэмэгдүүлэх, хүнсний ногооны 5 төрлийг тарьж ургуулах<br>• Цэцэрлэгийн эцэг эх, хүүхдүүд ногоон орчин бүрдүүлэх, сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд байгаль орчин, экологийн мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд оролцсон хувь<br>• Хүүхдийн сурч хөгжих, танин мэдэх үйл ажиллагааг дэмжих ногоон байгууламжийн талбайн хэмжээ<br>• Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд бодит орчинд тулгуурлан, байгаль орчин, экологийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх зорилгоор зохион байгуулсан сургалтын тоо |
| **Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат** | • Манай цэцэрлэг хүүхдийн эрхийг дээдэлсэн, эрүүл аюулгүй, эрсдэлгүй орчныг бүрдүүлэхийн тулд удирдлага, багш, ажилтан, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн “Дэмжих баг”-ийг байгуулсан. Багийн гишүүд сайн дураар эвлэлдэн нэгдэж, тэдний үйл ажиллагааг эрхлэгчийн тушаалаар баталгаажуулсан.<br>• Дэмжих багийн гишүүд гадна талбайдаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хуудсыг зөвшилцөн боловсруулж, ашигласан.<br>• Дэмжих багийнхан  хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээ цэцэрлэгийн 34 багш, ажилтанд танилцуулан, тэдний саналыг авч, дотоод нөөц бололцоогоо ашиглан |

| | |
|---|---|
| | ажиллахаар ярилцаж, ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн.<br>• Хичээлийн жилийн намрын эхэнд, хавар тарах үеийн туршилтын талбайн хэрэгцээ шаардлагад тулгуурлан зохион байгуулах сургалт, ажлын чиглэлээ тодорхойлсон.<br>• Хүлэмж болон хүнсний ногоо, мод зүлгийг тарихдаа мэргэжлийн хүнээс зөвлөгөө авч, туршлагаас нь суралцсан.<br>• Хүлэмж хийхэд шаардлагатай материалын орцыг тооцох, үнийн судалгаа гарган, мэдээлэл цуглуулсан.<br>• Бодит байдалтай танилцан, гүйцэтгэх ажлын зураглал гаргасан.<br>• Шаардлагатай багаж хэрэгслийг бэлтгэн агрономич мэргэжилтэй эцэг эхээс шаардлагатай туслалцааг авч хамтран ажилласан.<br>• Өндөржүүлсэн бэлэн байдалтай холбогдуулан багш нар эцэг эхчүүдтэй биеэр уулзах боломжгүй учраас хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүнг нийт 8 бүлгийн фейсбүүк группээр дамжуулан цахим зөвлөмж, уриалгыг бэлтгэн нийт 300 гаруй эцэг эхийг засварын ажилд уриалан, мэдээ мэдээллээр ханган ажилласан.<br>• Цэцэрлэгийн орчинд хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхийн тулд “Хүүхэд зорчиж байна” ТББ-тай хамтарч “Аав аа ээж ээ намайг автомашинаас хамгаалаач, дураараа биш дүрмээрээ, хүүхэд зорчиж байна, энд гарц бий” гэсэн тэмдгийг байршуулсан.<br>• Хүүхдийг байгаль орчинтой зөв харилцахад туршилтын талбайн гүйцэтгэх үүргийн талаар 2 төрлийн судалгаа гаргасан. |
| **Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)** | • Хүнсний ногооноос гадна жимсний мод 3 төрөл, бут сөөг 3-4 төрлийг шинээр нэмж тариалсан ба цэцэрлэгийн хашаан дахь мод ургамал, туршилтын талбайн хүнсний ногоог хаягжуулах тэмдэгжүүлэлтийг хийлээ.<br>**2019-2020 оны хичээлийн жилд дараах төрлийн ургамлыг тарьж байсан. Үүнд:**<br>Бут сөөг - 4 төрөл<br>Мандлын цэцэг - 6 төрөл<br>**2020-2021 оны хичээлийн жилд дараах байдлаар нэмэгдсэн. Үүнд:**<br>Бут сөөг - 6 төрөл<br>Мандлын цэцэг - 9 төрөл |

| | |
|---|---|
| | Жимсний мод - 3 төрөл Хүнсний ногоо - 4 төрлийг тарьж байсан бол — Жимсний мод - 8 төрөл Хүнсний ногоо - 8 төрлийг тарьж үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.<br>• Мод бут сөөгийн нэрийг бичиж хаягжуулснаар хүүхдүүд ургамал ногоог таньж мэдэж, нэрлэж сурахад их дөхөмтэй болсон.<br>• Манай цэцэрлэг туршилтын талбай, хүлэмжийг барьж байгуулснаас гадна 7 төрлийн хүнсний ногоог хүүхдүүдтэйгээ хавар намартаа тарих, хураах авах ажлыг бодит орчинд нь биечлэн хийлгэснээр хүүхдүүд хөдөлмөрийн үр шимийг мэдрэх, хөдөлмөрийг хүндэтгэх үзэлд суралцсан үр дүнтэй ажил боллоо.<br>• 2019-2020 оны хичээлийн жилд туршилт танин мэдэхүйн талбай байгуулснаар хүүхдүүд бага наснаас нь байгаль орчин, юмс үзэгдлийг сонирхох ажиглах, таньж мэдэх, цэцэг ургамлыг арчилж ургуулах боломжтой болсон. Багш нар байгаль нийгмийн орчин, туршилт танин мэдэхүйн хичээл, сургалтын үйл ажиллагааг цэцэрлэгийн туршилтын талбайд зохион байгуулах боломж бүрдсэн.<br>• Цэцэрлэгийн гадаах ногоон байгууламждаа анхаарснаар цэцэрлэгийн гадаад орчны өнгө үзэж сайжирсан.<br>• Туршилт танин мэдэхүйн талбайг бүрэн тохижуулж, бодит орчныг бүрдүүлж өгснөөр хүүхдийн байгальтай зөв харьцах, ургамал болон орчноо бохирдуулахгүй, хүмүүсийн хөдөлмөрийг хайрлах зэрэг хандлага нэмэгдсэн.<br>• Туршилт танин мэдэхүйн талбайг тэмдэгжүүлж өгснөөр хүүхэд болон эцэг эхчүүд ногоон байгууламжийг анхаарч хайрлах болсон. |
| **Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд** | Дэмжих багийн үйл ажиллагааг тогтворжуулахаар байгууллагын эрх зүйн баримт бичгүүдэд дараах нэмэлт, өөрчлөлтүүд оруулсан.<br><br>**Цэцэрлэг, бүлгийн багш, хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчийн хооронд байгуулсан гурвалсан гэрээнд шинээр тусгасан заалтууд:**<br>*2-р бүлэг. Эцэг эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг* |

| | |
|---|---|
| | • 2.1. Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ үнэлгээний “дэмжих баг”-ийн зүгээс зохион байгуулсан аливаа үйл ажиллагаанд өөрийн ажил, мэргэжлийн онцлогийн дагуу оролцож, сургалтын таатай орчин бүрдүүлэхэд туслах<br>• 2.13. Хүүхдийнхээ суралцаж байгаа анги танхимд эрүүл, аюулгүй байдлыг хангах, орчин нөхцөлийг сайжруулах засвар үйлчилгээнд зориулан хичээлийн жилд нэг удаа хандив, тусламж, дэмжлэг үзүүлэх<br>**Сонгинохайрхан дүүргийн 79 дүгээр цэцэрлэгийн дүрэмд шинээр тусгасан заалтууд:**<br>• 2.9. Цэцэрлэг нь эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ үнэлгээний “дэмжих баг”-тай байна.<br>• 2.11. Цэцэрлэгийн “дэмжих баг” нь ажлаа төлөвлөхдөө багш ажилтан, эцэг эхээс санал асуулга авах, тэдний санал санаачилгыг тусгах, санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэр гаргахад оролцуулах, хэрхэн шийдвэрлэснээ эргэж мэдэгдэнэ.<br>• 2.13. Цэцэрлэгийн “дэмжих баг” нь жилд 2 удаа цэцэрлэгээс зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ үнэлгээг хийж, хөндлөнгийн хяналт тавьж ажиллана.<br>• 4.9. Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийнхээ суралцаж буй анги танхимын эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, орчин нөхцөлийг сайжруулах засвар үйлчилгээнд зориулан хичээлийн жилд нэг удаа хандив, тусламж, дэмжлэг үзүүлнэ.<br><br>**Нийслэлийн 79 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журамд шинээр тусгасан заалтууд:**<br>Журмын зорилго нь 79 дүгээр цэцэрлэгийн хэмжээнд дотоод хяналт шалгалт, эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ үнэлгээг зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.<br>• 1.4. Сургалтын орчинд тулгамдаж буй асуудлыг илрүүлж, шийдвэрлэхэд эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ үнэлгээг “Дэмжих баг” гүйцэтгэнэ. “Дэмжих баг” нь 8 бүлэг бүрээс эцэг эхийн |

| | |
|---|---|
| | төлөөлөл 1, багш 1, ажилтан 1, ахлагч 1, гэсэн 11 хүний бүрэлдэхүүнтэй байна.<br>• 3.2. Дотоод хяналтын нэгж болон дэмжих баг нь хяналтын хуудас ашиглаж, эрхлэгчээр баталгаажуулж, хяналт-шинжилгээ үнэлгээг хийнэ.<br>• Туршилт танин мэдэхүйн талбай байгуулах санал, хэрэгцээ шаардлагад тулгуурлан цэцэрлэгийн захиргаа, Заах аргын нэгдэл хамтарч, ямар ажил хийхээ судалгаанд тулгуурлан шийдвэрлэж, орчин бүрдүүлэлтийг хийх, хаврын тариалалт, намрын ургац хураалтын үед хамтарч баг болон хүүхдүүддээ үзүүлэн танилцуулах ажлыг уламжлал болгон зохион байгуулна.<br>• Эхний жил төмс, байцаа, лууван, хүлэмжид өргөст хэмх, улаан лооль тарьж байсан бол дараа жилээс улаан манжин, шар манжин нэмж тариалан мандлын цэцэг - 5 төрөл, үхрийн нүдний бут - 5ш, нохойн хошуу - 3 бутыг нэмж тарьсан байна.<br>• Хаврын тариалалт дээр бүлэг бүрийг хуваарь гарган багш хүүхдүүд, эцэг эх хамтран тариалалтыг явуулна.<br>• Намрын ургац хураалтын үеэр хүүхдүүдийг хүнсний ногоо хэрхэн ургаж байгааг ажиглуулан анги бүлэгт хуваарь гарган ургацаа хураан авч, "Алтан намар" сэдэвт ажлаа туршилт танин мэдэхүйн талбайтайгаа холбож хийдэг болно. |
| **Тулгарсан бэрхшээл эрсдэл:** | • Өндөржүүлсэн бэлэн байдалтай холбогдуулан багш нар бүлгийн эцэг эхчүүдтэй биеэр уулзах боломжгүй учраас хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүнг нийт 8 бүлгийн фейсбүүк группээр дамжуулан цахим зөвлөмж, уриалгыг боловсруулан мэдээлсэн нь үр дүнтэй байсан эсэхийг тооцон үзэх боломжгүй байсан.<br>• Онцгой нөхцөл байдлын үетэй уялдуулан дотоод нөөц бололцоо, эцэг эхийн дэмжлэгээр туршилт танин мэдэхүйн талбайгаа тохижуулсан.<br>• Дэмжих багийн эцэг эхчүүд цаг баримтлахдаа муу байсан боловч засварын ажлын ач холбогдлыг ойлгон, хэрэгжүүлэх үйл явцад идэвхтэй оролцож эхэлсэн.<br>• Эхний үед хүүхдүүд ургамал ногоогоо хайрлан хамгаалах мэдлэг дутуу байснаас гадаа талбайд тарьж ургуулсан мандлын цэцэг, хүнсний ногоог зулгааж хаях, |

| | |
|---|---|
| | гишгэх зэрэг сөрөг үйлдэл гарч байсан ч аажимдаа ач холбогдлыг ойлгож, хайрлан хамгаалах болсон. |
| **Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс** | “Дэмжих баг”-ийнхан цэцэрлэгийн гадаад орчны аюулгүй байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээ цэцэрлэгийн 34 багш, ажилтанд танилцуулснаар 100 хувийн саналаар туршилт танин мэдэхүйн талбайтай болох нь зүйтэйг дэмжин, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөгөө гаргасан.<br>• Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу удирдлага, багш, ажилтан, эцэг эх санал нэгдэж, нэг баг болон хамтран ажилласан.<br>• Дотоод нөөцдөө тулгуурлан санхүү болон ажиллах нөөц боломжоо судлан, ажлыг цаг хугацаанд нь хийж, хэрэгжүүлж чадсан.<br>• Цэцэрлэгийн удирдлагын зүгээс бичиг баримт боловсруулах ажил дээр зөвлөн туслах, заавар зөвлөгөө өгч, хийгдэж буй ажлуудад чиглүүлэг өгч эцэг эх, дэмжих багийн гишүүдтэй шийдвэрийг хамтран гаргаж, шийдлийг эрэлхийлж ажилласан нь үр дүнг нэмэгдүүлэх гол хөшүүрэг болж чадсан.<br>• Мэргэжлийн хүнээс зөвлөгөө авч зааврын дагуу ургамал, бутны арчилгаа тордлогоо зөв хийсэн.<br>• Зуны амралтын хугацаанд хариуцсан жижүүр, манаач нар хариуцлагатай хандаж арчилж тордсоны хүчинд ургалт сайн, ургац арвин авсан.<br>• Туршилт танин мэдэхүйн талбайгаа Монгол телевизээр сурталчилсан.<br><br>**Эцэг эхийн зүгээс:**<br>• Эцэг эхчүүдэд байгаль орчин, экологийн сургалт зохион байгуулснаар цэцэрлэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, оролцоо, хандлага сайжирсан.<br>• Эцэг эхчүүдийн дунд сургалт, идэвхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулснаар эцэг эх-хүүхдийн дунд амьд харилцаа үүсэх, эцэг эхийн зүгээс хүүхдүүдэд экологийн зөв дадал хэвшил олгох зэрэгт эергээр нөлөөлсөн. |
| | • Эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх ойлголт харилцан адилгүй байдаг. Иймд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээс өмнө дэмжих багийн |

| | |
|---|---|
| **Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс** | гишүүд, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдад мэдээ мэдээлэл хүргэх, сургалт зохион байгуулах нь тун зөв арга хэмжээ юм.<br>• Цэцэрлэгийн их засвар, дулаан алдагдал, орчны аюулгүй байдал бүрдүүлэх ажилд эцэг эхийн оролцоог хэрхэн, жигд хангах талаар төлөвлөгөөндөө нарийвчлан тусгах<br>• Туршилт танин мэдэхүйн талбайгаар дамжуулан хүүхэд, эцэг эхчүүд байгаль орчноо хайрлан хамгаалах, хүмүүсийн хөдөлмөрийг хүндэтгэх, эко орчин бүрдүүлэхэд таны оролцоо дэмжлэг чухал гэсэн сэтгэл зүйг хэрхэн бий болгох тал дээр анхаарлаа хандуулах<br>• Мэргэжлийн хүний заавар, зөвлөгөөг авч хамтран ажиллах<br>• Орчны тэмдэг тэмдэглэгээг сайн хийх нь учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлдэг талаарх мэдлэгийг хүүхдэд эзэмшүүлэхэд анхааран ажиллах |
| **Холбоо барих утас** | **Сонгинохайрхан дүүрэг 21 дүгээр хороолол-1, 18 дугаар хороо, 79 дүгээр цэцэрлэг Утас: 70171255**<br><br>**Цэцэрлэгийн эрхлэгч Т.Ундармаа,** Утас: 99062972<br>Э-шуудан: Undarmaa2972@gmail.com<br>**Цэцэрлэгийн арга зүйч Д.Таяа** Утас: 99297332<br>Э-шуудан: Dtaya0121@gmail.com |

## ТОХИЛОГ ОРЧИН – ДУЛААН УУР АМЬСГАЛ

| | |
|---|---|
| **Зорилго** | Цэцэрлэгийн дулааны алдагдлыг бууруулж, хүүхдүүдийн хувьд эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлэхэд оршино. |
| **Нөхцөл байдал, тулгамдсан асуудал** | **Нөхцөл байдал:**<br><br>• Дулааны алдагдал ихтэй байснаас ая тухтай орчин бүрдээгүй, хүүхдүүдийн дунд улирлын чанартай ханиад томууны өвчлөл ихтэй байсан.<br>• Цэцэрлэгийн барилга, байгууламжийн агааржуулалт гэмтэж, муудсанаас хөгц мөөгөнцөр их үүссэн, хаалга, цонхны жийргэвчүүд муудсанаас дулаан алдагдалд нөлөөлж анги танхимууд хүйтэн, халдаггүй байсан.<br>• Олон жил ашиглагдсан барилгын дээврийн хучилт муудсанаас цас бороони ус гоожиж хүндрэл гарсан. |

| | |
|---|---|
| | • Байгалийн давтагдашгүй хүчин зүйл, гамшигт тохиолдол болон онцгой байдлын үед хүүхдүүдийг аврах аваарын гарц хаалга хангалтгүй байсан.<br><br>**Тулгамдсан асуудал:**<br>• Хүүхдүүдийн хувьд эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих боломж муу байсан. |
| **Зорилтот бүлэг** | • Цэцэрлэгийн 2-5 настай 8 бүлгийн 260 хүүхэд, багш, туслах багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчид |
| **Шалгуур үзүүлэлт** | • Сургалтын орчинд тулгамдаж буй асуудлыг илрүүлж, шийдвэрлэхэд эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ үнэлгээг хийх “дэмжих баг” байгуулах<br>• Дэмжих багийн гишүүд дулаалга, их засварын ажилд хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал ашиглан засварын ажлын эхэн, дунд, төгсгөл гэсэн 3 шатанд үнэлгээ хийж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд нь засан сайжруулах (гарсан өөрчлөлтөөр хэмжигдэнэ)<br>• Цэцэрлэгийн дулаан алдалтыг бууруулсан хувь<br>• Дулааны алдагдал буурснаар хүүхдийн өвчлөл буурсан хувь<br>• Барилга байгууламжийн агааржуулалтыг сайжруулснаар хөгц мөөгөнцөр арилсан байдал<br>• Онцгой тохиолдолд хүүхдийг аюул, эрсдэлээс хамгаалах аваарын гарцын тоо<br>• Нийт анги танхимын цахилгаан хэрэгслийн хамгаалалт, аюулгүй байдалд тавих, хяналтын тоо |
| **Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат** | • Дэмжих багийн гишүүд дулаалга, их засварын ажилд хяналт тавих, үнэлгээний аргачлал ашиглан эхэн, дунд, төгсгөлд 3 шатны үнэлгээ хийж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд нь засан сайжруулсан.<br>• Энэ төслийн хүрээнд эрх бүхий хүмүүстэй харилцан зөвшилцсөний үндсэн дээр цэцэрлэгийн дээвэр, агааржуулалт, аваарын шат гадна талбай, дээд 3 ангийн халаагуурт өөрчлөлт оруулан барилгын чанарт анхааран ажилласан.<br>• Дээвэр хэсгийн залгаа 16 цонхноос арын хэсгийн 4 цонхыг аван өрөлт хийж, дулаан алдахгүй болгож, бусад 3 талын 12 цонхыг сольсон.<br>• Цэцэрлэгийн суурь, хормой хэсгийн шавардлагыг ухан авч дулаалгын үйл ажиллагааг стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. |

| | |
|---|---|
| | • Дээд давхрын аваарын гарцыг зурагт заасны дагуу өргөтгөл болгон ашиглах зориулалтаар 3 ангийн өргөтгөсөн.<br>• Зураг төсөлд заасан гадна аваарын шатанд өөрчлөлт оруулсан. |
| **Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)** | • Дэмжих багийн гишүүд нийт 5 удаагийн чадавхжуулах сургалтад хамрагдаж, их засварын ажилд хяналт тавих, үнэлгээний аргачлал ашиглан эхэн, дунд, төгсгөлд 3 шатны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.<br>• Цэцэрлэгт барилгын их засвар, дулаалгын ажил хийгдсэнээр хүүхдийн өвчлөл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад энэ оны 10 сарын байдлаар 40 хувь буурсан байна.<br>• Хүүхдийн өвчлөл буурснаар эцэг эхчүүдийн ажлаасаа чөлөө авах, таслах байдал арилж цаашилбал, өрхийн орлого нэмэгдэхэд эерэг нөлөө үзүүлсэн.<br>• 2019 оны 10 сард өрөөний хэм +18, чийгшил 80 хувьтай байдаг байсан бол 2020 оны 10 сарын сүүлийн байдлаар өрөөний хэм +24, чийгшил 40 хувьтай болсон.<br>• Цонхыг шинэчилснээр цантах, чийгтсэнээс ус тавцан руу урсах, хулдаас шал норж, хүүхэд халтирч унах гэсэн багшийн айдас, санаа зовнил багасаж, сургалтын үйл ажиллагааг илүү үр өгөөжтэй зохион байгуулах болсон.<br>• Дулаалга, их засвар хийгдэж, анги танхим дулаан болсон нь эцэг эхчүүдийн хүүхдээ цэцэрлэг дээр даарч байгаа болов уу гэсэн санаа зовнилт буурч, сэтгэл ханамжийн түвшин 90 хувь болж нэмэгдсэн.<br>• Гадна дулаалгын асуудлыг шийдсэнээр бүлэг бүрийн өрөөний температур 7-8 хэмээр нэмэгдсэн.<br>• Дээврийн засварыг шийдсэнээр дээд давхрын ангийн өрөөний чийг багасаж, дусаал дусдаггүй болсон.<br>• 6 бүлэгт аваарын хаалга, шаттай болсноор богино хугацаанд хүүхдүүдийг осол авааргүй, чөлөөтэй гадагш болон дотогш нэвтрүүлдэг болсон ба онцгой, өндөржүүлсэн байдлын үед үүдэнд бөөгнөрөл үүсгэхгүй таатай нөхцөлийг бүрдүүлж чадсан.<br>• Цэцэрлэгийн гадаад ба дотоод их засвар хийгдсэнээр эцэг эх, асран хамгаалагчдын хандлага эергээр өөрчлөгдөж байна. |

| | |
|---|---|
| **Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд** | • Цэцэрлэгийн удирдлага, багш нарын зүгээс хүүхдийн сурч хөгжих тав тухтай орчныг бүрдүүлж өгч байгаад сэтгэл хангалуун байна. Цаашид энэ тохижилтын ажлаа жил бүр баяжуулан нэмэлтээр хийх ажлаа төлөвлөн боловсруулж холбогдох баримт бичигт тусгалаа.<br><br>**Тодруулбал:**<br>• Цэцэрлэгийн эцэг эхчүүдээс улирал бүр санал хүсэлтийг авч зохих ажлыг зохион байгуулах<br>• Цаашид гадаа тоглоомын талбайд хүүхдийн тоглох нөхцөлийг бүрдүүлсэн, осол аюулгүй, стандартад нийцсэн иж бүрэн тоглоомын талбайтай болохоор ажиллаж байна.<br>• Анги, бүлэг бүрийн эрсдэлтэй хэсгийг тогтоож, аюулгүй стандартын шаардлага хангасан орчин бүрдүүлэхэд анхааран ажиллаж байна. |
| **Тулгарсан бэрхшээл эрсдэл:** | Цэцэрлэгийн удирдлагын зүгээс эрсдэлгүй орчин бүрдүүлэхэд тодорхой ажлуудыг хийж байсан ч дулаан алдалт ихтэй, агааржуулалтын систем муудсан зэрэг нь хүндрэл учруулж байсан. Харин “Монгол дахь барилга байгууламжийг эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөл хэрэгжүүлсэн нь энэхүү хүндрэлтэй асуудлыг шийдэж, хүүхэд хөгжих, боловсрох таатай орчныг бүрдүүлж өгөхөд нөлөөлсөн. |
| **Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс** | **Цэцэрлэгийн зүгээс:**<br>Үйл ажиллагааны төлөвлөгөөний нэг чиглэлийг холбогдох дээд байгууллагуудад санал тавьж, хамтран ажиллах хүсэлт хүргүүлснээр нөхцөл байдалд эергээр нөлөөлсөн.<br>**Эцэг эхийн зүгээс:**<br>Дэмжих баг нь цэцэрлэгээс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт үнэлгээ хийснээр цэцэрлэгийн удирдлага, багш, ажилчидтай хамтран зохих байгууллагуудад хүсэлт илгээсэн.<br>**Төсөл хэрэгжүүлэгчдийн зүгээс:**<br>Энэхүү санаачилга үр дүнд хүрч, сайн туршлага болоход “Монгол дахь барилга байгууламжийг эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөл гол нөлөөг үзүүллээ. Төслийн зүгээс зөвхөн цэцэрлэгийн барилгын их засвар, дулаалгын асуудлыг шийдэхэд анхаарах бус, цэцэрлэгийн удирдлага, багш, ажилтан, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн “Дэмжих |

| | |
|---|---|
| | баг" байгуулж ажилласан. "Автобустай аялал" зохион байгуулж төсөлд хамрагдсан бусад цэцэрлэгийн туршлагаас суралцах боломж бүрдүүлэв.<br>"Харилцан суралцах арга зүй" сургалтад хамруулсан нь бусдын туршлагыг судлахад ихээхэн нөлөө үзүүлэв. |
| **Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс** | • Энэ туршлагыг өөрийн цэцэрлэгтээ хэрэгжүүлэхийн өмнө бүх багш нараа нэг ойлголт, мэдлэгтэй болох сургалтыг зохион байгуулж багш нар бие биеэсээ суралцах боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ нийслэл, дүүргээс зохион байгуулж байгаа хөгжүүлэх арга зүй, технологийн сургалтад хамруулах, чадварыг дээшлүүлэхэд анхаарах нь чухал юм. Багшийг бусад цэцэрлэгийн багш нартай хамтран ажиллуулах, зөвлөн туслах баг болон бусад багш нараас зөвлөгөө авах, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх нь чухал нөлөөтэй.<br>• Хичээлийн жилийн эхэнд эцэг эхтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, тухайн хичээлийн жилийн хамтын ажиллагааны төлөвлөгөөг танилцуулж, тэдний санал бодлыг сонсох, цэцэрлэгийн багш ажилтан, эцэг эх нэг ойлголттой болоход нөлөөлсөн гэж үзэж байна.<br>• Эцэг эхийн хувьд таны хүүхэд эрсдэлгүй, таатай орчинд сурч хөгжихөд таны оролцоо чухал гэдгийг ойлгуулах нь ач холбогдолтой байсан. Хичээлийн жилд эцэг эхийн дунд зохион явуулах ажлыг эцэг эхийн хурал сургалтаас санаа оноог авч тусгах нь хамгийн чухал байв. |
| **Холбоо барих утас, лого** | **Сонгинохайрхан дүүрэг 21 дүгээр хороолол-1, 18 дугаар хороо 79 дүгээр цэцэрлэг Утас: 70171255**<br><br>**Цэцэрлэгийн эрхлэгч Т.Ундармаа** Утас: 99062972<br>Э-шуудан: Undarmaa2972@gmail.com<br>**Цэцэрлэгийн арга зүйч Д.Таяа** Утас: 99297332<br>Э-шуудан: Dtaya0121@gmail.com |

## БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДУЛААЛГЫН АЖЛЫН ЯВЦАД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Дүүрэг: Сонгинохайрхан Байгууллага: 79 дүгээр цэцэрлэг

Огноо: 2020 оны 8 дугаар сарын 11-ны өдөр

| БАРИЛГЫН ЗАСВАРЫН АЖЛЫН ҮЙЛ ЯВЦ ЭХЭЛСНЭЭС ХОЙШ ЦУГЛУУЛАХ МЭДЭЭЛЭЛ | | | |
|---|---|---|---|
| **Шалгуур** | | **Тэмдэглэгээ** | **Тайлбар/дэлгэрэнгүй** |
| 3.1 | Барилгын зураг төсөлд тэмдэглэгдсэн бүх цонх, гадна хаалгыг шинэчлэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | Цонхны дулаалгын ажлыг зурагт заасны дагуу гүйцэтгэж, шаардлагатай цонхнуудаас хэмжээ авч, шинээр суурилуулж байна. Дээвэр хэсгийн 16 цонхноос арын хэсгийн 4 цонхыг авч өрөлт хийж байна. 5 хаалга хийгдэж, дулаалгын хөөс шахагдаж байна. |
| 3.2 | Цонх, хаалганы байрлал түүний ус тусгаарлалт, битүүмжлэлийн үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | • Цонхны рамын өргөн: 72 Давхар шилний тоо: 3<br>• Цонхны хүрээний таславчийн тоо: 5<br>• Үйлдвэрлэсэн байгууллагын нэр: ХААН ЦОНХ ХХК |
| 3.3 | Гадна ханыг иж бүрэн, зохих зузаанаар дулаалах үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ **Ажил эхлэх шатандаа**<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | • Хөөсөнцрийн зузаан.15 см<br>• Нягт:22<br>• Грунт: ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА<br>• Хөөсөнцрийн цавуу: 999<br>• Чулуут замаскийн гарал үүслийн гэрчилгээ: ЭХЛЭЭГҮЙ |
| 3.4 | Дээврийн дулаалгыг иж бүрэн хийх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | Хуулалт хийгдсэн. Бетон зуурмагийн хучилт хийгдэж байна. |
| 3.5 | Цонхны амлагаа болон дотор тавцангууд | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд шатандаа** | Цонхны амлагаа, тавцан хийгдээгүй. Цонхны тавцангийн хэмжээ стандарт бус зөрүүтэй байгааг |

| | | | |
|---|---|---|---|
| | бүрэн хийгдэх үйл явц | ○ Ажил дуусах шатандаа | гүйцэтгэгч компанитай ярилцах |
| 3.6 | Халаалтын системийг зургийн дагуу гүйцэтгэх үйл явц | ○ **Огт тусгагдаагүй**<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 3.7 | Сантехникийн тоноглолууд иж бүрэн, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан эсэх | ○ **Огт тусгагдаагүй**<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 3.8 | Дээвэрт ус нэвтрэхгүй битүүмжлэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | Бетонон зуурмагийн хучилт хийгдэж дуусаад хөрсжүүлэлт хийгдэж байна. |
| 3.9 | Цэвэр, бохир усны шугам шаардлагатай стандартын дагуу хийгдэх үйл явц | ○ **Огт тусгагдаагүй**<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 1. | **Ажиглагдсан зөрчил, дутагдал:**<br>➢ Гүйцэтгэгч компани стандартын шаардлагад нийцэхгүй хөөс буулган, хийх гэж байсныг хэлж залруулан, буцаалт хийлгэж шинжилгээний бичигтэй хөөсөөр хийлгэж байна.<br>➢ Зарим ангийн хуучин цонхны амлагаар дутуу хийсний улмаас цонхны хүрээний өргөн 7 см байх бол 4-5 см болгож хасалт хийсэн нь буцааж авахад хүндрэлтэй, хагарч эмтэрч авагдсан.<br>➢ Аяга угаадаг өрөөний агааржуулалтыг шийдээгүй барилгын зураг төсөлд тусгагдаагүй байсныг удирдах хүмүүс, хяналтын инженертэй ярилцан агааржуулалт хийлгэж байна.<br>➢ Дээврийн засал хийгдэж байх хугацаанд бороо орж, дээврээс ус гоожин дээд доод давхрын ангиуд руу ус гоожиж хана, таазны шохой нурж унасан.<br>➢ Төслийн баг хуралдан гадна аваарын шатыг буулган, аваарын шатыг зурагт заасанаас зай талбай бага эзлэх байдлаар хийх шийдэлд хүрсэн. | | |

| | |
|---|---|
| 2. | **Цаашид анхаарах зүйлс:**<br>➢ Засварын ажил явагдах үед барилгын зураг төсөлд зааснаас зарим зүйл нь цэцэрлэгт стандарт бус байсан тул энэ төслийн хүрээнд дээрх бүх эрх бүхий хүмүүстэй харилцан зөвшилцсөний үндсэн дээр цэцэрлэгийн дээвэр, агааржуулалт, аваарын шат, гадна талбай, дээд 3 ангийн халаагуурт өөрчлөлт оруулан барилгын заслын чанарт анхааран ажиллах<br>➢ Барилгын заслын үед байгалийн хүчин зүйлээс шалтгаалан ажлын бүтээмж муудахаас сэргийлж төлөвлөгөөг маш нарийн гаргаж ажиллах<br>➢ Гүйцэтгэгч байгууллагын барилгын засалд хийж байгаа бараа материалд хяналт тавин ажиллах<br>➢ Барилгын засвар үйлчилгээг аль болох хүүхдэд ээлтэй эрсдэлгүй удаан тогтох чанартай бараа материалаар хийлгэх<br>➢ Цонхны тавцан нь стандартын зөрүүтэй учир аль болох зөрүүг арилгах, харагдах байдлыг үзэмжтэй цэвэрхэн, хүүхдийн осол, аюулгүй байдлыг хангахад анхаарч гүйцэтгэх |
| 3. | **Барилгын их засвар, дулаалгын явцын талаарх ерөнхий дүгнэлт:**<br>2020 оны 8 сарын 11 ны өдрийн байдлаар барилгын их засвар нь стандартын шаардлагад нийцсэн, батлагдсан зураг төслийн дагуу зохион байгуулалт сайтай явагдаж байна. Засварыг материалын чанар стандарт шаардлагад нийцсэн, тохирлын гэрчилгээтэй, лабораторийн шинжилгээний бичигтэй баталгаатай материалаар гүйцэтгэж байна.<br>Барилгын засварын дээвэр дулаалгын ажлын явц нь хуучин дээврээ хуулан авч, бүх хаягдал шороо, хар цаасыг зөөн ачуулж зурагт тусгагдсаны дагуу дээврийн ажил явагдаж байна. Цонхны дулаалгын ажил зурагт заасны дагуу шаардлагатай цонхнуудыг авч шинээр цонх суурилуулж хуучин цонхоо өмч хариуцах газар хүлээлгэн өгөхөд бэлэн болголоо. Барилгын суурь хормой хэсгээр ухан авч, дулаалгын үйл ажиллагааг стандартын дагуу хийж гүйцэтгэж байна. Дээд давхрын аваарын гарцыг зураг төсөлд заасны дагуу өргөтгөл болгон ашиглах зориулалтаар 3 ангид өргөтгөл хийгдэж өрж дууссан байна.<br>Цонх бүрэн солигдсон боловч цонхны амлагаа, тавцан суугдаагүй 40%<br>Хаалга солих үйл явц 30%<br>Суурийн дулаалга 60%<br>Дээврийн дулаалга 50%<br>Ханын дулаалга 15 %<br>Нийт засварын ажлын гүйцэтгэл 40%-тай явагдаж байна. |
| **Ажиглалт хийсэн хүний нэр, холбоо барих хаяг, утас** | |
| Сонгинохайрхан дүүргийн 79-р цэцэрлэгийн дэмжих багийн ахлагч Д.Таяа<br>Утас: 99297332 | |

## ЗӨВШИЛЦЛИЙН ХУУДАС

*Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 79 дүгээр цэцэрлэгийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа БАКО КОНСТРАКШН ХХК нь “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төслийн хүрээнд зохион байгуулалтад орсон “Дэмжих баг”-ийн гишүүдийн барилгын засвар, дулаалгын ажлын явцад хийсэн эцэг эхийн оролцоот, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, санал дүгнэлттэй танилцлаа.*

Дэмжих багийн гишүүдийн тайланд туссан дараах зүйлсийг гүйцэтгэгч их засвар, дулаалгын явцад тусгаж ажиллахаа талууд харилцан зөвшилцлөө.

**Гүйцэтгэгч компанийн зүгээс**:

- Дээврийн засал хийгдэж байх хугацаанд бороо орж, дээврээс ус гоожин дээд доод давхрын ангиуд руу ус гоожиж хана,
  таазны шохой нурж гүйцэтгэгч байгууллагын буруугаас болсон тул харилцан ойлголцож тодорхой хэмжээний засвар хийх
- Төслийн баг зөвшилцөн гадна аваарын шатыг буулган янзалж аваарын шатыг зурагт зааснаас зай талбай бага эзлэхээр хийх
- Дээврийн агааржуулалтын яндан хоолой нурж тагларсан байгааг цэвэрлэж засах
- Цонхны тавцан суулгалтыг хүүхдийн осол аюулгүй байдлыг харгалзан стандарт зөрүүг арилган, харагдах байдлыг цэвэрхэн хийх
- Аяга угаадаг өрөөний агааржуулалт шийдээгүй зурагт заагаагүй байсныг засаж агааржуулалт хийх
- Дээд давхрын аваарын гарцыг зураг төсөлд заасны дагуу өргөтгөл болгон ашиглах зориулалтаар 3 ангийн өргөтгөл хийх
- Бако Констракшн ХХК нь өөрийн хөрөнгөөр барилгын хог хаягдлыг ачиж, цэвэрлэх

**Цэцэрлэгийн зүгээс**:

- Засварын батлагдсан зурагт өөрчлөлт оруулах саналыг зургийн компанид албан тоот хүргүүлж саналаа өгөх Үүнд: гадна аваарын шат, дээд давхрын 3 ангийн өргөтгөл, дээд давхрын гэгээвчийн засал гэх мэт.
- Анги бүлгийн цонхны тавцан, амлагаар хийхэд саад болзошгүй хананд тогтоогдсон тавиурыг авч чөлөөлөх
- Дэмжих багийн гишүүд хуваарийн дагуу хяналт тавьж ажиллах

| Дэмжих багийн ахлагч | Хяналтын инженер | Компанийн захирал |
|---|---|---|
| Д.Таяа | Б.Баясгалан | Б.Баатархүү |

## ЗӨВШИЛЦЛИЙН ХУУДАСНЫ БИЕЛЭЛТ БУЮУ ДҮГНЭХ ХУУДАС

*Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 79 дүгээр цэцэрлэгийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа БАКО КОНСТРАКШН ХХК болон "Дэмжих баг"-ийн гишүүдийн харилцан зөвшилцсөн ажил үйлчилгээ нь дор дурдсан байдлаар биелэгдсэн байна.*

| Харилцагч талууд | Д/д | Зөвшилцсөн ажлууд | Ажлын биелэлт |
|---|---|---|---|
| Гүйцэтгэгч компанийн зүгээс | 1 | Дээврийн засал хийгдэж байх хугацаанд бороо орж, дээврээс ус гоожин дээд доод давхрын ангиуд руу ус гоожиж хана,таазны шохой нурж гүйцэтгэгч байгууллагын буруугаас болсон тул зөвшилцлийн хуудсаар дамжуулан тодорхой хэмжээний засвар хийх. | Дээд, доод давхрын анги танхим, өрөө тасалгаа коридорын хана, таазны шохойг хусаж цэвэрлэн замаск, эмульс хийж гүйцэтгэсэн боловч зарим ангийн тааз бүрэн гүйцэт хатаагүй ус нэвтэрсэн шарласан байдал арилаагүй байна.<br><br>Гүйцэтгэл 80% |
| | 2 | Төслийн баг зөвшилцөн гадна аваарын шатыг буулган янзалж, аваарын шатыг зурагт зааснаас зай талбай бага эзлэхээр шийдэх | Төслийн баг зөвшилцөн гадна аваарын шатыг буулган янзалж аваарын шатыг зурагт зааснаас зай талбай бага эзлэхээр шийдэн гүйцэтгэв.<br>Гүйцэтгэл: 100% |
| | 3 | Дээврийн агааржуулалтын яндан хоолой нурж, тагларсан байгааг цэвэрлэж, засах | Дээврийн дулаалгын засварын ажил явагдах үед агааржуулалтын яндан хоолой нурж, тагларсан байсныг тоосгоор дахин өрж, янзлан цэвэрлэсэн.<br>Гүйцэтгэл: 100% |
| | 4 | Цонхны тавцан суулгалтыг хүүхдийн осол аюулгүй байдлыг харгалзан, стандарт зөрүүг арилган харагдах байдлыг цэвэрхэн хийх | Цонхыг суулгахдаа зөрүүг арилган харагдах байдлыг үзэмжтэй цэвэрхэн суулгасан. Цонхны тавцан хийгдээгүй байна.<br><br>Гүйцэтгэл: 90% |
| | 5 | Аяга угаадаг өрөө агааржуулалт шийдээгүй | Аяга угаадаг өрөөний агааржуулалт шийдээгүй зурагт заагаагүй байсныг |

| | | | |
|---|---|---|---|
| | | зурагт заагаагүй байсныг засах агааржуулалт хийх | зөвшилцлийн хуудсаар дамжуулан, агааржуулалт гаргуулсан. Гүйцэтгэл: 100% |
| | 6 | Дээд давхрын аваарын гарцыг зураг төсөлд заасны дагуу өргөтгөл болгон ашиглах зориулалтаар 3 ангийн өргөтгөл хийх | Дээд давхрын аваарын гарцыг зураг төсөлд заасны дагуу өргөтгөл болгон ашиглах зориулалтаар 3 ангид өргөтгөл хийгдэж, ангийн ашигтай талбайг нэмэгдүүлсэн. Гүйцэтгэл: 100% |
| | 7 | Бако Констракшн ХХК нь өөрийн хөрөнгөөр барилгын хог хаягдлыг ачиж, цэвэрлэх | Бако Констракшн ХХК нь өөрийн хөрөнгөөр барилгын хог хаягдлыг ачиж, цэвэрлэсэн. Гүйцэтгэл: 100% |
| Цэцэрлэгийн зүгээс | 8 | Засварын батлагдсан зурагт өөрчлөлт оруулах саналыг зургийн компанид албан тоот хүргүүлж саналаа өгөх | Засварын батлагдсан зурагт өөрчлөлт оруулах саналыг зургийн компанид албан тоот хүргүүлж ажилласан. Гүйцэтгэл: 100% |
| | 9 | Анги бүлгийн цонхны тавцан, амлагаар хийхэд саад болзошгүй хананд тогтоогдсон тавиурыг авч чөлөөлөх | Анги бүлгийн цонхны тавцан, амлагаар хийхэд саад болж болзошгүй хананд тогтоогдсон тавиурыг авч чөлөөлсөн. Гүйцэтгэл: 100% |
| | 10 | Дэмжих багийн гишүүд хуваарийн дагуу хяналт тавьж ажиллах | Дэмжих багийн гишүүд хуваарийн дагуу хяналт тавьж ажилласан. Гүйцэтгэл: 100% |
| **Дүгнэлт:** | | | |
| Барилгын гүйцэтгэгч “*БАКО КОНСТРАКШН*” ХХК-тай дэмжих багийн гишүүдийн харилцан зөвшилцсөн 10 ажлаас 8 ажил бүрэн 100% биелж, 2 ажлын нэг нь 90% биелэлттэй, нөгөө нь 80%-тай байна. | | | |
| **Биелэлтийг дүгнэсэн хүний нэр, холбоо барих хаяг, утас:** | | | |
| Дэмжих багийн ахлагч Д.Таяа. Утас: 99297332 | | | |

# ЗУРГИЙН ЦОМОГ















# НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 80 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ



## БИДНИЙ ТУХАЙ

Нийслэлийн 80 дугаар цэцэрлэг 1986 онд байгуулагдсан, Сонгинохайрхан дүүргийн 3 дугаар хороонд байрладаг. 16 бүлэг, 66 багш, ажилтантай хамран сургах тойргийн 2-5 насны 560 гаруй хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг үзүүлж байна. Манай цэцэрлэг мэргэжлийн боловсон хүчнээр 100 хувь хангагдсан, 2 тэргүүлэх, 10 заах аргач мэргэжлийн зэрэгтэй багштай.

## БИДНИЙ АМЖИЛТ

Улаанбаатар хотын захирагчийн албанаас зохион байгуулсан Нийслэлийн 381 жилийн ойг угтсан “Манай хороо-Миний гудамж” аяны хүрээнд орчны тохижилт, ногоон байгууламж, соёлжилтыг сайжруулах чиглэлээр шинэлэг ажлуудыг зохион байгуулж, хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлсэн тул “Тусгай байр” өргөмжлөл, нэг сая төгрөгөөр шагнагдсан.

## “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөл манай цэцэрлэгт



**Б.Ганцэцэг (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 80 дугаар цэцэрлэгийн эрхлэгч):**

Манай цэцэрлэгийн барилгын их засвар, дулаалгын ажлыг “Сайрын харгана” ХХК гүйцэтгэж гадна фасадын дулаалга, цахилгаан, бохирын шугам, худаг шинэчлэх, 106 цонх, 19 хаалга солих, дээврийг сэндвичээр дулаалахад 650 сая төгрөг, гал тогооны иж бүрэн засвар, нийтийн эзэмшлийн талбайн засварын ажлыг 46 сая төгрөгийн санхүүжилтээр тус тус хийж гүйцэтгэлээ. Бага насны хүүхдийн сурч боловсрох таатай орчин бүрдүүлэхэд багш, ажилчид, эцэг эхийн үүрэг, оролцоо маш чухал болох нь төслийн хүрээнд хийгдэж байгаа ажлуудаас тодорхой харагдлаа. Цаашид цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хэрэгжүүлэхээр эрх зүйн баримт бичгээ боловсруулан ажиллаж байна.




**Г.Цэрмаа (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 80 дугаар цэцэрлэгийн арга зүйч):**

Бид төслийн хүрээнд эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх аргад суралцаж, хамтран ажиллах арга барил эзэмшлээ. Энэхүү эзэмшсэн арга барилдаа тулгуурлан цэцэрлэгийнхээ гадна талбайн “Эко ногоон байгууламж”-ийн тохижилтыг хийлээ. Энэ бүтээн байгуулалтын зорилго нь бага насны хүүхдийг байгаль орчинтойгоо байнга харьцаж, нийгэм, хүмүүсийн амьдрал, юмс үзэгдлийн шинжийн энгийн холбоо хамаарлыг таних ухаарахад хүүхдийн ажигч чанар, анхаарал, сонирхол, жиших, ялгах, харьцуулах, ангилах, бүлэглэх чадварыг хөгжүүлж, тэдний дараагийн шатны суралцах үйл ажиллагаанд эрэмбэ дараатай бэлтгэх, бодол санаагаа цэгцтэй илэрхийлж сурахад нь туслах юм. Цаашид “Дэмжих баг”-ийн гишүүдийн оролцоог улам өргөжүүлж ногоон байгууламжаа 50 хүртэл хувьд хүргэх төлөвлөгөө боловсруулан, ажиллаж байна.



**С.Мөнхцэцэг (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 80 дугаар цэцэрлэгийн нярав)**: Манай цэцэрлэгийн бүх цонхны гадна тал амлагаа байхгүй, ус зайлуулах хоолой байхгүй утаа, шороо их орж ирдэг маш хүйтэн, тав тух муутай үүнээс шалтгаалаад хүүхдийн өвчлөл ихтэй байсан. Одоо цэцэрлэг маань маш дулаахан өнгө үзэмжтэй болсон.

**Ж.Энх-Отгон (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 80 дугаар цэцэрлэгийн багш)**: Төслийн хүрээнд “Дэмжих баг” байгуулагдаж эцэг эх, багш, ажилчид хамтдаа хүүхдийн суралцах орчин түүний нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагын талаар ярилцаж, хамтран ажиллав. Барилгын дулаалга, их засварын ажил стандартын дагуу хийгдсэн гэж бодож байна. Хөөсөн фасад зузаан, цонх нь таван таславч, гурван давхар шилтэй орчин үеийн стандартын дагуу хийгдсэн.





**Л.Даваацэрэн (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 80 дугаар цэцэрлэгийн сантехникч)**: Манай цэцэрлэг 35 жил бохирын болон цэвэр усны шугамаа шинэчлээгүй, худаг нурж, бөглөрсөн байсан. Төслийн хүрээнд цэвэр усны шугамыг 12 метр ган хоолойгоор, бохирын шугамыг 100 метрийн PC хоолойгоор шинэчилж, 1 худгийг шинээр барьсан нь сантехникийн эд ангийн насжилтыг нэмэгдүүлсэн гэж бодож байна.



**С.Гончиг (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 80 дугаар цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл)**:

Төсөл хэрэгжихээс өмнө манай хүүгийн анги өвөлдөө маш хүйтэн тав тух муутай, зузаан хувцастай цэцэрлэгтээ ирдэг байсан. Төсөл хэрэгжсэнээр манай хүүхдийн ангийн бусад хүүхдүүдийн дунд өвчлөл буурч, ирц нэмэгдэж, багш, ажилчдын хувьд ажиллах тав тухтай орчин бүрдсэн. Цаашид багш, эцэг эхийн хамтын ажиллагаа улам сайжирна гэдэгт итгэлтэй байна.

## ЦЭЦЭРЛЭГИЙН НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГААГ НЭМЭГДҮҮЛЭХ

| | |
|---|---|
| **Зорилго** | Дэмжих багийн гишүүдийн оролцоотой бага насны хүүхдийг сургаж хөгжүүлэх экологи танин мэдэхүйн орчин бүрдүүлэх |
| **Нөхцөл байдал, тулгамдсан асуудал** | Манай цэцэрлэгийн ногоон байгууламжийн талбай том ч, тохижилт муутай, сул шороо тоосжилт ихтэй, бага насны хүүхдийн хэрэгцээнд нийцсэн бодит суралцах орчин байхгүй байсан нь хүүхдийн танин мэдэхүйг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг бодит орчинд зохион байгуулах боломжгүй байв. |
| **Зорилтот бүлэг** | 2-5 насны 560 хүүхэд, 66 багш, ажилтан, 1200 орчим эцэг эх, асран хамгаалагч |
| **Шалгуур үзүүлэлт** | • Тохижуулсан ногоон байгууламжийн талбай нэмэгдсэн $м^2$ тоо хэмжээ<br>• Хүлэмжийн суурилуулалт аюулгүй, хөдөлгөөнгүй болж 2-3 бэхэлгээтэй болсон байх<br>• Хүүхдийн танин мэдэхүйг хөгжүүлэх зорилгоор тарьсан хүнсний ногоо, цэцэг, зүлэг, модны нэмэгдсэн тоо хэмжээ<br>• Туршилтын талбайд зорчих зам талбайг нэмэгдүүлсэн хэмжээ (хэмжих нэгж метр)<br>• Туршилтын талбайг хамгаалсан, заагласан хашлага хайс хийсэн байдал (хэмжих нэгж тоогоор)<br>• Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд оролцсон эцэг эхийн тоо, хувиар |

| | |
|---|---|
| **Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат** | • Эцэг эх, багш, ажилчдын төлөөллөөс бүрдсэн дэмжих багийг цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар байгуулсан.<br>• "Дэмжих баг"-ийн гишүүдэд "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин MNS 655852015 стандарт, "Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний алхам" сэдвийн хүрээнд хичээл зааж, зөвлөмж, чиглүүлэг өгсөн.<br>• "Дэмжих баг"-ийн гишүүд эзэмшсэн мэдлэг мэдээлэлдээ тулгуурлан цаашид хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулсан.<br>• "Дэмжих баг"-ийн гишүүд цэцэрлэгийн гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг үнэлэх хяналтын хуудсандаа тохируулга хийж ,хамтран боловсруулсан.<br>• "Дэмжих баг"-ийн гишүүд цэцэрлэгийн гадаад, дотоод орчны бодит байдалтай танилцан, сургалтын орчинд тавигдах стандарт шаардлагатай харьцуулах байдлаар хяналт- шинжилгээ, үнэлгээ хийсэн.<br>• "Дэмжих баг"-ийн гишүүд хамтран эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмжийг боловсруулав.<br>• Дэмжих багийн гишүүдийн саналаар "Цэцэрлэгийн туршилт танин мэдэхүйн талбайг зүлэгжүүлэн нарийн ногоо, хүнсний ногоо тариалах туршилтын талбай"-г байгуулахаар шийдвэрлэсэн.<br>• Туршилтын талбайн мод ургамалд хүүхдийн танин мэдэхүйг хөгжүүлэх зорилгоор хаягжилт хийлээ.<br>• Туршилтын талбайд 2 портер элс, хар шороо асган хөрс бэлдэн, таван төрлийн хүнсний ногоо, дөрвөн төрлийн цэцэг тарьж, 200 м$^2$ талбайг зүлэгжүүлэн, хүлэмждээ 18 кг өргөст хэмх тарьсан. 80ш банзаар 3 метрийн урттай вагон ачааны машин хийснээс гадна 8 ширхэг булангийн хайс хийлээ. |
| **Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)** | • Дэмжих баг, багш, ажилчдын оролцоотой гадаад талбай, ногоон байгууламжийн орчин нөхцөлийг сайжруулж, хүүхдүүдийг бага наснаасаа байгаль орчны юмс үзэгдлийг сонирхон ажиглах, танин мэдэх, ургамал ургуулах бодит орчныг бий болгосон.<br>• Хүнсний ногоо 5 төрөл, мод 30 ширхгийг шинээр тарив.<br>• Хүлэмжээсээ 18 кг өргөст хэмх хурааж авсан. |

| | |
|---|---|
| | • Хүнсний ногоо болон модыг хаягжуулснаар эцэг эх болон хүүхдүүдэд ургамал ногоог танин мэдэх, сонирхон судлах байдал нэмэгдсэн.<br>• Хүүхэд бодит орчинд биечлэн мод ургамал тарих, хөдөлмөрийн үр шимийг мэдрэх, хөдөлмөрийг хүндэтгэх үзэлд суралцахад ахиц гарсан үр дүнтэй ажил болсон.<br>• Нийт ногоон байгууламжийг өмнөх үетэй харьцуулахад 20 хувиар нэмэгдүүлсэн.<br>• Цэцгийн мандлууд бий болгосноор цэцэрлэгийн гадаад орчны өнгө үзэмж эрс сайжирсан. 36 $м^2$ талбайд зургаан төрлийн хүнсний ногоо суулгаж нийт, 38 кг ногоо хурааж авсан.<br>• 200 $м^2$ талбайд ерхөг согоояврын үр суулган, зүлэгжилт хийж, 30 ширхэг шар хуайс тарьсан. 150 $м^2$ талбайг цэцгийн мандлаар тохижуулав. 24 $м^2$ талбайд өргөс хэмхийн үрсэлгээ хийж, 18 кг ургац авсан.<br>• 280 м урттай явган хүний замыг цэцгийн мандал, туршилтын талбайн зай хооронд тавьсан. |
| **Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд** | • Цэцэрлэгт мөрдөгдөж буй дүрэм, журамд эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байх зүйл, заалтыг нэмж оруулсан.<br>• Хичээлийн жилийн төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, үр дүнг бодитоор тооцон ажиллахад дэмжих баг, олон нийтийн оролцоог хангаан хамтран ажилласан.<br>**Үүнд:**<br>• Цэцэрлэг, багш, эцэг эх асран хамгаалагчийн хооронд байгуулсан гурвалсан гэрээнд нэмэлт өөрчлөлтүүд оруулсан.<br>• Дотоод хяналт шалгалт хийх журамд нэмэлт өөрчлөлтийг тусгасан. |
| **Тулгарсан бэрхшээл эрсдэл:** | • Цаг агаарын нөхцөл байдлаас хамааран ажил зогсох, байгалийн давагдашгүй зарим хүчин зүйл төлөвлөсөн ажлыг цаг хугацаанд нь дуусгахад бэрхшээл учруулсан.<br>• Өндөржүүлсэн бэлэн байдалтай холбогдуулан багш нар бүлгийнхээ эцэг эхчүүдтэй биеэр уулзах боломжгүй учраас хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүнг нийт 16 бүлгийн фейсбүүк группээр дамжуулан цахим зөвлөмж уриалгыг бэлтгэн |

| | |
|---|---|
| | ажилласан учир нөлөөллийн ажлын үр дүнг тооцоход хүндрэлтэй байв.<br>• Ковид-19 цар тахлын улмаас хүмүүсийг олноор цуглуулж, мэдээлэл дамжуулахад бэрхшээлтэй байсан.<br>• Багш, ажилтан, эцэг эхчүүдийн хувьд бага насны хүүхдэд зориулсан ногоон байгууламж, туршилт танин мэдэхүйн талбай ямар байх талаарх ойлголт дутмаг байсан. |
| **Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс** | • Цэцэрлэгийн удирдлагын зүгээс дотоод журам, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт зэрэг бичиг баримт боловсруулах ажилд зөвлөн тусалж, заавар зөвлөгөө өгсөн. Мөн хийгдэж байгаа ажлуудад байнга чиглүүлэг өгч, эцэг эх, дэмжих багийн гишүүдтэй хамтран шийдлийг эрэлхийлж, шийдвэр гарган ажилласан нь үр дүнг нэмэгдүүлэх гол хөшүүрэг болж чадсан.<br>• Багш нар эцэг эхчүүдэд зориулан цэцэрлэгийн орчинд хүүхдүүдийг эрсдэлээс сэргийлэх, хүүхэд хамгааллын цахим хичээл бэлтгэн фейсбүүк хуудсаар дамжуулан заасан нь эцэг эх, асран хамгаалагчдаас авах дэмжлэг туслалцааг илүү үр дүнтэй болгож чадсан.<br>• Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг фейсбүүк хуудсанд байршуулан, эцэг эхийг уриалан өөрсдийн үйл ажиллагаандаа татан оролцуулж чадсан.<br>• Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг байгууллагын ажилчдад танилцуулан, дотоод нөөц бололцоог ашиглан ажиллаж төлөвлөсөн ажлаа цаг хугацаанд нь дуусгаж чадсан.<br>• Мужаан мэргэжилтэй эцэг эхийн судалгааг гарган, тэднээс ажил мэргэжлийн туслалцааг авч, багаар хамтран ажиллаж амжилтад хүрсэн. |
| **Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс** | • Дэмжих багийн гишүүдээс гадна багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдыг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, хэлэлцүүлэг зохион байгуулах нь үр дүнтэй юм.<br>• Бусад цэцэрлэгийн ололт амжилт, тулгамдсан асуудлаа хэрхэн шийдэж байсан туршлагаас суралцаж, байнгын мэдээллээ солилцож ажиллавал цаг хугацаа хэмнэсэн, үр дүнтэй зохицуулалт болж байсан. |

| | |
|---|---|
| **Холбоо барих хаяг Лого** | **Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 3 дугаар хороо**<br>**80 дугаар цэцэрлэг**<br>Эрхлэгч: Ганцэцэг, утас : 70182396, 99043829<br>э-майл: bgantsetseg_11@yahoo.com<br>Арга зүйч: Г.Цэрмаа, утас: 89038050<br>э-майл: tsermaa.bagsh80@gmail.com |

## БАРИЛГЫН ДУЛААЛГА, ИХ ЗАСВАРЫН ТӨГСГӨЛИЙН ШАТАНД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУРШЛАГА

| | |
|---|---|
| **Зорилго** | Цэцэрлэгийн их засвар үйлчилгээ, дулаалгын явцад эцэг эх оролцоот хөндлөнгийн хяналт тавьж, тохилог орчин бүрдүүлэхэд хамтран ажиллах |
| **Нөхцөл байдал, тулгамдсан асуудал** | • Цэцэрлэг байгуулагдаад 34 жил болсон. Ашиглалтад орсноос барилгын дээвэрт огт засвар хийгдээгүй, дээврийн хар цаас хуучирч муудсан учир борооны ус гоождог.<br>• Барилгын ханын дулаалга муудсан, цонх хаалга стандартын дагуу суурилагдаагүй цанталт, дулаан алдагдал ихтэй.<br>• Зарим ангиудын булан тохойд мөөгөнцөр үүссэн, 34 жилийн хугацаанд цахилгааны сүлжээг засаагүй, бохирын худаг нурсан байсан.<br>• Дээврийн эргэн тойрны ханын тоосго нурж эмтэрсэн. Цэцэрлэгийн баруун, зүүн талын блок хэсэгт дээврийн усны хаялга төмөр огт байхгүй. Дээврийн 21 агааржуулалтын нүхнээс 2 ширхэг нь дунд зэргийн түвшинд нурсан, 19 нь огт ашиглагдахааргүй нурсан, малгай төмөр байхгүй, усны хаялгын нүх битүүрсэн байсан.<br>• Үүнээс болж 2 давхрын ангиудын дээврээс ус байнга гоождог. Ус нэвчин дээврийн шохой унах асуудал үүссэн байсан. Ангид засварын ажил хийгээд ч үр дүн гардаггүй байв. |
| **Зорилтот бүлэг** | 2-5 насны 560 хүүхэд, 1200 эцэг эх, асран хамгаалагч, 66 багш, ажилтан |
| **Шалгуур үзүүлэлт** | • Эцэг эх, багш, ажилтнаас бүрдсэн “Дэмжих баг”-ийг байгуулж цэцэрлэгийн засвар болон бусад ажилд эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо |

| | |
|---|---|
| | • Цэцэрлэгийн гадна хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан налуу замыг хийсэн эсэх<br>• Цэцэрлэгийн гадна талд гэрэлтүүлэг болон камер суурилуулсан тоо<br>• Ашиглагдаагүй талбайг ашиглан өрөө тасалгааг нэмэгдүүлсэн хэмжээ<br>• "Дэмжих баг"-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал, өмнөх болон дараа үеийн орчин нөхцөлийг харьцуулсан байдал<br>• Барилгын дулаалгын их засварт хяналт тавьж ажилласан байдалд өгсөн үнэлгээ |
| **Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат** | • Дэмжих багийн гишүүд хамтран уулзалт зохион байгуулж төгсгөлийн шатанд хийгдэх эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний хуудсыг боловсруулсан.<br>• Дэмжих багийн гишүүн бүр төгсгөлийн шатны хяналтын хуудас ашиглан эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн.<br>• Дэмжих багийн гишүүд хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг боловсруулан санал дүгнэлтийг гаргасан.<br>• Төгсгөлийн шатны хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүндээ тулгуурлан зөвшилцлийн хуудас боловсруулан, харилцан баталгаажуулав.<br>• Зөвшилцлийн хуудаст дурдсан ажлууд хэрхэн биелснийг хянаж, дүгнэх хуудас боловсруулан, дараагийн шатанд хамтран ажиллах чиглэлээ харилцан тохиролцсон. |
| **Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)** | 2020-2021 оны хичээлийн жилд манай цэцэрлэг "Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь" төсөлд хамрагдан, барилгын их засвар, дулаалгын ажил хийгдсэн нь цэцэрлэг байгуулагдсанаас хойш хийгдсэн хамгийн том хөрөнгө оруулалт байлаа. Их засварын ажлыг гүйцэтгэгч компани "Сайрын харгана компани нь гадна фасад, дээвэр, аваарын хаалга шат, цонх, цахилгааны их засвар, сантехникийн хэсэгчилсэн засварын (худаг шинэчлэх) ажлыг 650 сая төгрөгийн өртгөөр 100 хувь хийж дуусгалаа.<br><br>**Үүнд:**<br>• 109 цонх 5 таславчтай гурван давхар вакум цонхоор шинэчлэгдсэн. |

<table>
<tr><td></td><td>
<ul>
<li>17 хаалгыг стандартын төмөр хаалгаар шинэчилсэн.</li>
<li>Гадна дулаалгын фасадыг 80 нягт, 15 см зузаантай хөөсөнцрөөр дулаалж чулуун замаскаар өнгөлсөн.</li>
<li>Дээврийг сэндвичин хавтангаар 100 хувь шинэчилсэн.</li>
<li>Долоон аваарын шатыг стандартын дагуу хийсэн.</li>
<li>Цахилгааны шийтийг сольж, газардуулга, аянга зайлуулагчийг шинээр хийсэн.</li>
<li>Цэвэр усны шугамыг 100 метр ган хоолойгоор, бохирын шугамын 70 метрийг PC хоолойгоор шинэчилж, 1 худгийг шинээр барьсан.</li>
</ul>
46 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтээр нийтийн эзэмшлийн талбайн дотор заслыг 100 хувь хийж гүйцэтгэлээ.
<ul>
<li>Цэцэрлэгийн орчны талаарх эцэг эхийн сэтгэл ханамж өмнөх мөн үетэй харьцуулахад 100 хувь болж нэмэгдсэн.</li>
<li>Аваарын хаалга, цонхоор дулаан алдах байдал бүрэн зогссон.</li>
<li>80 $м^2$ ашиглагдаагүй талбайг ашигтай талбай болгон өргөтгөсөн.</li>
</ul>
Үүнд:
<ul>
<li>Цагаан хэрэглэлийн өрөө - $20м^2$</li>
<li>Хүнсний агуулах - $22м^2$</li>
<li>Урлаг заалны хувцасны өрөөг - $20м^2$</li>
<li>Аяга таваг угаах өрөө - $18м^2$ болж тус тус нэмэгдсэн.</li>
</ul>
</td></tr>
<tr><td>Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд</td><td>
Дотоод журам болон дотоод хяналт, бусад баримт бичигт нэмэлт зүйл, заалт оруулж өөрчилсөн.
<ul>
<li>Дотоод хяналтын 1.4-т “Нэгдүгээр улиралд сургалт, эрүүл ахуй, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх”</li>
<li>Дотоод журмын 5.6-д “дэмжих баг” цэцэрлэгийн гадна ба дотор орчинд жилд хоёр удаа хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх зохицуулалтыг цэцэрлэгийн дүрэм журамд тусгасан.</li>
</ul>
Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээгээр цэцэрлэгийн материаллаг орчныг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн.
<ul>
<li>16 бүлэг бүр ангидаа дэмжих баг байгуулж, эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн.</li>
</ul>
</td></tr>
</table>

| | |
|---|---|
| | Ингэснээр ангиудад иж бүрэн дотор засварын ажлууд амжилттай хийгдсэн.<br>• Хүүхдэд ээлтэй сургалтын орчныг бүрдүүлсэн нь багш ажилтнуудад урам зориг өгч сэдэлжүүлсэн. |
| **Тулгарсан бэрхшээл эрсдэл:** | • Барилгын ажиллах хүч, хөрөнгө оруулалт саатсан зэрэг шалтгаанаар засварын ажил удааширч, хугацаандаа ажлаа дуусган хүлээлгэж өгөөгүй.<br>• Зураг төслийг нарийвчилж гаргаагүйгээс дээврийн ажилд асуудал үүссэн. Зураг төслийн архитектур дээврийн зургийг дахин төлөвлөж, төслийн хяналтын инженер, барилгын компанийн инженертэй харилцан ярилцаж шийдвэрлэсэн.<br>• Нийслэлийн Боловсролын Газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын албанаас ирүүлж байгаа зөвлөмж, чиглэлүүд хоорондын уялдаа холбоогүйн улмаас биелүүлэн ажиллахад хүндрэл үүсэж байсан. |
| **Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс** | • Арга зүйн зөвлөмж “дэмжих баг”-ийн гишүүдэд гол гарын авлага, үндсэн чиглүүлэг болсон.<br>• Эцэг эх, багш, ажилчид багаар ажиллах чадвартай болсон нь манай ажилд ихээхэн дэмжлэг үзүүлэв.<br>• Цэцэрлэгт тулгамдаж буй асуудлыг зөвхөн удирдлага, багш нарын хүлээх хариуцлага гэж үзэхгүйгээр эцэг эхийн шууд оролцоог сайжруулах, төрийн байгууллага, ТББ-тай хамтран ажиллавал илүү үр дүнтэй. |
| **Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс** | • Барилгын их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа компани анхнаасаа цэцэрлэгтээ харилцан тохиролцож, нягт холбоотой ажиллах хэрэгтэй.<br>• Гүйцэтгэгч компани ажлын төлөвлөлт, хийх ажлыг тодорхой цаг хугацаанд оновчтой товлон багш, ажилтан, эцэг эхэд нээлттэй байдлаар мэдээлэх нь зүйтэй.<br>• Эцэг эх, асран хамгаалагчдын оролцоот, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх ойлголтыг цэцэрлэгийн нийт эцэг эхэд сурталчлан таниулах<br>• Эцэг эхчүүдийг хувь хүний идэвх, оролцоо, мэргэжил, цаг барьдаг эсэх, хувийн зохион байгуулалт зэргийг харгалзан сонгохоос гадна тэдний хүсэл сонирхлыг харгалзан сонгогдох нь хамгийн зөв шийдэл болно. |

| | |
|---|---|
| **Холбоо барих хаяг** | **Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 3 дугаар хороо 65-р сургуулийн ард 80 дугаар цэцэрлэг, утас: 70182396**<br>Эрхлэгч: Б.Ганцэцэг, утас: 99043829, bgantsetseg_11@yahoo.com<br>Арга зүйч: Г.Цэрмаа, утас: 89038050, tsermaa.bagsh80@gmail.com |

## БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДУЛААЛГЫН АЖЛЫН ТӨГСГӨЛД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Дүүрэг: Сонгинохайрхан Байгууллага: 80 дугаар цэцэрлэг

Огноо: 2020 оны 9 дугаар сарын 18-ны өдөр

| **БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДУЛААЛГЫН АЖЛЫН ТӨСГӨЛД ХИЙХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ** | | |
|---|---|---|
| **Шалгуур** | **Тэмдэглэгээ** | **Тайлбар/яагаад гэдэгт хариулна.** |
| Барилгын зураг төсөлд тусгагдсан бүх цонх, гадна хаалгыг шинэчлэх үйл явц | Маш муу – 1<br>Муу - 2<br>Дунд - 3<br>**Сайн - 4**<br>Маш сайн - 5 | Монгол Улсын барилгын салбарт мөрдөж буй стандарт “Хаан цонх” ХХК-ийн цонхыг зургийн дагуу бүрэн хийгдсэн. Цонхны амлагаа стандартын дагуу маш нямбай хийгдсэн. “Өнгөт төмөр” ХХК “Супер ган хаалга” ХХК-аас 17-н аваарын хаалгыг шинэчилсэн. |
| Цонх хаалганы байрлал түүний ус тусгаарлалт битүүмжлэлийн үйл явц | Маш муу – 1<br>Муу - 2<br>Дунд - 3<br>**Сайн - 4**<br>Маш сайн - 5 | Цонх хаалганы тохиргоо хийгдсэн. |
| Гадна ханыг иж бүрэн, зохих дулаалгын зузаанаар дулаалах үйл явц | Маш муу – 1<br>Муу - 2<br>Дунд - 3<br>**Сайн - 4**<br>Маш сайн - 5 | Стандартын дагуу хяналтын инженерийн хяналт, зааварчилгааны дагуу гүйцэтгэгдсэн. |
| Дээврийн дулаалгыг иж бүрэн хийх үйл явц | Маш муу – 1<br>Муу - 2<br>Дунд - 3<br>**Сайн - 4** | Дээврийг сэндвичин хавтангаар зураг төслийн дагуу чанартай хийж гүйцэтгэсэн. |

| | | |
|---|---|---|
| | Маш сайн - 5 | |
| Цонхны амлагаа болон дотор тавцангууд бүрэн хийгдэх үйл явц | Маш муу – 1<br>Муу - 2<br>Дунд - 3<br>Сайн - 4<br>**Маш сайн - 5** | Анги, өрөө болгоны цонхны амлагаа бүрэн хийгдсэн. Анги танхим, өрөө тасалгааны цонхны тавцан чулуун тавцангаар сольж хийсэн. |
| Сантехникийн тоноглолууд иж бүрэн байх, хүүхдийн хэрэгцээнд нийцүүлэх үйл явц | Маш муу – 1<br>Муу - 2<br>Дунд - 3<br>Сайн - 4<br>Маш сайн - 5 | Огт хийгдээгүй (Зураг төсөлд тусгагдаагүй) |
| Дээвэрт ус нэвтрэхээргүй битүүмжлэх үйл явц | Маш муу – 1<br>Муу - 2<br>Дунд - 3<br>**Сайн - 4**<br>Маш сайн - 5 | Ус нэвтэрч гоожихоос сэргийлж стандартын дагуу сэндвичин хавтангаар дээвэрлэсэн. |
| Цэвэр бохир усны шугам зураг төслийн дагуу хийгдэх үйл явц | Маш муу – 1<br>Муу - 2<br>Дунд - 3<br>Сайн - 4<br>**Маш сайн - 5** | Бохир усны шугамын шинэчлэл зураг төсөлд 30%-аар хэсэгчлэн орох байсан ч засвар 100% болон шинэчлэгдсэн. Цэвэр усны шугамыг 12 метр ган хоолойгоор, бохирын шугамын 100 метрийг PC хоолойгоор шинэчилж, 1 худгийг шинээр барьсан. |
| Барилгын засварын ерөнхий чанар | Маш муу – 1<br>Муу - 2<br>Дунд - 3<br>Сайн - 4<br>**Маш сайн - 5** | Барилгын ерөнхий чанар бол 95 хувьтай гүйцэтгэсэн.<br>Хаалга, цонх, фасад, дээвэр, аваарын гарц ажлууд чанартай материалын дагуу гүйцэтгэсэн. |
| Гадна ханын өнгө будаг ба түүний чанар | Маш муу – 1<br>Муу - 2<br>Дунд - 3<br>Сайн - 4<br>**Маш сайн - 5** | Гадна дулаалгын фасадын нягт - 80, 15 см зузаантай хөөсөнцрөөр дулаалж, солонгос чулуун замаскаар өнгөлсөн. |
| **Ажиглагдсан зөрчил, дутагдал:** | | |

| |
|---|
| Дэмжих багтай хамтран ажиллаж, харилцан тохиролцож, засварын ажлыг маш сайн, чанартай гүйцэтгэсэн. Ажилчид болон дэмжих багийнхан хоорондоо уялдаа холбоотой, маш сайн хамтран ажилласан. |
| **Сайжруулах шаардлагатай зүйлс:**<br>Барилгын компанийн үйл явц сайн. Засварын ажлын санхүүжилт, хуваарийн дагуу цаг хугацаандаа орж ирэхэд холбогдох байгууллагууд анхаарах |
| **Барилгын их засвар, дулаалгын талаарх ерөнхий дүгнэлт:**<br>Барилгын их засвар, дулаалга цонх, хаалга, дээвэр, гадна фасад, аваарын гарц, цонхны амлагаа зэрэг стандартын дагуу чанартай сайн хийгдсэн. |
| **Ажиглалт хийсэн хүний нэр, холбоо барих хаяг, утас**<br>Г.Цэрмаа 86030520, С.Мөнхцэцэг 86680049, Ж.Энх-Отгон 99065526, С.Гончиг 88196485, Б.Даваажав, Ж.Чулуундорж 80031429, Б.Ганхуяг 89558050, С.Майсайхан, Б.Батманлай, Ё.Зангад |

## ЗӨВШИЛЦЛИЙН ХУУДАС

<table>
<tr><td colspan="3">Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 80 цэцэрлэгийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа “Сайрын харгана” компани нь “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төслийн хүрээнд зохион байгуулалтад орсон “Дэмжих баг”-ийн гишүүдийн барилгын засвар, дулаалгын ажлын төгсгөлд хийсэн эцэг эхийн оролцоот, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, санал дүгнэлттэй танилцлаа.</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжих багийн гишүүд дараах ажлыг гүйцэтгэгч компани их засвар, дулаалгын төгсгөлийн шатанд бүрэн тусгаж ажиллахаа талууд харилцан зөвшилцлөө.<br>➢ “Сайрын харгана” компанитай зөвшилцөж, гадаа талбайн 280м$^2$ талбайн хог хаягдлыг тус компанийн техникээр буулгаж ачуулах<br>➢ Гал тогооны их засварыг бүрэн дуусгах<br>➢ Ажлыг чанартай, хугацаанд нь гүйцэтгэх, ажлын цагийг баримтлах<br>➢ Хяналт тавьж ажилла явцад харилцан бие биеэ хүндэтгэж хамтран ажиллах<br>➢ Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах<br>➢ Цэцэрлэгийн үүдний саравчийг хийж дуусгах<br>➢ Аваарын гарцын шатыг хийж дуусгах<br>➢ Төв хаалганы амлагааг хийх<br>➢ Тэргэнцрийн шатны хамгаалалт, бариулыг хийх</td></tr>
<tr><td>Дэмжих багийн ахлагч<br>С.Мөнхцэцэг</td><td>Хяналтын инженер<br>Хандсүрэн</td><td>Компанийн захирал<br>Түвшинсайхан</td></tr>
</table>

## ДҮГНЭХ ХУУДАС

Нийслэлийн 80 дугаар цэцэрлэгийн дулаалгын их засварын ажлыг гүйцэтгэж байгаа "Сайрын харгана" ХХК болон "Дэмжих баг"-ийн гишүүдийн харилцан зөвшилцсөн ажил нь дор дурдагдсан байдлаар биелэгдсэн.

| Харилцагч талууд | № | Зөвшилцсөн ажлууд | Ажлын биелэлт |
|---|---|---|---|
| Гүйцэтгэгч компанийн зүгээс | 1 | "Сайрын Харгана" компанитай зөвшилцөж гадаа талбайн 280м$^2$ талбайн 3 тонн хог хаягдлыг тус компанийн техникээр буулгаж ачуулах | "Хово" маркийн ачааны машинаар ачиж бүх хог хаягдлыг хаяж ойр орчмын талбайг цэвэрлэв. |
| | 2 | Гал тогооны их засварыг бүрэн дуусгах | Гал тогооны засварыг дуусгаж 380 холболт болон уурын яндант бүрэн гүйцэд угсарч дуусгав.<br>Гүйцэтгэл: 100% |
| | 3 | Цэцэрлэгийн төв хаалганы амлагаaг хийх | Цэцэрлэгийн төв хаалганы амлагаaг хийж цоожийг суулгасан. Гүйцэтгэл: 100% |
| | 4 | Аваарын гарцын шатыг хийж дуусгах | Аваарын хаалганы шатны угсралтын ажлыг зургийн дагуу гүйцэтгэсэн.<br>Гүйцэтгэл: 100% |
| | 5 | Тэргэнцрийн шатны хамгаалалт бариулыг хийх | Тэргэнцрийн налуу замыг зургийн дагуу хийсэн.<br>Гүйцэтгэл: 100% |
| Цэцэрлэгийн зүгээс | 1 | Хяналт тавьж ажиллах ажлын явцад харилцан бие биеэ хүндэтгэж хамтран ажиллах | Гүйцэтгэгч компани болон "Дэмжих баг"-ийн гишүүд харилцан бие биеэ хүндэтгэн зөрчил дутагдал, үл хүндэтгэх байдалгүй, их засварын ажлыг хугацаандаа амжилттай хийж дуусгалаа. Гүйцэтгэл: 100% |

**Дүгнэлт:** Барилгын их засварын ажил гүйцэтгэгч "Сайрын Харгана" ХХК-тай "Дэмжих баг"-ийн гишүүдийн харилцан зөвшилцсөн ажлууд100% биелэв.

**Биелэлтийг дүгнэсэн хүний нэр, холбоо барих хаяг, утас:**

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 3 дугаар хороо 65-р сургуулийн ард 80 дугаар цэцэрлэг
Эрхлэгч: Ганцэцэг Утас : 70182396, 99043829 э-майл: bgantsetseg_11@yahoo.com
Арга зүйч: Г.Цэрмаа утас: 89038050 э-майл: tsermaa.bagsh80@gmail.com

# ЗУРГИЙН ЦОМОГ










# НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 81 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ



## БИДНИЙ ТУХАЙ

Сонгинохайрхан дүүргийн 81 дүгээр цэцэрлэг нь 2 дугаар хороо Орбитын 39 дүгээр гудамжинд байрладаг. 1979 онд 6 бүлэг 140 хүүхдийн хүчин чадалтай, 29 багш, ажилтантай сургалт хүмүүжлийн ажлаа эхэлснээс хойш багш, ажилтны тоо 60 гаруй болж өргөжин, 41 дэх жилдээ сургалт, хүмүүжлийн ажлаа явуулж байна.

2020-2021 оны хичээлийн жилд өдрийн болон 24 цагийн ангийн 11 бүлгийн 360 гаруй хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлж байна. 2007 оноос цэцэрлэгт хамрагдаагүй сургуулийн өмнөх насны хүүхдийг хамруулах “Хувилбарт сургалт”-ыг зохион байгуулж байна.

Манай цэцэрлэг мэргэжлийн багшлах эрхтэй хүний нөөцөөр 100 хувь хангагдсан, багш нарын 30 хувь нь магистр, 70 хувь нь бакалаврын зэрэгтэй, мэргэжлийн тэргүүлэх зэрэгтэй 1, заах аргач мэргэжлийн зэрэгтэй 9, нийт 18 багштай ажилладаг. Тэдний амжилт бүтээлийг үнэлж Төрийн дээд “Алтан гадас” одонгоор 1, Засгийн газрын шагнал “Хөдөлмөрийн Хүндэт” медалиар 3, БШУЯ-ны шагнал

“Боловсролын тэргүүний ажилтан” цол тэмдгээр 7, “Хүндэт жуух бичиг”-ээр 5 багш тус тус шагнагдсан.

## БИДНИЙ АМЖИЛТ

- 2007 онд СХД-ийн тэргүүний цэцэрлэг
- 2011 онд “Сургалтын таатай орчин бүрдүүлэгч байгууллага”
- 2017 онд бүс, дүүргийн илтгэлийн тэмцээнд III байр
- 2019 онд СХД-ийн Засаг даргын нэрэмжит “Хүн болох багаасаа” хүмүүжлийн аяны “Шилдэг цэцэрлэг”
- Монголын Оюун Ухааны Академийн “Хурд-Спорт өрөлт”-ийн сургагч багшаар 2 багшийг тусгайлан бэлтгэж, 2017 оноос эхлэн цэцэрлэгүүдийн улсын аварга шалгаруулах “Хурд спорт өрөлт”-ийн тэмцээнд ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүдийг амжилттай бэлтгэж оролцуулан 2017, 2018 онд шилдэг оролцогчдоор шалгарсан, 2019 онд тусгай байр эзэлж батламж авсан.

## “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хэрэгжилт манай цэцэрлэгт



**Б.Лхамжав (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 81 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч)**

Манай цэцэрлэг баригдсан цагаасаа л дулаан алдагдал ихтэй, маш хүйтэн “Толгойтын хөлдүү саарал” гэдэг нэртэй байлаа. Одоогоос 17 жилийн өмнө 81 дүгээр цэцэрлэгийн эрхлэгчээр томилогдон ирсэн. Ангиуд маш хүйтэн учир зөвхөн хүлээн авах өрөөндөө хоол цайгаа идээд унтдаг, хүүхдүүд гадуур хувцастайгаа, гутлынхаа гадуур улавчтай, багш нар цагаан эсгий гуталтай, олон давхар хувцастай, цэвэрлэгээ хийж байхад шал нь мөстдөг маш хүйтэн байсан. Хэдий ажиллах орчин хүнд ч халуун дулаан сэтгэлтэй, эрч хүчээр дүүрэн эвсэг сайхан хамт олон намайг хүлээж авч байсан.

Манай цэцэрлэгийн барилгын чанар муу, дулаан алдагдал ихтэй дээвэр цонхноосоо сийгж, борооны усанд байнга автдаг байсан. Цэцэрлэгээ яаж дулаахан тохилог болгох тухай бодолдоо хөтлөгдөн, олон байгууллага руу хандаж, боломж боломжоо эрэлхийлэн ажилласан. Энэ хичээлийн жилд “Монгол

дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөл хамрагдсандаа баяртай байна. Төслийн хүрээнд нэг компани бүх ажлыг иж бүрэн, цогцоор хийсэн нь чанарын гүйцэтгэл маш сайн болоход нөлөөлж бид ч туйлын их сэтгэл ханамжтай байна. Төслийн чанар, үр дүн нь хүүхэд багачууд, нийгэмд олон талаар эерэг үр нөлөө үзүүлж чадсан. Одоо л хүүхдүүд, багш, ажилчид минь хөнгөн нимгэн хувцаслах хөдөлмөрийн бүтээмж нь сайжрах ая тухтай, дулаахан сайхан орчныг бүрдүүлж чадлаа.

Дэлхийг нөмөр,ч аюулын харанга дэлдээд байгаа Ковид-19 цар тахлын үед болон эрс тэс уур амьсгалтай манай орны хувьд хүүхдүүд маань дулаан, ая тухтай орчинд суралцах болсноор өвчлөл эрс буурч, цэцэрлэгтээ ирэх хүүхдийн хүсэл тэмүүлэл нэмэгдэж, улмаар боловсролыг тасралтгүй эзэмших, цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо нэмэгдэн, хандлагад нь эерэг өөрчлөлт гарсан.

Манай цэцэрлэгийн 24 цагийн үйл ажиллагаатай бүлэгт эмзэг бүлгийн өрхийн хүүхдүүд ихээр хамрагддаг. Хүүхдийн өвчлөл буурснаар хүүхдүүд цэцэрлэгтээ ирэх байдал сайжирч, гэр орондоо харгалзах хүнгүй үлдэх, ахуйн эрсдэлээс хамгаалах боломж бүрдэх боллоо.

Төслийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжих багийнхан маань хяналт-шинжилгээ, үнэлгээгээ сайн хийсэн нь удирдлагын ажлыг их хөнгөвчилсөн, төслийн чанар, үр дүн сайжрахад 100 хувь нөлөөлж чадсан гэж бодож байна. Энэ төслийг үр дүнтэй хэрэгжүүлж Монголынхоо ирээдүй хойч болсон мянга мянган хүүхдүүдийг эрүүл, зөв хүн болон төлөвших нөхцөл бололцоогоор хангаж, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг чанартай хүргэхэд үнэтэй хувь нэмрээ оруулсан төслийн багийнхандаа баярлаж, талархсанаа илэрхийлье.



**Т.Оюунцэцэг (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 81 дүгээр цэцэрлэгийн арга зүйч):**

Бид “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөлд хамрагдан цэцэрлэгийн барилгын дулаалга, их засвар үйлчилгээний ажлаа шийдэж чадсандаа баяртай байна. Манай цэцэрлэгийн барилга 1979 онд баригдсан, барилгын чанар муу, анги танхим, өрөө тасалгаа, ялангуяа 24 цагийн бүлэг хүйтэн байсан нь хүүхдийн тав тухтай сурч хүмүүжих орчныг бүрдүүлэхэд ихээхэн хүндрэлийг бий болгож байсан. Одоо цэцэрлэгийн маань өнгө үзэмж нэмэгдэн, дулаахан таатай болсон. Дэмжих багт цэцэрлэгийн удирдлага, багш, ажилтан, эцэг эхийн төлөөлөл оролцсон. Энэхүү төслийн “Дэмжих баг”-ийг ахалж

ажилласнаар “Хамт олон гэдэг нь зөвхөн хамт ажилладаг хүмүүсийг хэлэх биш, эцэг эх ч бас бидний нэг хамт олон юм” гэдгийг илүү ойлгосон.

**Б.Оюунтунгалаг (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 81 дүгээр цэцэрлэгийн багш):**



Манай цэцэрлэгт гадна дулаалга, цонх, хаалга, дээврийн засвар зэрэг ажил хийгдсэн. Барилгын засвар эхлэхээс өмнө эцэг эхийн оролцоот дэмжих баг байгуулагдан сургалтад хамрагдсанаар багийн гишүүд барилгын засварын ажлын талаар мэдлэгтэй болж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадавхтай болсонд энэхүү төслийн гол ач холбогдол оршиж байна. Манай цэцэрлэг энэ төсөлд хамрагдсанаар хүүхэд эрүүл аюулгүй орчинд суралцах орчин нөхцөл бүрдэж, хүүхдийн өвчлөл эрс буурсан. Хүүхэд цэцэрлэгтээ ирэх хүсэл нэмэгдэж, эцэг эхчүүдийн оролцоо, хандлага нэмэгдэж, хамт олны дунд эерэг уур амьсгал бүрдэж, ажиллах эрч хүч нэмэгдсэнд баяртай байна.



**Б.Золхуяг (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 81 дүгээр цэцэрлэгийн ажилтан):**

Би цэцэрлэгтээ 7 дахь жилдээ ажиллаж байна. Манай цэцэрлэгийн анги бүлгүүд цонхоороо дулаан алддаг, дээврээс нь ус гоождог, мөөгөнцөр үүссэн байсан. Байгууллага өөрсдийн болон улс, нийслэлээс хэсэгчлэн засвар үйлчилгээ жил болгон хийдэг байсан ч асуудлыг бүрэн шийдэж чаддаггүй байлаа. Анх дэмжих баг байгуулагдахад үнэндээ их төвөгтэй санагдаж, ямар сайндаа л засвар хийхэд юун сургалт, юун баг байгуулах вэ? гэж гайхаж хүлээж авч байсан. Явцын дунд дэмжих баг байгуулах нь бидний ажлыг ямар их хөнгөвчилж байгааг, эцэг эхтэй харилцах харилцааны үл ойлголцол буурч байгаа зэрэг давуу талууд бий болж байгааг мэдэрсэн.

**Д.Баасанхүү (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 81 дүгээр цэцэрлэгийн Бэлтгэл-Б бүлгийн ээж):**



Манай хүүхэд тус цэцэрлэгийн 24 цагийн бүлэгт 3 дахь жилдээ суралцаж байна. Ээлжийн ажилтай учраас хүүхдээ цэцэрлэгт өгдөгтөө сэтгэл зовнидог байсан. Хүүхдийн маань ангид дээврээс ус гоождог, хүйтэн, тухгүй байсан. Бүлгийн багшийн санал болгосноор дэмжих багт орж, засварын явцад хяналт тавьж ажилласан. Зуны турш засвар хийгдсэнээр цэцэрлэг маань дулаахан тохь тухтай сайхан боллоо. Миний хувьд ч хүүхдэдээ сэтгэл зовних зүйлгүй, тайван ажлаа хийж байна. Хүүхдийнхээ хоёр дахь гэрийг дулаахан болгох ажилд оролцсон өөрөөрөө болон та бүхнээр үнэхээр их бахархаж байна.

## ОРЧНОО СОЁЛТОЙ, ТОХИЛОГ БОЛГОЁ

| | |
|---|---|
| Зорилго | Эрүүл ахуй, орчны стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болж тав тухтай орчин, нөхцөл бүрдүүлэх |
| Нөхцөл байдал, тулгамдсан асуудал | • Ариун цэврийн өрөөнд байгаа зүйлс нь элэгдэж эвдэрсэн, орчин нөхцөл тааруу, эрүүл ахуйн шаардлага хангаагүй<br>• Багш ажилтнуудын ариун цэврийн байгууламжийн талаарх сэтгэл ханамж муу<br>• Ариун цэврийн өрөө хүйс харгалзсан таславч, тусгаарлагч байхгүй, суултуурын тоо хангалтгүй<br>• Багш, ажилтнуудын хувьд эрүүл ахуйн шаардлагад нийцсэн зориулалтын ариун цэврийн байгууламж байхгүй байсан. |
| Зорилтот бүлэг | Байгууллагын 60 багш, ажилтан |
| Шалгуур үзүүлэлт | • Ариун цэврийн байгууламжийн эрүүл ахуйн стандарт шаардлагыг хангасан байдал (ариун цэврийн стандарт, норм хангасан байдал)<br>• Ариун цэврийн байгууламжийн тохь тухын талаарх багш, ажилтны сэтгэл ханамжийн түвшин (хэмжих нэгж хувиар)<br>• Ариун цэврийн байгууламжийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлын талаарх хяналт-шинжилгээ, үнэлгээний харьцуулалт (хэмжих нэгж хувь)<br>• Бодлогын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлт (хэмжих нэгж тоогоор) |

| | |
|---|---|
| Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат | • Эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээний дэмжих баг байгуулсан<br>• Дэмжих багийн гишүүдийг чадавхжуулах сургалтад хамруулсан<br>• Багш ажилчид болон дэмжих багийн гишүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан<br>• Бодит нөхцөл байдлыг үнэлэх хяналтын хуудас боловсруулан хяналт- шинжилгээ, үнэлгээ хийсэн<br>• Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд суурилан хийх ажлын төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацааны график зураглалыг гаргаж, төсвийн тооцоог гаргасан.<br>• Байгууллагын багш, ажилтан, эцэг эхийн оролцоонд тулгуурлан нөөц бололцоог бүрдүүлсэн<br>• Төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлсэн<br>• Тогтвортой байдлыг ханган ажиллаж байна. |
| Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд) | - Ариун цэврийн өрөөг засан сайжруулахдаа шинээр солих, нэмж хийх тоног хэрэгслийн үнэ өртгийг судлан, санхүүгийн үүсвэрийг хэрхэн бүрдүүлэх талаар дэмжих багийн гишүүд болон байгууллагын нийт багш, ажилтнуудтай ярилцаж тохиролцсоны үр дүнд дараах шийдэлд хүрсэн.<br>    - Агааржуулагчтай болсон, гар угаах ариутгах нөхцөл бүрдсэн, ариутгалын бодис, цэвэрлэгээний материал хийх шүүгээ хийсэн<br>    - Угаалтуурын холигчийг шинээр сольсон, суултуурын тоог нэмсэн<br>    - Хүйсийн ялгаатай байдлыг харгалзан тусгаарлагч хана босгосон<br>- Цэцэрлэгийн эмчийн сар тутмын эрүүл ахуйн хяналт үнэлгээгээр ариун өрөөг засвар хийж, шинэчлэхээс өмнө 54 хувийн үзүүлэлттэй үнэлэгддэг байсан бол засвар хийсний дараа 80 хувь болж нэмэгдсэн төдийгүй үйлчилгээний ажилтны ажлын бүтээмж болон гүйцэтгэл дээшилсэн үзүүлэлттэй үнэлэгдсэн.<br>- Цэвэр орчин бүрдсэнээр багш, ажилтны сэтгэл ханамж сайжирсан<br>- Ариун цэврийн байгууламжийг ариутгалын бодисоор тогтмол ариутгах, цэвэрлэгээ үйлчилгээг чанартай хийж, тав тухтай орчныг бүрдүүлсэн. |
| Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд | • Цэцэрлэгийн дотоод журам, багш ажилтны албан тушаалын тодорхойлолт болон бусад бодлогын баримт бичгүүдэд байгууллагын өмчийг зүй зохистой ашиглах, хадгалалт |

| | |
|---|---|
| | хамгаалалт, цаашид тогтвортой, эрүүл аюулгүй таатай орчин бүрдүүлж ажиллуулахад багш ажилчид ямар үүрэг, хариуцлагатай байхыг тусган оруулсан. (Байгууллагын дотоод журмын 11.1.3 дугаар заалт, Байгууллагын эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт дүрэм 11.1.4. заалтад тус тус өөрчлөлт оруулсан.)<br>• Эд хөрөнгийг эвдрэл гэмтэлгүй стандартын дагуу байхад хяналт тавьж, гарсан эвдрэл гэмтлийг засаж сайжруулж бүрэн бүтэн байх, өнгө үзэмжид анхаарч хэвшсэн. |
| Тулгарсан бэрхшээл, эрсдэл: | • Цэцэрлэгийн үйл ажиллагаа дахь эцэг эхийн оролцоо бага, хамтын ажиллагааны тухай ойлголт харилцан адилгүй байсан нь баг бүрдүүлэн ажиллахад хүндрэлтэй байсан.<br>• Эцэг эхийн мэдлэг боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдал харилцан адилгүй, байгууллагын баримт бичиг боловсруулалт, төлөвлөлтөд оролцож байгаагүй, багш, удирдах ажилтны үгийг даган дуурайн өөрийн үзэл бодлоо илэрхийлэхгүй байсан.<br>• Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйд суралцаагүй, энэ талаарх ойлголт муу байсан. |
| Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс | • Амжилтад нөлөөлсөн гол зүйлийн нэг нь сургалт, арга зүйн зөвлөмж, ололт амжилтын талаар харилцан ярилцаж, хэлэлцүүлэг зохион байгуулж хүн бүхний хичээл, зүтгэл, оролцоог дэмжсэн.<br>• Баг болон ажиллах арга зүйд суралцуулсан нь зөв арга байсан.<br>• Эцэг эхчүүд идэвхжин, хамтран асуудлыг шийдвэрлэх арга зүй, оролцоог дэмжих арга зүйд суралцсан. |
| Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс | • Ажлын төлөвлөгөөндөө эцэг эхийн санал санаачилгыг тусган хэрэгжүүлэх, эргэн мэдээлдэг байх зохицуулалтыг цэцэрлэгийн дотоод журамд тусган, эрхлэгчийн тушаалаар баталгаажуулах<br>• Үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх бүх үйл явцад багаар ажиллах, санал солилцох, зөвлөлдөх, оролцуулах зарчмыг дэмжин ажиллах<br>• Өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчлан аль болох олон гэр бүл, эцэг эхийг хамруулж оролцоог нэмэгдүүлэх |
| Холбоо барих хаяг, лого: | **Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 81 дүгээр цэцэрлэг**<br>Эрхлэгч Б.Лхамжав, Утас: 99114386, lham.b8181@gmail.com<br>Арга зүйч Т.Оюунцэцэг, Утас: 95748470, oyuntsetseg.az81@gmail.com<br>Багш Б.Оюунтунгалаг. Утас: 96693969, tungaaoyun22@gmail.com |

## ХАЛУУН СЭТГЭЛ - ДУЛААН ОРЧИН

| | |
|---|---|
| Зорилго | Хүүхэд, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдад ээлтэй, стандарт шаардлагад нийцсэн, эрсдэлгүй, дулаан, тав тухтай орчныг бүрдүүлэх |
| Нөхцөл байдал, тулгамдсан асуудал | • Барилгын суурь хагарал ихтэй, ханын дулаалгын хөөсөнцөр хөндийрч, зай завсар гарсан, ханын зарим хэсэгт ус чийгээс үүдэлтэй мөөгөнцөр үүссэн<br>• Цонхны суулгалт буруу хийгдсэнээс дулаан алдагдал ихтэй, цонхны шил хоёр давхар учир хөлөрч цантдаг<br>• Агааржуулалтын хоолой нурж бөглөрсөн<br>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зорчих зориулалтын гарц байхгүй<br>• Хаалганы цоож, тоноглол болон нугас, резин хатаж, суларч муудсан<br>• Дээврийн хар цаас хуучирч урагдсан, дээврийн хаялга төмөр хөндийрч унасан<br>• Цэцэрлэгийн барилга нь дөчин жилийн насжилттай, стандартын дагуу засвар үйлчилгээ хийгдэж байгаагүй,<br>Дээрх нөхцөл байдлаас улбаалан цэцэрлэгийн барилга дулаан алдагдал ихтэй, хүйтэн байсан нь манай цэцэрлэгийн хамгийн тулгамдсан асуудал болж байв. |
| Зорилтот бүлэг | Цэцэрлэгийн бүх хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагчид, багш, ажилчид |
| Шалгуур үзүүлэлт | • Тодорхой давтамжтай барилгын их засвар, дулаалгын ажлын эхэн, дунд, төсгөлд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ<br>• Барилгын засварын гүйцэтгэл, өдөр тутамд хийх хяналт<br>• Эцэг, эх асран хамгаалагч, багш, ажилчдын сэтгэл ханамжийн түвшин<br>• Цэцэрлэгийн дулаан алдалтыг бууруулсан хувь хэмжээ<br>• Цэцэрлэгээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд эцэг эхийн зүгээс хөндлөнгийн хяналт тавьж үнэлгээ хийсэн байдал |
| Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат | • Зохион байгуулалтад орсон цэцэрлэгийн удирдлага, багш, ажилтан, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний “Дэмжих баг”-ыг байгуулсан.<br>• Дэмжих багийн гишүүдээ чадавхжуулах сургалтад 4-5 удаа хамруулсан |

| | |
|---|---|
| | • Багш ажилчид болон “Дэмжих баг”-ийн гишүүдийн дунд хэлэлцүүлэг, зохион байгуулсан<br>• Барилгын засварын явцад “Дэмжих баг”-ийн гишүүд өдөр тутмын хяналт болон эхэн, дунд, эцсийн шатны үнэлгээг хийсэн.<br>• Шат бүрийн үнэлгээний дүгнэлтэд үндэслэн тулгарсан асуудлыг гүйцэтгэгч компанитай харилцан зөвшилцөж ажилласан.<br>• Сар бүр хийсэн ажлын тайлан гаргаж холбогдох шатны байгууллагад тайлагнаж ажилласан. |
| Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд) | Дэмжих багийн гишүүдийн хяналт үнэлгээгээр илрүүлэн гаргасан асуудлын талаар гүйцэтгэгч компани, хяналтын инженертэй зөвшилцөн дараах ажлуудыг амжилттай гүйцэтгэсэн.<br><br>Үүнд:<br>• Барилгын урд болон хойд хэсэгт олон жилийн бороо усны чийгшлийн улмаас мөөгөнцөр үүссэн, суурийн дулаалгын явцад техникийн ажиллагааны доргилтын нөлөөгөөр суурийн нуралт үүсэж болзошгүй байсныг өдөр тутмын хяналтын явцад илрүүлэн хяналтын инженер болон барилгын гүйцэтгэгч компанийн удирдлагатай зөвшилцөн гараар ухах болон бусад шаардлагатай арга хэмжээг авсан.<br>• Цонх бүр өөр өөр хэмжээтэй байсан тул захиалга өгөхдөө цонх тус бүрээр хэмжээг нарийвчлалтай гарган зөрүүг арилгасан, цонхыг суурилуулахдаа салхивчийг стандартын дагуу дээд талд байрлуулж дээшээ хагас онгойдог, харагдах байдлыг үзэмжтэй цэвэрхэн, хүүхдийн осол аюулгүй байдлыг хангаж суулгуулсан.<br>• Цэцэрлэгийн дотор 2 давхрын тусгаарлагч таазыг авахад олон жилийн тоос тортог тогтож цэцэрлэгийн дотоод орчны эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй болсон тул засал хийгдэх зайлшгүй шаардлага гарсныг холбогдох байгууллагад хүсэлт гарган засуулсан.<br>• Дээврийн паркетын төмөр хамгаалалт, мансардад дээвэр төмөр хийлгэсэн.<br>• Аваарын шатны төмөр хашлага зураг төсөлд тусгагдаагүй байсныг гүйцэтгэгч компанитай зөвшилцөн шинээр сольсон.<br>• Барилгын их засвар стандартын шаардлагад нийцсэн, батлагдсан зураг төслийн дагуу зохион байгуулалт сайтай хийгдсэн. |

| | |
|---|---|
| | • Засварыг стандартын чанарын шаардлагад нийцсэн, тохирлын гэрчилгээ бүхий лабораторийн шинжилгээний бичигтэй баталгаатай материалаар гүйцэтгүүлсэн. |
| Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд | • Цэцэрлэгийн тулгамдаж буй асуудлаа бодит судалгаа, хяналт үнэлгээний үр дүн, тоо баримтаар баталгаажуулж багаар хамтран ажиллах, шийдвэрлэх боломжтойг ойлгож ажил хэрэг болгож эхэллээ.<br>• Дэмжих багийн гишүүд цэцэрлэгийн гадаад, дотоод орчинд хийсэн хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд түшиглэн цэцэрлэгт тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэх арга зүйг боловсруулан бусад багш, эцэг эхчүүдэд танилцуулан тэдний саналыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлнэ. |
| Тулгарсан бэрхшээл, эрсдэл: | • Цэцэрлэгийн удирдлага, багш, ажилчид, эцэг эхчүүд барилгын дулаалгын засвар үйлчилгээний талаар мэдлэг дутмаг, хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх ойлголт, төсөөлөл харилцан адилгүй байсан ч удаа дараагийн сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, төслийн зөвлөх мэргэжилтэн, хяналтын инженерийн зөвлөгөө, мэдээллийн үр дүнд багийн гишүүдийн оролцоо нэмэгдэж эхэлсэн.<br>• Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь эцэг эхчүүдийн хувьд цоо шинэ санаачилга байсан. Тэд зөвхөн цэцэрлэгээс зохион байгуулагддаг уралдаан, тэмцээн, сургалтад оролцож байснаас бус дэмжих багийн үйл ажиллагаанд оролцож байсан туршлагагүй байсан. Багийн нийт гишүүдийн 70-80 хувь нь хуваарийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хамтран ажилласан. |
| Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс | • Дэмжих багийн зүгээс барилгын засварын үйл ажиллагаанд өдөр тутам хяналт тавьснаар багш, ажилтан, эцэг эхчүүд цэцэрлэг дээр хэрэгжиж байгаа төслийн талаар нэгдсэн ойлголттой болж төслийн хэрэгжилт ямар шатанд яваа, ажлын явцад ямар алдаа дутагдал гарсан, хэрхэн шийдвэрлэж болох талаар төсөл хэрэгжүүлж байгаа багтай хамтран ажиллах боломж бүрдсэн. Дэмжих багийн гишүүд нийт 44 удаа өдөр тутмын хяналтыг хийсэн.<br>• Төсөл хэрэгжүүлсэн нь дэмжих багийн талаарх ойлголттой болж цэцэрлэгийн барилгын засвар, дулаалгын явцад хөндлөнгийн хяналт тавиад зогсохгүй цэцэрлэгийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх, дотоод хяналт тавих цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эхийн санал оролцоог дэмжих гэсэн чухал үйл ажиллагаанд суралцсан. |

| | |
|---|---|
| Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс | • Цэцэрлэг олон нийтийн оролцоог дэмжих, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, бүхий л талаар дэмжин ажиллах<br>• Эцэг эх болон дэмжих багийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг эргэж мэдээлэх, олон нийтэд хүргэх, сурталчлах<br>• Байгаль цаг агаарын болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, ажлыг сайн төлөвлөх нь учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх сайн талтай.<br>• Үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүхий л үйл явцад багаар ажиллах, санал солилцох зөвлөлдөх, оролцох зарчмыг баримталж ажиллах. |
| Холбоо барих хаяг, лого: | **Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 81 дүгээр цэцэрлэг**<br>Эрхлэгч Б.Лхамжав, Утас: 99114386, lham.b8181@gmail.com<br>Арга зүйч Т.Оюунцэцэг, Утас: 95748470, oyuntsetseg.az81@gmail.com<br>Багш Б.Оюунтунгалаг. Утас: 96693969, tungaaoyun22@gmail.com |

## БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДУЛААЛГЫН АЖЛЫН ЯВЦАД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Дүүрэг: Сонгинохайрхан Байгууллага: 81 дүгээр цэцэрлэг

Огноо: 2020 оны 7 дугаар сарын 31-ны өдөр

| БАРИЛГЫН ЗАСВАРЫН АЖЛЫН ҮЙЛ ЯВЦ ЭХЭЛСНЭЭС ХОЙШ ЦУГЛУУЛАХ МЭДЭЭЛЭЛ | | | |
|---|---|---|---|
| **Шалгуур** | | **Тэмдэглэгээ** | **Тайлбар/дэлгэрэнгүй** |
| 3.1 | Барилгын зураг төсөлд тэмдэглэгдсэн бүх цонх, гадна хаалгыг шинэчлэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | Цонхнууд бүрэн солигдсон. Цонхны амлагаа, тавцан хийгдээгүй байна. Гадна 5 ш хаалга солигдож ирснийг өөрчлөх |
| 3.2 | Цонх, хаалганы байрлал түүний ус тусгаарлалт, битүүмжлэлийн үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | • Цонхны рамын өргөн: 72<br>Давхар шилний тоо: 3<br>• Цонхны хүрээний таславчийн тоо: 5<br>• Үйлдвэрлэсэн байгууллагын нэр: ХААН ЦОНХ ХХК |
| 3.3 | Гадна ханыг иж бүрэн, зохих | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй | • Хөөсөнцрийн зузаан.15 см |

| | | | |
|---|---|---|---|
| | зузаанаар дулаалах үйл явц | ○ **Ажил эхлэх шатандаа**<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | • Нягт: 22<br>• Грунт: ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА<br>• Хөөсөнцрийн цавуу: 999 |
| 3.4 | Дээврийн дулаалгыг иж бүрэн хийх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд** шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | Хуулалт хийгдсэн. Урд талын 2 ангийн дээвэр, төв хэсэгт цутгагдсан. Хучилт хийгдээгүй байна. Хойд 2 ангийн дээвэр, баруун талд хуулалт хийгдэж байна. |
| 3.5 | Цонхны амлагаа болон дотор тавцангууд бүрэн хийгдэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд** шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | Цонхны амлагаа, тавцан хийгдээгүй. Цонхны тавцангийн хэмжээ стандарт бус зөрүүтэй байгааг гүйцэтгэгч компанитай ярилцаж тохирох |
| 3.6 | Халаалтын системийг зургийн дагуу гүйцэтгэх үйл явц | ○ **Огт тусгагдаагүй**<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 3.7 | Сантехникийн тоноглолууд иж бүрэн, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан эсэх | ○ **Огт тусгагдаагүй**<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 3.8 | Дээвэрт ус нэвтрэхгүй битүүмжлэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | Бороо орох үеэр гялгар уутаар бүтээж ус нэвтрэхгүй байх арга хэмжээг авч байна. |
| 3.9 | Цэвэр, бохир усны шугам шаардлагатай стандартын дагуу хийгдэх үйл явц | ○ **Огт тусгагдаагүй**<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа | |

| | | | |
|---|---|---|---|
| | | ○ Ажил дуусах шатандаа | |

| | |
|---|---|
| **Ажиглагдсан зөрчил, дутагдал:** | |
| 1. | Дээврийн хуулагдсан хэсэгт бороо усны хамгаалалт бүрэн хийгдээгүй учир борооны ус доошоо нэвтэрч, гоожин ангийн хана, тааз норж, дахин засал хийгдэх шаардлагатай болсон. 2 давхрын гэгээвчийн тусгаарлагч таазыг авахад олон жилийн тоос тортог тогтож эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй болсон тул засал хийгдэх шаардлагатай байна. |
| **Цаашид анхаарах зүйлс:** | |
| 2. | • Бороо орж байгаа нөхцөлд дээврийн битүүмжлэлийг сайтар хийх, доошоо ус нэвтэрч гоожихоос сэргийлэх. Хуучин стандарт бус усны хаялгыг өөрчилж зөв чиглэлийн дагуу хийх<br>• Цонхны тавцан стандарт зөрүүтэй учир зөрүүг арилган харагдах байдлыг үзэмжтэй, цэвэрхэн, хүүхдийн осол аюулгүй байдлыг хангаж хийх<br>• Суурийн чийгшил их өгч мөөгөнцөртсөн хэсэгт ухах явцад барилгын суурь суулт өгч болзошгүй учир гараар ухахдаа цэцэрлэгийн барилгын төв хаалгатай зүүн хэсэг, хойд хэсэгт онцгойлон анхаарах |
| **Барилгын их засвар, дулаалгын явцын талаарх ерөнхий дүгнэлт:** | |
| 3. | 2020 оны 7 дугаар сарын 31-ны байдлаар барилгын их засвар стандартын шаардлагад нийцсэн, батлагдсан зураг төслийн дагуу зохион байгуулалт сайтай хийгдэж байна. Засварыг материалын чанар стандарт шаардлагад нийцсэн, тохирлын гэрчилгээтэй, лабораторийн шинжилгээний бичигтэй баталгаатай материалаар гүйцэтгэж байна.<br>Төслийн мэргэжилтэн, хяналтын инженер, гүйцэтгэгч компанийн төлөөлөгчид Эм Эл Эс ХХК-ын зураг төслийн багтай харилцан тохиролцож, цонхны камер таславчийг 5-аар хийсэн. Мөн барилгын дээврийн засварыг хийхдээ порпадьны өрлөг хэт намхан байсан учир Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар болон зураглалын багийн зөвшөөрлөөр дээш 30 см өрлөг нэмж хийгдэж байна.<br>• Цонх бүрэн солигдсон боловч цонхны амлагаа, тавцан суугдаагүй 40 хувь<br>• Хаалга солих үйл явц 10 хувь<br>• Суурийн дулаалга 70 хувь<br>• Дээврийн дулаалга 50 хувь<br>• Ханын дулаалга 10 хувь<br>• Нийт засварын ажлын гүйцэтгэл 36 хувьтай явагдаж байна. |
| **Үнэлгээг нэгтгэсэн хийсэн хүний нэр, холбоо барих хаяг, утас** | |
| Сонгинохайрхан дүүргийн 81 дугаар цэцэрлэг<br>Дэмжих багийн ахлагч Т.Оюунцэцэг. Утас: 95748470 | |

## ЗӨВШИЛЦЛИЙН ХУУДАС

*Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 81 дүгээр цэцэрлэгийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа ЦАГААН УДАМ ХХК компани нь “Монгол дахь*

| |
|---|
| *барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төслийн хүрээнд зохион байгуулалтад орсон “Дэмжих баг”-ийн гишүүдийн барилгын засвар, дулаалгын ажлын явцад хийсэн эцэг эхийн оролцоот, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, санал дүгнэлттэй танилцлаа.* |
| Дэмжих багийн гишүүдийн тайланд туссан дараах зүйлсийг гүйцэтгэгч их засвар, дулаалгын явцад тусгаж ажиллахаа талууд харилцан зөвшилцлөө. |
| **Гүйцэтгэгч компанийн зүгээс**:<br>• Цонхны тавцан суулгалтыг хүүхдийн осол аюулгүй байдлыг харгалзан стандарт зөрүүг арилган, цэвэрхэн суулгах<br>• Камер, гэрлийн суурийн төмөр бэхэлгээг суулгахдаа бороо усны гоожих аюулаас сэргийлж битүүмжлэлийг бүрэн хийх<br>• Суурийн дулаалга хийхдээ барилгын урд хэсэгт олон жилийн бороо усанд норж чийгшил их өгөгдсөн суурь суулт өгч болзошгүй учир гараар ухаж, дулаалга хийх<br>**Цэцэрлэгийн зүгээс**:<br>• Засварын батлагдсан зурагт өөрчлөлт оруулах саналыг зургийн компанид албан тоот хүргүүлж саналаа өгөх (Үүнд: дотор шат, дээд давхрын гэгээвчийн засал орно.)<br>• Барилгын урд талбайн овгор газрын талбайг тэгшлэх<br>• Анги бүлгийн цонхны тавцан, амлагааг хийхэд саад болзошгүй ханнанд тогтоогдсон тавиурыг авч чөлөөлөх |

## ЗӨВШИЛЦЛИЙН ХУУДАСНЫ БИЕЛЭЛТ БУЮУ ДҮГНЭХ ХУУДАС

*Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 81 дүгээр цэцэрлэгийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа ЦАГААН УДАМ ХХК компани болон “Дэмжих баг”-ийн гишүүдийн харилцан зөвшилцсөн ажил үйлчилгээ нь дор дурдсан байдлаар биелэгдсэн байна.*

| Харилцагч талууд | № | Зөвшилцсөн ажлууд | Ажлын биелэлт |
|---|---|---|---|
| Гүйцэтгэгч компанийн зүгээс | 1 | Цонхны тавцан суулгалтыг хүүхдийн осол аюулгүй байдлыг харгалзан стандарт зөрүүг арилган харагдах байдлыг цэвэрхэн хийх | Цонхыг суулгахдаа зөрүүг арилган, харагдах байдлыг үзэмжтэй цэвэрхэн суулгаж, тавцанг зүсүүлэхдээ тус бүрийн хэмжээг нарийн гаргаж, тавцангийн ирмэг буланг хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс дугуйлж, суулгасан. Гүйцэтгэл: 100% |
| | 2 | Камер, гэрлийн суурийн төмөр бэхэлгээг суулгахдаа бороо усны гоожих аюулаас сэргийлж | Камер гэрлийн төмөр бэхэлгээг суулгахдаа гадна фасадын хөөсөнцрийг гэмтээхгүйгээр урьдчилан тоосгон ханан дээр суурилуулж бороо ус гоожих |

| | | | |
|---|---|---|---|
| | | битүүмжлэлийг бүрэн хийх | аюулаас сэргийлж битүүмжлэлийг бүрэн хийсэн.<br>Гүйцэтгэл: 100% |
| | 3 | Суурийн дулаалга хийхдээ барилгын урд хэсэгт олон жилийн бороо усанд норж чийгшил их өгөгдсөн суурь суулт өгч болзошгүй учир гараар ухаж дулаалах | Барилгын арын хэсэг болон урд хэсэгт суурийн 20 метр орчим газарт ус нэвтэрч хана мөөгөнцөртсөн, гал тогооны баруун ханаы хэсэгт суурь мөөгөнцөртсөнөөс барилгын суурьд суулт өгч болзошгүй байсныг анхааралдаа авч гүйцэтгэгч компанитай зөвшилцөн техник хэрэгслээр ухалгүй, гараар хүрздэж шороог зайлуулан суурийн хэсгийн дулаалгын ажлыг хийсэн.<br>Гүйцэтгэл: 100 хувь |
| **Цэцэрлэгийн зүгээс** | 1 | Засварын батлагдсан зурагт өөрчлөлт оруулах саналыг зургийн компанид албан тоот хүргүүлж саналаа өгөх (Үүнд: дотор шат, дээд давхрын гэгээвчний засал орно.) | Засварын батлагдсан зурагт өөрчлөлт оруулах саналыг зургийн компанид албан тоот хүргүүлж дээд давхрын гэгээвчний заслыг хийлгэж эрүүл ахуйн таатай орчныг бүрдүүлсэн.<br>Харин дотор шатны төсөв хөрөнгө шийдэгдээгүй, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар зөвшөөрөл өгөөгүй учир хийгдээгүй.<br>Гүйцэтгэл: 50 хувь |
| | 2 | Барилгын урд талын овгор газрын талбайг тэгшлэх | Барилгын урд талбайн овгор шороог тэгшлэн цементэлж усны хаялгыг урсгалын дагуу налуулан хийсэн.<br>Гүйцэтгэл: 100 хувь |
| | 3 | Анги бүлгийн цонх тавцан, амлагааг хийхэд саад болзошгүй хананд тогтоогдсон тавиурыг авч чөлөөлөх | Цонхны тавцан суулгах болон амлагаа шавардлага хийхэд саад болохуйц тавиур, таван зэргийг хананаас авч чөлөөлүүлсэн.<br>Гүйцэтгэл: 100 хувь |
| **Дүгнэлт:** | | | |
| Барилгын гүйцэтгэгч “Цагаан Удам” ХХК-тай Дэмжих багийн гишүүдийн харилцан зөвшилцсөн 6 ажлаас 5 ажил бүрэн 100% биелж 1 ажил хагас 50% биелэлттэй, биелэлт 92%-тай байна. | | | |
| **Биелэлтийг дүгнэсэн хүний нэр, холбоо барих хаяг, утас:** | | | |
| Сонгинохайрхан дүүргийн 81 дүгээр цэцэрлэгийн арга зүйч, дэмжих багийн ахлагч Т.Оюунцэцэг. Утас: 95748470 | | | |

# ЗУРГИЙН ЦОМОГ

















# НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 65 ДУГААР СУРГУУЛЬ



## БИДНИЙ ТУХАЙ

Манай сургууль 1975 онд Сонгинохайрхан дүүргийн Толгойтын Нарангийн дэнжид байгуулагдсан. СХД-ийн 3, 4, 26, 36 дугаар хорооны хүүхдүүдийг хамран сургадаг, хичээлийн хоёр байртай.

2020-2021 оны хичээлийн жилд 111 бүлэгт 4184 хүүхдийг сургаж, 161 багш, 40 ажилчидтай үйл ажиллагаагаа явуулж байна. 100 хувь мэргэжлийн багш нараар хангагдсан. Математик, англи хэл, монгол бичиг, уран зураг, шатрын төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалттай ангиуд хичээллэдэг.

Манай хамт олон ОХУ-ын Буриад улсын 17 дугаар сургууль, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Туньляа хотын Монгол бага сургуультай хамтын ажиллагаатай. Сургуулийн захиргаа гавьяаны амралтдаа гарсан ахмад багш, ажилчдын зөвлөл, төгсөгчдийн холбоотойгоо хамтран олон ажлыг зохион байгуулдаг уламжлалтай. Жил бүр оны “Шилдэг амжилт”, “Шилдэг ажил”-ууд хамт олны оролцоотой шалгаруулдаг. Хамтран ажилладаг байгууллагуудын дэмжлэгээр багш, ажилчид, эцэг эхчүүдийг гадаад, дотоодын тойрон аялалд хамруулан тэдэнд ажиллах урам зориг өгдөг.

## “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хэрэгжилт манай сургуульд



**Ч.Хишигмаа (Нийслэлийн СХД-ийн Ерөнхий боловсролын 65 дугаар сургуулийн захирал):**

Манай сургууль энэхүү төсөлд хамрагдсанаар хаалга, дээвэр, цонх, гадна дулаалгын фасадыг шинээр хийж гүйцэтгэлээ. Төслийн үр шимийг 8100 гаруй хүн хүртэж байгаад сэтгэл хангалуун байна. Өмнө нь сургууль хүйтэн байсны улмаас хүүхэд, багш, ажилчдын дунд өвчлөл их гарахаас гадна, ажиллах нөхцөл таагүй, сэтгэл санаа тав тухгүй байдаг байсан. Энэ оны 10 дугаар сараас дээрх нөхцөл байдал өөрчлөгдөн бид дулаахан, ая тухтай орчинд ажиллаж эхэллээ. Ингэснээр сургалтын чанар, сурагчдын төлөвшилд эерэг өөрчлөлтүүд гарч байна.

Төсөл хэрэгжих хугацаанд эцэг эхийн оролцоот “Дэмжих баг” нь сургуулийн хог хаягдлын асуудлыг онцлон, анхаарч ажилласны үр дүнд хогийг ангилан ялгах арга зүйд хамт олноороо суралцаж байна. Бага ангийн багш, сурагчдад “Хогон мангас” жүжгийг найруулан үзүүлсэн нь үр дүнгээ өгч байна. Цаашид хогийг ангилан ялгах чиглэлээр хороо, цэцэрлэг, өрхтэй хамтран ажиллах зорилтыг дэвшүүлэн, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Манай сургуулийн барилгын их засвар, дулаалгын ажлыг “Саран Инж” ХХК гүйцэтгэж нийгмийн хариуцлагаа ухамсарлан хогийн цэгийг шинэчлэхэд блок болон талбайг цементлэх ажилд дэмжлэг туслалцаа үзүүлсэнд талархаж байна.



**Т.Шижирмаа (Нийслэлийн ЕБ-ын 65 дугаар сургуулийн нийгмийн ажилтан, дэмжих багийн ахлагч):**

Энэ хичээлийн жилд сургууль маань гадна өнгө төрхөө өөрчилж, тохь тухтай тавлаг орчин бүрдүүлэн, багш, сурагч, ажилчдаа угтан авлаа. Урлаг, спортын заал дулаан, анги танхим тав тухтай болсноор сурагчдын өвчлөл өмнөх оны 10 дугаар сартай харьцуулахад 20 хувиар буурсан үзүүлэлт гарлаа. Энэ нь “Монгол дах барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн үр дүн гэдгийг тэмдэглэх нь

зүйтэй. Эрүүл аюулгүй, сурч хөгжих, таатай орчин бүрдэж, тохилог дулаахан нөхцөлд ажиллах болсондоо сэтгэл хангалуун байна.



**Ж.Отгонбаяр (Нийслэлийн ЕБ-ын 65 дугаар сургуулийн технологийн багш):**

Энэ онд сургууль дээрээ хэрэгжиж байгаа “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төсөл”-ийн хүрээнд зохион байгуулалтад орсон “Дэмжих баг”-ийн гишүүнээр ажиллаж байна. Бид нар дэмжих багаараа “Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” аргачлалын дагуу сургуулийн гадаад, дотоод орчин болон барилгын их засвар, дулаалгын өмнөх, дунд, сүүлийн шатанд үнэлгээ хийж зөвшилцлийн хуудсаа боловсруулан ажилласан. Энэ ажлын хүрээнд дулаан алдалтад нөлөөлдөг хүчин зүйлийг илрүүлэн, дулаалгын ажлын явцыг өдөр тутам хянаж, чанартай хийж гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллалаа. Сургуулийн анги танхим, коридор дулаахан болсноор сурагчдын сурах идэвх, оролцоо сайжирч байгаа нь харагдаж байна.

**Д.Оюунжаргал (Нийслэлийн ЕБ-ын 65 дугаар сургуулийн 5д ангийн сурагч Н.Доржнамжилын ээж):**



Миний бие Сонгинохайрхан дүүргийн 3 дугаар хороонд оршин суудаг. Нийслэлийн ЕБ-ын 65 дугаар сургуульд миний 3 хүүхэд суралцаж байна. Хүүхдүүдээ сайн иргэн болж төлөвшүүлэхийн төлөө эцэг эхийн зүгээс сургуулийн захиргаа, багш нартай нягт уялдаатай хамтран ажиллах нь чухал гэж боддог. Энэ ч үүднээс төслийн хүрээнд байгуулагдсан дэмжих багт орж ажилласан. Дэмжих багийн зүгээс сургуулийн гадаад, дотоод орчинд үнэлгээ хийхэд хогийн цэгийг шинэчлэх шаардлагатай болох нь илэрхий болсон. Энэ саналыг захирал Ч.Хишигмаад танилцуулж, хамтран ажилласны үр дүнд хогийг ангилан ялгах боломжтой, шинэ цэгийг байгуулсан. Энэ нь хүүхдүүдэд сургууль, гэр

бүлийн орчинд хогийг ангилан ялгах дадалд сургах ач холбогдолтой гэж үзэж байна. Бид нарын эхлүүлсэн энэ ажлаас иргэд санаа авч, хашаандаа хогийг ангилан ялгаж хаях ажлыг эхлүүлсэн нь бидний зорилго биелэгдсэний нэгэн илрэл гэж үзэж байна.

## ХОЛИВОЛ ХОГ - АНГИЛБАЛ БАЯЛАГ

| | |
|---|---|
| Зорилго | Хог хаягдлыг ангилан ялгах, зөв дадал хэвшлийг багш, ажилчид, сурагч, эцэг эх, асран хамгаалагчдад төлөвшүүлэх, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх |
| Нөхцөл байдал тулгамдсан асуудал | Манай хогийн цэг сургуулийн зүүн талд 50 метрийн зайд байрладаг, 4184 сурагч, 200 багш ажилчдаас гарах хог хаягдлыг агуулдаг ч нийт 8 мкв хэмжээтэй. Сард 10-15 тонн хог хаягдал гардаг. Үүнийг сард 2-3 удаа ачихад нэг удаагийн ачилтын хөлс 85,000 төгрөг, сард 170,000-255,000 төгрөг зарцуулдаг. 2017 онд одоогийн хогийн савыг блокоор өрж, шат хийн шинэчилсэн. Гэвч энэхүү хогийн сав нь стандартын дагуу хийгдээгүй, шаардлага хангахгүй болох нь дэмжих багийн хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад илэрхий болсон.<br><br>**Өөрөөр хэлбэл, хогийн сав нь:**<br>- Дээвэргүй учраас бороо, цасны ус орж ялзрал үүсгэж, хөрсний бохирдол бий болгодог. Мөн салхинд хийсэж орчны бохирдол үүсгэдэг).<br>- Ангилан ялгах боломжгүй<br>- Хаалга жижиг, ачихад хүндрэлтэй<br>- Шалгүй, тэмдэг тэмдэглэгээ, хаяггүй<br>- Хог түүдэг хүмүүс орж хог авдаг. Ингэхдээ хаалга үүдийг онгорхой орхих, нохой орох зэрэг асуудал үүсгэдэг.<br>Дээрх байдал сургууль орчны ариун цэвэр, эрүүл ахуйн орчинд сөргөөр нөлөөлж, хөрсний болон агаарын бохирдлын хэмжээг нэмэгдүүлж байгаа олж тогтоосон. |
| Зорилтот бүлэг | 111 бүлгийн 4,184 сурагч, 201 гаруй багш ажилчид, 8,100 гаруй эцэг эх |
| Шалгуур үзүүлэлт | • Хогийн цэгийн талбайн нэмэгдсэн тоо хэмжээ (мкв)<br>• Хогийг хэрхэн ангилан ялгах тухай мэдээлэл өгөх сургалтад хамрагдсан багш, сурагч, эцэг эхийн тоо<br>• Анги, коридорт ангилан ялгах хогийн савыг байршуулсан тоо |

| | |
|---|---|
| | • Сургууль, ангийн группт байршуулсан хог ангилан хаях тухай нөлөөллийн уриалгыг үзсэн багш, сурагч, эцэг эхийн тоо<br>• Хяналт-шинжилгээ, үнэлгээнд оролцсон эцэг эх, сурагчдын тоо<br>• Хог ангилан хаях тухай нөлөөлөх сургалтад хамрагдсан бага ангийн сурагчдын тоо |
| Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат | Сургуулийн хогийн цэгийг шинэчлэх ажлын төлөвлөгөө зураглал гарган дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>**Үүнд:**<br>- Дэмжих багийн гишүүд сургуулийн гадаад орчин, анги танхимын өнөөгийн нөхцөл байдалтай биечлэн танилцсан. Дэмжих багийн гишүүд санал нэгтэй хогийн цэг болон хог хаягдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр шийдэж, хяналтын хуудсаа боловсруулсан.<br>- Хяналтын хуудасны дагуу дэмжих багийн гишүүд үнэлгээ хийн, санал солилцож, ажигласан зүйлсээ багаараа ярилцаж, хогийн цэгт тулгамдаж байгаа асуудлуудын жагсаалт гаргасан.<br>- Тулгамдсан асуудлуудаа шийдэхийн тулд хогийн цэгийг шинэчлэх, нөлөөллийн ажил зохион байгуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн.<br><br>**Ингэхдээ:**<br>- Хуучин хогийн цэгээ буулгаж орчныг цэвэрлэж зургийн дагуу 6 м урттай, 2 м өргөнтэй суурь цутгасан.<br>- Газрын хөрсний бохирдлоос сэргийлэн шалыг 10 см зузаантай цутгасан.<br>- Ханыг 20-ийн блокоор, тусгаарлалтын 3 хана босгон өрж хийсэн. Ханыг өрөхдөө ангилан ялгах 3 цонх гаргасан.<br>- Дээврийн усны уналтыг тооцоолон налуу гөлмөн төмрөөр 30 градусын налуу хийсэн.<br>- Хогийг гадна талаас нь ачих зориулалт бүхий том гүйдэг хаалгыг гөлмөн төмрөөр хийж цоожтой болгосон.<br>- Хогийн цэгийн орчныг хүүхдийн аюулгүй байдлыг хангаж 42 мкв талбайг цементэлж, машин хааж зогсохоос сэргийлэх зорилгоор хашаа хийж хаалга гаргасан.<br>- Хогийг ангилан ялгах цаас, хуванцар, ахуйн хогны тэмдэг тэмдэглэгээг 3 цонх тус бүрд хийсэн. |

| | |
|---|---|
| | - Сургуулийн анги тус бүрд 3 сав буюу нийт 150 хогийн сав, сургуулийн "А, Б" байрны давхар бүрд хогийг ангилан ялгаж хийх 36 хогийн савыг байршуулсан.<br>- Нийт 12 мкв талбайтай ангилан ялгах хогийн цэгийг шинэчлэн барьсан.<br>- Хог хаягдлын менежментийн чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн хүн урьж сургууль дээрээ сургалт зохион байгуулсан.<br>- Хогийг ангилан ялгах нөлөөллийн танилцуулга хуудас хийж хороо, багш, сурагчдын олон нийтийн сүлжээний групп дээр байршуулсан. |
| Хүрсэн үр дүн богино хугацаанд гарсан өөрчлөлт | • Сургуулийн гаднах хогийн цэг өмнө нь стандартын бус, 10 мкв байсан бол шинэчлэгдэн талбайн хэмжээ 12 мкв болж нэмэгдсэн.<br>• Сургуулийн анги бүр хог ангилан ялгах савтай болсон нь сурагчид хогийг ангилан ялгаж хаях дадалтай болсон.<br>• Хог хаягдлын цэгийн шалыг 10 см зузаантай цементэлж, дээвэр хийснээр агаарын болон хөрсний бохирдол үүсэхгүй болсон.<br>• Сургуулийн коридорт ангилан ялгах хогийн савыг байршуулсан нь үйлчилгээний ажилчдын цагийг хэмнэх, ууттай хогоо шууд хогийн цэг дээр хаяхад хялбар болсон.<br>• Сургуулийн эцэг эхийн зөвлөлийн дарга нарт "Хогийг хэрхэн ангилан ялгах" сэдвээр сургалтыг зохион байгуулахад 116 эцэг эх оролцож, гэр, гудамж, хашаандаа хогийг ангилан ялгахыг уриалж ажиллахаа илэрхийлсэн.<br>• Эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх дэмжих багийн 11 гишүүний хоёр нь сургуулийн 9, 12 дугаар ангийн сурагчид байсан.<br>• Бага ангийн 1-5 дугаар ангийн 2,520 сурагчид болон 80 дугаар цэцэрлэгийн 350 гаруй хүүхдэд "Хогон мангас" хүүхдийн театрчилсан тоглолтыг үзүүлж хүүхдүүдэд хогийг ангилан ялгаж сурах зөв дадал хэвшилд уриалсан үр дүнтэй ажил болсон. |
| Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд | • Сургуулийн дотоод дүрэм, журам зэрэгт ангилан ялгах хогийн савыг хэрхэн ашиглах, хогийн гарцыг багасгах, эрүүл аюулгүй цэвэр, орчин бүрдүүлэхэд хүлээх үүрэг хариуцлагын тухай тусгасан.<br>• Цаашид хог ангилан ялгах асуудлыг сурагчдын баримтлах дэг журам, сурагчдын өөрөө удирдах байгууллагын зохион байгуулах үйл ажиллагаанд тусгаж ажиллаж байна. |

| | |
|---|---|
| | • Сургууль, багш, эцэг эхтэй байгуулах гурвалсан гэрээнд хог хаягдлыг ангилан хаяхтай холбоотой эцэг эх, багш, сурагчдын хүлээх хариуцлагын тухай зүйл заалт нэмж оруулахаар ажиллаж байна.<br>• Сургуулиас гарах хог хаягдлыг ангилах ялгах ач холбогдлыг таниулах сургалт зохион байгуулна.<br>• Анги тус бүрийн цаасны болон хуванцар савны хогийг хэмжиж, аль ангиас илүү их хог гарч байгааг хянаж, дүгнэлт хийж зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллана.<br>• Гадаа хогийн цэг дээр хуримтлагдсан хуванцар савыг тушааж мөнгөөр нь коридорын хогийн савнуудад цэнхэр, шар, ногоон уутыг авч бэлтгэх ажлыг тогтмолжуулахаар ажиллаж байна.<br>• 3 дугаар хороотой хамтран 250 айл өрхийг ангилан ялгах хогийн цэгтэй болох төслийн үйл ажиллагааг дэмжин ажиллана. |
| Тулгарсан бэрхшээл, эрсдэл | Бид өмнө нь сургуулийн эцэг эхийн зөвлөлтэй хамтран сургуулийн орчны эрсдэлийн үнэлгээг хийж байсан. Энэ үед хогийн цэгийн асуудлыг харж байгаагүй. Сургуулийн удирдлага, багш, ажилтан, сурагч, эцэг эхчүүдэд хогийг ангилан ялгаж хаяхын ач холбогдлын талаарх мэдлэг, ойлголт дутмаг байсан нь хамгийн том бэрхшээл болон тулгамдаж байсан. |
| Амжилтад нөлөөлсөн хүчин зүйл | • Энэхүү амжилтад хүрэхэд багаар ажиллах чадвар их нөлөөлсөн. Багаар хамтран ажилласны үр дүнд ажлын төлөвлөгөөгөө хамтран боловсруулж, мэдлэг мэдээллээ харилцан солилцож ажиллалаа.<br>• Багийн гишүүд, багш, ажилтан, эцэг эх, сурагчдын идэвх оролцоо, хандлага энэ төрлийн ажлыг зохион байгуулахад чухал үүрэгтэй байсан.<br>• Ийнхүү амжилт гаргахад сургуулийн захиргаа, Саран инж ХХК-ийн дэмжлэг, дэмжих багийн гишүүдийн оролцоо зэрэг нь ээрэг нөлөө үзүүлсэн. |
| Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс | • Мэргэжлийн байгууллагын заавар зөвлөгөөг авч ажиллах<br>• Дэмжих багийн гишүүд болон багш ажилтан, эцэг эх, сурагчдыг чадавхжуулах, мэдлэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах<br>• Эцэг эх, багш, сурагчдаас гарсан санал, дэмжлэгт тулгуурлан ажиллах<br>• Сурагчдыг “Хогийг ангилан ялгах” дадал хэвшилд 100 хувь сургахад няхуур хандан ажиллах |

| | |
|---|---|
| Холбоо барих хаяг, лого | **Сонгинохайрхан дүүрэг 3 дугаар хороо Ерөнхий боловсролын 65 дугаар сургууль**<br>Захирал Ч.Хишигмаа ажил утас: 70172654, гар утас: 99179105<br>Цахим хаяг: khishigmaa9105@gmail.com<br>Нийгмийн ажилтан Т.Шижирмаа Утас: 89891596<br>Цахим хаяг: shijirmaaterbish@gmail.com<br>Багш: Ж.Отгонбаяр утас: 99841065<br>Цахим хаяг: JambalOtgonbayar@gmail.com |

## БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДУЛААЛГЫН ЯВЦАД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУРШЛАГА

| | |
|---|---|
| Зорилго | Сургуулийн их засвар, дулаалгын ажлыг чанартай хийж гүйцэтгэхэд эцэг эхийн оролцоотой хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх |
| Нөхцөл байдал тулгамдсан асуудал | • Дэмжих багийн гишүүдийн ажигласнаар засвар дулаалгын ажил хийж буй ажилчид ажлын хувцас дутуу өмссөн, бэхэлгээгүй байсан нь хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдахад хүргэж байсан.<br>• Барилгын хог хаягдал их хэмжээгээр овоорсон ч цаг тухайд нь ачиж цэвэрлэхгүй байсан.<br>• Цонх суурилуулахад цонхны тавцангийн хөндийд дулаалга, дүүргэлт хийхэд анхаарах шаардлага бий болсон байсан.<br>• Цонх суурилуулсны дараа тавцангийн тэгш байдалд анхаарах, гадна талд усны хаялгыг стандартын дагуу хийхэд онцгой анхаарах шаардлага бий болсон.<br>• Дээврийн дулаалгын хөөсөнцрийг хийхэд зөрлөгийг анхаарах, дээврийн цутгалтын явцдаа усны уналтыг тооцоолоход хяналт тавих хэрэгтэй байсан.<br>• Суурийн дулаалгын цементийг зүсэхдээ ажилчдын аюулгүй байдлыг анхаарах, ухаж гаргасан хог хаягдлыг холдуулах, цонхыг суурилуулахад интернэт, холбооны утас, кабелийг таслахгүйгээр шилжүүлэн байрлуулах хэрэгтэй болсон.<br>• Ажилчид ажлаас буухдаа барилгын багаж хэрэгслээ сайтар цэгцэлсэн (бороотой үед цахилгааны залгуурыг ил орхихгүй байх) эсэхэд хяналт тавих хэрэгцээ ч нэмэгдэж байв.<br>Эдгээрээс үүдэн сургуулийн их засвар, дулаалгын ажлыг чанартай хийж гүйцэтгэхэд эцэг эхийн оролцоотой хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай болсон. |

| | |
|---|---|
| Зорилтот бүлэг | Барилгын ажил гүйцэтгэгч Саран-Инж ХХК-ны 22 ажилтан, фасадын 13 ажилтан, сургуулийн 9 ажилтан, талбайн 4 инженер, сургуулийн сурагч, багш, ажилтнууд |
| Шалгуур үзүүлэлт | • Дээврийн ажлын гүйцэтгэлийн хувь<br>• Цонх солих ажлын гүйцэтгэлийн хувь<br>• Суурийн дулаалгын гүйцэтгэлийн хувь<br>• Гүйцэтгэгч компанийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажилласан ажилтны тоо<br>• Барилгын ажлын гүйцэтгэл, хувиар |
| Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат | Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах байдлаар барилгын ажлын явцад хийлээ.<br>**Үүнд:**<br>• Дээврийн ажлыг эхлэхийн өмнөх цэвэрлэгээний ажлыг 100 хувь хийлгүүлэн дулаалгын бэлтгэл ажлыг хангасан.<br>• Дээврийн парпетийг зургийн дагуу тоосгоор 100 хувь өрж дуусгахад хяналт тавьж ажилласан.<br>• Дээврийн цутгалтыг хийхдээ усны уналтыг зургийн дагуу хийж, цоргыг суурилуулахад налууг анхаарах хэрэгтэй байгаа талаар зөвлөн зургийн дагуу ажлыг хийлгүүлсэн.<br>• 216 цонхны амлагааг суллаж, цонх суулгах бэлтгэл ажлыг хангах, цонх суулгахдаа тавцангийн тэгш байдал, амлагааг зургийн дагуу гүйцэтгэсэн эсэхэд хяналт тавьсан.<br>• Цонхыг суурилуулахдаа интернэтийн утас, кабелийг таслахгүйгээр хийх, суурийн дулаалгын ажилд хяналт тавьж ажилласан.<br>• Барилгын ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах талаарх талбайн ХАБ-ын инженерт болон ажилтнуудад анхааруулж ажилласан болно. |
| Хүрсэн үр дүн, богино хугацаанд гарсан өөрчлөлт | • Аюулгүй байдлыг хангаж ажиллахад ХАБ-ын инженерийн хамтаар хяналт тавин ажилласнаар барилгын ажилтнууд 100 хувь хамгаалах хувцас хэрэглэлээ бүрэн өмсөж хэвшсэн.<br>• Барилгын хог хаягдлыг тухай бүрд 3 удаа ачуулж талбайг цэвэрлүүлсэн. Ажил эхлэхийн өмнөх цэвэрлэгээний ажлыг 100 хувь хийлгүүлэн засварын ажлыг хийж дуусгуулсан.<br>• 216 цонхыг стандартын дагуу суурилуулсан, амлагаа болон тавцанг суурилуулах ажил хэвийн явагдаж дууссан.<br>• Барилгын ажлын явцад эрүүл аюулгүй байдлыг хангаж ажиллахын зэрэгцээ санамж, анхааруулах тэмдэг тэмдэглэгээг хэрэглэж сурсан. |

| | |
|---|---|
| Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд | • Барилгын дээвэр, цонх, хаалга, фасадын чанарт хяналт тавьж шалгах ажлыг сургуулийн мужаан, цахилгаанчин, слесарийн ажлын байрны тодорхойлолтод нэмэлтээр оруулж өгөхөөр ажиллаж байна.<br>• Улирал бүр дэмжих багаараа барилгын дулаан алдалтыг хянаж, харьцуулалт хийж, сургуулийн захиргаа болон барилга хариуцсан компанид мэдээлэх зорилгоор ажлаа эхлүүлээд ажиллаж байна.<br>• Сургуулийн их, бага засварын явцад хяналтын хуудас боловсруулан хяналт- шинжилгээ үнэлгээ хийх үйл явцыг хэвшил болгон ажиллахад анхаарч байна.<br>• Зөвшилцлийн хуудас боловсруулан холбогдох хүмүүст мэдэгдэж багш, ажилтны эрүүл аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.<br>• Сургуулийн ХАБ-ын багийн үйл ажиллагааны ажлын төлөвлөгөөнд засварын явцад эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хамтран ажиллах заалтыг оруулах боломжийг судалж байна. |
| Тулгарсан бэрхшээл, эрсдэл | • Цаг агаарын эрсдэлт байдал, хөрөнгө оруулалт саатсанаар хугацаа алдаж, барилгын засварын ажил удаашрахад нөлөөлж байсан.<br>• Барилгын ажил гүйцэтгэх компанийн ажилтнууд цаг баримталж хэвшээгүй нь ихээхэн бэрхшээл болж байсан. Дэмжих багийн гишүүдийн идэвх оролцоо харилцан адилгүй байсан нь үйл ажиллагаанд бэрхшээл болж тулгамдаж байсан. |
| Амжилтад нөлөөлсөн хүчин зүйл | • Талбайн инженер, ХАБ-ын инженер, GIZ-ын инженер, сургуулийн удирдлагатай байнгын холбоотой ажиллаж байсан нь амжилтад хүрэхэд эерэг нөлөө үзүүлсэн.<br>• Дэмжих багийн гишүүд, засварын ажлыг гүйцэтгэгч компани байнгын эргэх холбоотой ажилласан.<br>• Дэмжих баг цаг заваа гарган өдөр тутмын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан нь амжилтад хүрэхэд нөлөө үзүүлсэн болно. |
| Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс | • Эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хяналтын хуудсаа тун няхуур, багийн гишүүдийн оролцоог ханган, харилцан ярилцаж боловсруулах<br>• Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж, хандлагыг өөрчлөхөд ажлаа чиглүүлэх<br>• Хамтран ажиллаж буй компанийн удирдлага, ажилтнуудтай харилцан ойлголцох, эргэх холбоог тогтоох зэргийг цаашид |

| | |
|---|---|
| | энэ чиглэлээр ажиллах сургуулиуд анхааран үзэх шаардлагатай юм. |
| Холбоо барих хаяг | **Сонгинохайрхан дүүрэг 3 дугаар хороо Ерөнхий боловсролын 65 дугаар сургууль**<br>Захирал Ч.Хишигмаа ажил утас: 70172654, гар утас: 99179105<br>Цахим хаяг: khishigmaa9105@gmail.com<br>Нийгмийн ажилтан Т.Шижирмаа Утас: 89891596<br>Цахим хаяг: shijirmaaterbish@gmail.com<br>Багш: Ж.Отгонбаяр утас: 99841065<br>Цахим хаяг: JambalOtgonbayar@gmail.com |

## БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДУЛААЛГЫН АЖЛЫН ЯВЦАД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Дүүрэг: Сонгинохайрхан Байгууллага: 65 дугаар сургууль

Огноо: 2020 оны 8 дугаар сарын 13

| **БАРИЛГЫН ЗАСВАРЫН АЖЛЫН ҮЙЛ ЯВЦ ЭХЭЛСНЭЭС ХОЙШ ЦУГЛУУЛАХ МЭДЭЭЛЭЛ** | | | |
|---|---|---|---|
| **Шалгуур** | | **Тэмдэглэгээ** | **Тайлбар/дэлгэрэнгүй** |
| 3.1 | Барилгын зураг төсөлд тэмдэглэгдсэн бүх цонх, гадна хаалгыг шинэчлэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ **Ажил эхлэх шатандаа**<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | Хуучин цонх болон тавцан авах, суллах ажил явагдаж байна. Хаалга солих ажил эхлээгүй байна. |
| 3.2 | Цонх, хаалганы байрлал түүний ус тусгаарлалт, битүүмжлэлийн үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ **Ажил эхлэх шатандаа**<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | Цонх ирээгүй байна. “Хаан” цонхны ажилчид ирж, цонх нэг бүрийг хэмжиж олон янзын хэмжээтэй байгааг барилгын ажил гүйцэтгэгчтэй ярилцсан. |
| 3.3 | Гадна ханыг иж бүрэн, зохих зузаанаар дулаалах үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ **Ажил эхлэх шатандаа**<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | • Хөөсөнцрийн зузаан 15 см<br>• Нягт: 25 м.куб<br>• Грунт-Формула<br>• Хөөсөнцрийн цавуу-милл хаус |

| | | | |
|---|---|---|---|
| | | | • Чулуут замаска гарал үүслийн гэрчилгээтэй |
| 3.4 | Дээврийн дулаалгыг иж бүрэн хийх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ **Ажил эхлэх шатандаа**<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | Парпетийн өрлөг явагдаж байна. Өрлөгийг тоосго, элс, цементээр дээшээ 4 үе өрж хийж байна. |
| 3.5 | Цонхны амлагаа болон дотор тавцангууд бүрэн хийгдэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ **Огт эхлээгүй**<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 3.6 | Халаалтын системийг зургийн дагуу гүйцэтгэх үйл явц | ○ **Огт тусгагдаагүй**<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 3.7 | Сантехникийн тоноглолууд иж бүрэн, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан эсэх | ○ **Огт тусгагдаагүй**<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 3.8 | Дээвэрт ус нэвтрэхгүй битүүмжлэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ **Огт эхлээгүй**<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 3.9 | Цэвэр, бохир усны шугам шаардлагатай стандартын дагуу хийгдэх үйл явц | ○ **Огт тусгагдаагүй**<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 1. | **Ажиглагдсан зөрчил, дутагдал:**<br>• Суллаж авч байгаа цонх нь  стандартын цонх биш учир авахад хүндрэлтэй байв. | | |

| | |
|---|---|
| | • Цонхны рамыг эвдэлж цонхоо салгаж байгаа тул аюулгүй байдлыг анхаарч ажиллах<br>• Гадна фасадын ажил гүйцэтгэж байгаа ажилчдын ажлын хувцас бүрэн бус<br>• Засварын ажил гүйцэтгэж байгаа ажилчдын ажлын цаг ажиглалт хангалтгүй<br>• Барилгын хог хаягдал бөөгнөрсөн байгааг цаг тухайд нь ачиж байх зохицуулалт хийх |
| 2. | **Цаашид анхаарах зүйлс:**<br>• Засварын ажил зургийн дагуу хийгдэж байгаа ч сургуулийн зүгээс талбайг чөлөөлөхөд анхаарах<br>• Барилгын бараа материалд  хяналт тавьж ажиллах<br>• Суллан авсан цонх, тавцанг  барилгын ажил явагдаж байгаа орчноо холдуулах<br>• Сургуулийн ээлжийн манаачид тухайн өдрийн ажил дуусахад барилгын материал,, багаж, техникийг хүлээлгэн өгч хэвших<br>• Гадна фасадын хөөсөнцрийн хог хаягдлыг нэг цэгт төвлөрүүлэн хураах<br>• Цахилгаанаар ажиллаж буй шатыг тогноос  бүрэн салгаж занших |
| 3. | **Барилгын их засвар, дулаалгын явцын талаарх ерөнхий дүгнэлт:**<br>Барилгын их засвар, дулаалгын явцын үнэлгээ хийх хүртэл хугацаанд засварын ажил зургийн дагуу хийгдэж байна.<br>“Саран Инж” ХХК нь гадна фасадын хөөсөнцөр, сэнстэй тэлэгчтэй шруф, крунт цавуу,<br>хар замаск болон дээврийн цемент зэргийг “МАК”, “ИЛЧ-ХӨӨС” зэрэг барилгын материал нийлүүлэгч компаниас авч стандартын дагуу хийж гүйцэтгэж байна.<br>Дээврийн парпетийг өрөхөд сургуулийн эргэн тойронд байрласан гадаах камерын утсыг таслахгүй, анхаарал болгоомжтой хийж гүйцэтгэх анхааруулав.<br>Сургуулийн дээвэр рүү гаргаж байгаа тоосго, цемент, ус зэргийг зөөвөрлөхдөө аюулгүй ажиллагаар бүрэн хангаж ажиллахыг сануулав.<br>• Цонхыг бүрэн суллаж, тавцан хураах ажлын явц - 50%<br>• Суурийн дулаалга - 40%<br>• Дээврийн дулаалга - 20%<br>• Гадна фасадын дулаалга - 40%<br>• Нийт засварын ажлын явц  37%-тай явагдаж байна. |
| **Хяналт-шинжилгээ, үнэлгээг нэгтгэсэн:** | |
| Сонгинохайрхан дүүргийн 65 дугаар сургуулийн нийгмийн ажилтан, дэмжих багийн ахлагч Т.Шижирмаа      Утас:89891596 | |

## ЗӨВШИЛЦЛИЙН ХУУДАС

<table>
<tr><td colspan="3">Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 65 дугаар сургуулийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа “Саран-Инж” компани нь “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд зохион байгуулалтад орсон “Дэмжих баг”-ийн гишүүдийн барилгын их засвар, дулаалгын ажлын явцад хийсэн эцэг эхийн оролцоот, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, санал дүгнэлттэй танилцлаа.</td></tr>
<tr><td colspan="3">Дэмжих багийн гишүүдийн тайланд туссан дараах зүйлсийг гүйцэтгэгч компани их засвар, дулаалгын явцад тусгаж ажиллахаа талууд харилцан зөвшилцлөө.</td></tr>
<tr><td colspan="3">• Дэмжих багийн гишүүдийн ажигласнаар ажилчид ажлын хувцас дутуу өмссөн, бэхэлгээгүй байсан тул ажилчдын аюулгүй байдалд анхаарах<br>• Барилгын хог хаягдал цаг тухайд нь ачиж цэвэрлэх<br>• Барилгын ард байгаа контейнерыг холдуулах<br>• Цонх суурилуулахдаа тавцангийн хөндийд дулаалга, дүүргэлт сайтар хийх<br>• Цонх суурилуулсны дараа тавцангийн тэгш байдалд анхаарах, гадна талд усны хаялгыг стандартын дагуу хийхэд онцгой анхаарах<br>• Дээврийн дулаалгын хөөсөнцрийг хийхдээ зөрлөгийг анхаарах<br>• Дээврийн цутгалтын явцдаа усны уналтыг тооцоолох<br>• Суурийн дулаалгын цементийг зөөвөрлөхдөө ажилчдын аюулгүй байдлыг анхаарах, ухаж гаргасан хог хаягдлыг холдуулах<br>• Цонхыг суурилуулахад интернэт, холбооны утас зэрэг кабелийг анхаарч, таслахаас болгоомжлон шилжүүлэн байрлуулах<br>• Ажлаас буухдаа барилгын багаж хэрэгслээ сайтар цэгцэлж занших</td></tr>
<tr><td>Дэмжих багийн ахлагч<br>Т.Шижирмаа</td><td>Хяналтын инженер<br>Д.Хандсүрэн</td><td>Компанийн захирал<br>Ч.Дэлгэрхангай</td></tr>
</table>

## ЗӨВШИЛЦЛИЙН ХУУДАСНЫ БИЕЛЭЛТ БУЮУ ДҮГНЭХ ХУУДАС

<table>
<tr><td colspan="4">Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн ЕБ-ын 65 дугаар сургуулийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа Саран-Инж ХХК болон “Дэмжих баг”-ийн гишүүдийн харилцан зөвшилцсөн ажил дор дурсан байдлаар биелэгдсэн байна.</td></tr>
<tr><td>Харилцагч талууд</td><td>№</td><td>Зөвшилцсөн ажлууд</td><td>Ажлын биелэлт</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| Гүйцэтгэгч компанийн зүгээс | 1.1 | Барилгын ажилчид ажлын хувцас дутуу өмссөн | Барилгын ажилчид ажил эхлэхийн өмнө хувцсаа бүрэн өмсөж, багаж техникээ шалгаж хэвшсэн. |
| | 1.2 | Барилгын хог хаягдлыг цаг тухайд нь ачиж цэвэрлэх | Барилгаас гарч буй хог хаягдлыг цаг тухайд нь ачиж байна. |
| | 1.3 | Цонх суурилуулахдаа тавцангийн хөндийд дулаалга, дүүргэлт хийх | Цонхыг суллан, тавцанг авсны дараа цонх суурилуулах бэлтгэл ажил болох тавцан, цонхны дүүргэлтийг  дулаалгын материал болон шингэн ба хатуу хөөсөөр хийлээ. |
| | 1.4 | Цонх суурилуулсны дараа тавцангийн тэгш байдалд анхаарах, гадна талд усны хаялгыг стандартын дагуу хийхэд онцгой анхаарах | Цонх суулгахдаа тавцангийн тэгш байдалд анхаарч, усны хаялгыг хийхдээ анхаарч ажиллав. |
| | 1.5 | Дээврийн дулаалгын хөөсөнцрийг хийхдээ зөрлөгийг анхаарах | Дээврийн тоосгоны өрөлтийг хийхдээ эргэн тойрны аюулгүй байдлыг ханга усны хаялгын нүхийг сайтар гаргаж хийлээ. |
| | 1.6 | Суурийн дулаалгын цементийг зүсэхдээ ажилчдын аюулгүй байдлыг анхаарах, ухаж гаргасан хог хаягдлыг холдуулах | Барилгын өмнөх талбайн цементийг Зүсэж, суурийн дулаалга хийх байсан боловч зөвлөх баг, барилгын гүйцэтгэгч компани  болон сургуулийн захиргаа харилцан тохиролцон зузаан байгаа тул хийхгү байхаар тохиролцов. |
| Сургуулийн зүгээс | 2.1 | Цонхыг суурилуулахдаа интернэт болон холбооны утас, кабелийг  болгоомжтой байрлуулах | Цонх суурилуулах үед анги танхимаа гарсан интернэт, цахилгаан холбоон утсыг хураан авлаа. |
| | 2.2 | Барилгын ард байгаа контейнерыг холдуулах ”Болор шоо” ХХК мэдэгдэх | Сургуулийн баруун хойно байрших контейнерыг “Болор шоо” ХХК-д мэдэгдэн 1 метрийн зайтай холдуула талбайг чөлөөлсөн. |

| | | | |
|---|---|---|---|
| | 2.3 | Барилгын  багаж материал болон цахилгааны утас кабелий хурааж занших | Тухайн өдрийн сургуулийн жижүүрт хариуцлагатай хэлж үлдээх асуудлыг харилцан шийдлээ. |
| | 2.4 | Хуучин цонх, тавцанг зөөж талбайг чөлөөлөх | Хуучин цонх, тавцанг аж ахуйн склад руу сургуулийн ажилчид, дэмжих багийн гишүүд зөөж талбайг чөлөөлсөн. |
| | 2.5 | Дэмжих багийн гишүүд хуваарийн дагуу хяналт тавьж ажиллах | Дэмжих багийн гишүүд хуваарийн дагуу хяналт тавьж ажилласан. |
| **Биелэлтийг дүгнэсэн:** | | | |
| Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 65 дугаар сургуулийн нийгмийн ажилтан, Дэмжих багийн ахлагч Т.Шижирмаа, Утас: 89891596 | | | |

# ЗУРГИЙН ЦОМОГ


















# НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 148 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ



## БИДНИЙ ТУХАЙ

Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хороо, 21 дүгээр хорооллын нутаг дэвсгэрт байрлах 148 дугаар цэцэрлэг нь 1991 онд 5 дугаар яслийн өргөтгөл нэртэйгээр байгуулагдсан бөгөөд нийт 150 хүүхдийн хүчин чадалтай. Барилга байгууламжийн хувьд инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон.

2020-2021 оны хичээлийн жилд 6 бүлэгт 260 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулан, эрүүл, аюулгүй, өсөж хөгжих нөхцөлийг хангасан сургалт хөгжлийн ээлтэй орчныг бүрдүүлэн ажиллаж байна. Нийт 28 багш ажилтантай. Мэргэжлийн багшаар 100 хувь хангагдсан, нийт багшийн 40 хувь нь “Заах аргач” мэргэжлийн зэрэгтэй.

Цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эх, гэр бүл, олон нийтийн оролцоог идэвхжүүлж, хүүхэд хамгааллын чиглэлээр 19 дүгээр хорооны хамтарсан баг болон бусад мэргэжлийн хүмүүстэй хамтран ажилладаг.

**“Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хэрэгжилт манай цэцэрлэгт**



**Д.Мөнхтуяа (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 148 дугаар цэцэрлэгийн эрхлэгч):**

Манай хамт олон “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөлд хамрагдан, цэцэрлэгийн удирдлага, багш, ажилтан, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн “Дэмжих баг” байгуулж, засварын ажилд хөндлөнгийн хяналт тавьж ажилласнаар хүүхдийн сурч хөгжих, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлж, барилгын дулаан алдагдлыг бүрэн арилгаж чадлаа. Ялангуяа эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйд суралцан, хамтран ажиллах арга барил эзэмшсэн.

Дэмжих баг нь төслийн зүгээс ирүүлсэн заавар зөвлөмжийн дагуу барилгын засварын ажлын явцад 3 шатны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийснээс гадна цэцэрлэгийн гадна ба дотоод орчны аюулгүй байдалд үнэлгээ хийж, тулгамдаж буй асуудлаа сургуулийн өмнөх боловсролын байгууллагын орчны стандарт шаардлагад нийцүүлэн шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Сурч хөгжих, ажиллах хөдөлмөрлөх ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чин сэтгэлээсээ хамтран ажилласан багш ажилтан, эцэг эх, төслийн багийнхан, “Хан Зол” ХХК-ийн хамт олонд талархал илэрхийлье.

**Х.Нямхүү (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 148 дугаар цэцэрлэгийн арга зүйч):**



Төсөлд хамрагдсанаар дулаан алдагдалгүй болж, хүүхэд сурч хөгжих, багш ажиллаж хөдөлмөрлөх тав тухтай дулаан орчин бүрдэж чадсан. Ингэснээр хүүхдийн өвчлөл буурч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2020-2021 оны хичээлийн жилд хүүхдийн ирц 17 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнө нь эцэг эх, асран хамгаалагчид хүйтэн орчинд хүүхдээ өвдчих вий гэж сэтгэл зовнидог байсан бол одоо сэтгэл ханамж өндөр, эцэг эх, багш, ажилтны хоорондын харилцаа хандлага эерэг болж, ажлын бүтээмж, эрч хүч нэмэгдсэн.

Барилгын их засвар, дулаалгын ажлын хүрээнд эцэг эх, багш, ажилтнаас бүрдсэн “Дэмжих баг”-ийн гишүүд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга барилд суралцаж, барилгын дулаалга хийх арга технологийн талаарх мэдлэгтэй болж, сурч мэдсэн зүйлсээ ажил болоод амьдрал ахуйдаа хэрэгжүүлэх чадвартай болсон нь бидний ололт байлаа.

**Г.Ариунчимэг (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 148 дугаар цэцэрлэгийн дунд бүлгийн багш):**



19 дүгээр хороо нь 2-5 настай хүүхэд олон, цэцэрлэгийн хүрэлцээ муутай. Манай цэцэрлэгт хүүхдээ суралцуулах хүсэлтэй эцэг эх олон байдаг.

Өмнөх жилүүдэд бид анги танхимынхаа цонх, хаалга үүдээ эсгийгээр дулаалж, 2 давхрын ангиуд цахилгаан халаагуур ашигладаг байсан. Анги танхим хүйтэн, сэрүүн, чийгтэй, агааржуулалт муу, бүлгийн өрөө +18 хэмтэй байдаг байлаа. Төсөлд хамрагдаж, барилгын дулаалгын засвар хийснээр +23 хэмийн дулаан болж, бага насны хүүхэд сурч хөгжих, ажиллах тав тухтай нөхцөл бүрдлээ. Эцэг эхчүүд нимгэн хөнгөн хувцастай, эрүүл, аюулгүй орчинд хүүхдээ суралцуулж байгаадаа сэтгэл хангалуун байна.



**Н.Бүрэнжаргал (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 148 дугаар цэцэрлэгийн туслах багш):**

Манай бүлэг 2 давхарт байрладаг. Төсөл хэрэгжихээс өмнө манай ангийн хана хөлөрч, ус урсдаг, дулаан алдагдал ихтэй, булан тохой мөөгөнцөртсөн, хүүхэд болон багш бид нар ханиад томуу хүрч, өвчлөл ихтэй байдаг байсан. Цэцэрлэг маань энэ төсөлд хамрагдан, барилгын их засвар, дулаалга хийснээр анги танхим дулаан болж, хүүхдүүд нимгэн хувцастай тоглож наадаж байгааг харахад маш их баяртай байна. Багш ажилтан бидний хувьд ч ажиллаж хөдөлмөрлөх ая тухтай орчин бүрдсэн нь сайшаалтай.

**Л.Ариунжаргал (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 148 дугаар цэцэрлэгийн ахлах тогооч):**



Барилгын их засвар, дулаалгын ажил хийгдэхээс өмнө гал тогооны цонх дулаан алдагдал ихтэй, цонхны ус плитан шал руу гоожиж, халтирч унах, бэртэж гэмтэж болзошгүй, байнга арчиж цэвэрлэдэг байлаа. Гал тогооны хана тааз хөлөрч, хүнсний түгээлтийн хаалга өвөлдөө хөлдөж, мөс тогтож, алхаар цохиж цэвэрлэж, хүнсээ авдаг, хаалга цантаж, мөстөн, онгойлгоход цаг хугацаа алдах, даарах зэрэг бэрхшээл тулгарч байсан. Одоо эдгээр бэрхшээл арилж, ажлаа хийх аюулгүй орчин бүрдсэн нь бидэнд таатай байна.

**Р.Ганчимэг (Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 148 дугаар цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл):**




2018 онд миний хүү тус цэцэрлэгт элсэн орсон. Өвлийн улиралд орой хүүхдээ цэцэрлэгээс нь хүлээж авахад хөл, гар нь хүйтэн, байнга ханиад хүрдэг байсан. Хүүхдээ ханиадтай үед гэрээр асарч, ажлаа орхигдуулах тохиолдол хааяа гарна. Бүлгийн багшаас дулаалгын их засварын үед хяналт тавих дэмжих багт ороох гэсэн саналыг хүлээн авч, 2020 оны 4 дүгээр сараас хамтран ажиллах болсон.

Дэмжих багийн гишүүнээр ажиллах үед засварын явцад илэрсэн зөрчлийг тухайн бүрд нь харилцан ярилцан, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар зөвшилцөж байлаа. Ажил гүйцэтгэх компанийг тендерт шалгаруулахдаа санхүүгийн суурь хөрөнгийг сайтар нягталж сонгох нь чухал санагдсан.

## АЮУЛГҮЙ ОРЦ ГАРЦЫГ НЭЭЖ, ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛСЭН НЬ

| | |
|---|---|
| **Зорилго** | Цэцэрлэгийн орчинд хүүхдэд аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх, гадаад орчныг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлсэн бүс болгох |
| **Нөхцөл байдал, тулгамдсан асуудал** | • Тус цэцэрлэгийн барилга 1991 онд Октябрийн районы 5 дугаар яслийн өргөтгөл нэрээр баригдаж, 1997 онд татан буугдаж, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэдэлд шилжсэн. 2015 онд 2 байгууллагыг тусгаарлах хашаа, хаалга хийсэн. Гэвч манай цэцэрлэг дамжин ордог ганцхан хаалгатай, иргэд тээврийн хэрэгслээ дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн хаалганы ойролцоо, хашаа дагаж байрлуулсан тохиолдолд манай цэцэрлэг эмнэлэг, цагдаа, онцгой байдлын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нэвтрэхэд боломжгүй байсан.<br>• Ялангуяа хүнс түгээлтийн машин орж ирэхэд саадтай, автомашин хаалга хааж зогссоноос цаг алддаг, хүнсээ буулгалгүй буцдаг, хүүхдийн хоол хүнс тасалдах зэрэг бэрхшээлтэй тулгардаг. Яаралтай тусламж үйлчилгээ авах тээврийн хэрэгсэл цэцэрлэг рүү шууд нэвтрэх боломжгүй байсан учир шинэ хаалга гаргах шаардлагатай болсон. |
| **Зорилтот бүлэг** | Тус цэцэрлэгийн 28 багш ажилтан, 2-5 насны 260 хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчид |
| **Шалгуур үзүүлэлт** | • Цэцэрлэгийн гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчны (MNS6558:2015) стандартыг мөрдөн бүрдүүлсэн байдал<br>• Хүүхдийг осол гэмтлээс хамгаалахын тулд гадаад, дотоод орчны үнэлгээг хийх талаар ажлын төлөвлөгөөндөө тусган, хэрэгжилтийг хангаж ажилласан байдал<br>• Цэцэрлэгийн ойр орчмын авто зам нь зайлшгүй замын тэмдэг, тэмдэглээтэй байх гэсэн шаардлагыг хангасан байдал |
| **Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат** | • Дэмжих багийн гишүүдийг чадавхжуулах, багш ажилтны хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулж, хүүхдийн эрүүл аюулгүй байдлыг хангах зорилгоор "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчны (MNS6558:2015) стандарт"-ын мэдлэг олгох сургалтыг зохион |

| | |
|---|---|
| | байгуулсан. Уг сургалтад нийт 25 багш ажилтан, дэмжих багийн гишүүд хамрагдсан.<br>• Цэцэрлэгийн гадна орчинд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүднээс гишүүд бодит байдалтай газар дээр нь танилцаж, мэдээлэл цуглуулан, тулгамдсан асуудлыг тодорхойлж, хяналтын хуудсаа хамтран боловсрууллаа. Дэмжих багийн гишүүн бүрийн цуглуулсан мэдээлэл, үр дүнг нийт багш ажилтанд танилцуулан, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нэвтрэхэд зориулсан хаалга хийхээр шийдвэрлэн, ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллав.<br>**Үүнд:**<br>• Орчны аюулгүй байдлын зураглал гаргав.<br>• Хаалга хийхэд шаардлагатай материалын орц нормыг тооцон, үнийн судалгаа хийн, шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргаж, ажил үүргийн хуваарийг гаргав.<br>• Дотоод нөөц бололцоогоо ашиглан цэцэрлэгийн урд байрлуулсан ашиглахгүй байгаа гүйдэг хаалгыг баруун урд хэсэгт шилжүүлэн байрлуулж, хуучин трубаг ашиглан 30 метр урт хашлага хийж, манаач нар өөрсдөө гагнаж, баг,ш ажилтан, эцэг эхчүүд цэцгийн үр авчран 40 м$^2$ талбайд цэцэг тарьж, зүлэгжүүлэв.<br>• Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх талаар эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан 6 цахим, зөвлөмжийг багш бүр бэлтгэн бүлгийн facebook группүүдэд байршуулан, нийт эцэг эхэд сурталчлан ажилласан.<br>• “Хүүхэд зорчиж байна” ТББ-тай хамтарч “Аав аа ээж ээ намайг автомашинаас хамгаалаач, Дураараа биш дүрмээрээ, Хүүхэд зорчиж байна, Энд гарц хэрэгтэй байна” гэсэн 4 ширхэг тэмдэг байршуулсан. |
| **Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)** | Цэцэрлэгийн гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг бүрдүүлэхийн тулд сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчны (MNS6558:2015) стандартыг мөрдөн ажилласнаар дараах үр дүнд хүрсэн.<br><br>**Үүнд:**<br>• Шинээр 4 метр 20 см өргөнтэй, өндрийн тусгаарлалтгүй хаалга гаргаж, гарц орцын тоог нэгээр нэмэгдүүлсэн. Энэхүү гарц, орцыг хийснээр болзошгүй гал түймрийн |

| | |
|---|---|
| | аюулаас аврах, яаралтай тусламж үзүүлэх боломжтой болсон.<br>• Хүүхдийн хоол хүнс, бусад ачаа бараа зөөх нөөц хаалгатай болсон.<br>• Цэцэрлэгийн баруун талд тусгай зориулалтын хаалга хийсэн ч шинээр ашиглалтад орсон 90 дүгээр байрны оршин суугчид цэцэрлэг рүү орох хаалгыг хааж, автомашинаа байрлуулах болсон. Үүнээс сэргийлж хашлага хийж, цэцэг тарин, ногоон байгууламжийг 40$м^2$-аар нэмэгдүүлж, 210$м^2$ болсон. Гадна талбайн ногоон байгууламж 14 хувиар нэмэгдсэн.<br>• Мэргэжлийн байгууллага болох Ус сувгийн удирдах газарт хандан, цэцэрлэгийн хашааны гадна талд байрлах явган хүний замын дэргэдэх 2 бохирын худгийг зориулалтын тагтай болгосноор орчны тохижилтыг 20 хувиар сайжруулсан.<br>• Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх талаар эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан нөлөөллийн ажлын үр дүнд аливаа эрсдэлд орсон хүүхэд байхгүй болно.<br>• Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан цахим хичээл, зөвлөмж, анхааруулгыг бүлгийн facebook группэд тогтмол байршуулснаар эцэг эхийн хандалт нэмэгдэж, багштай хамтран ажиллах, мэдээлэл солилцох боломж нээгдсэн. Багш нарын цахим хичээл бэлтгэх ур чадвар нэмэгдэж, өөрийгөө хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай байна. |
| **Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд** | • Эцэг эхийн оролцоо, үүрэг хариуцлагыг сайжруулах зорилгоор цэцэрлэгийн гурвалсан гэрээнд хоёр заалтыг шинээр тусган, хагас жил тутам үр дүнг дүнг тооцон ажиллаж хэвшсэн.<br>• Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журамд “Дотоод хяналтын нэгж, дэмжих баг нь хамтран хяналтын хуудас ашиглан, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийнэ” гэсэн нэмэлт өөрчлөлт оруулсны дагуу сургалтын орчинд тулгамдаж буй асуудлыг илрүүлэх зорилгоор улирал тутам хөндлөнгийн үнэлгээ хийх арга барилд суралцсаар байна.<br>• Дэмжих багийн гишүүд өөрийн ажил, мэргэжлийн онцлогийн дагуу “Эцэг эхийн зөвлөл”-тэй хамтран эцэг эхийн боловсролд зориулсан сургалтыг улирал бүр зохион байгуулж байна. |

| | |
|---|---|
| | Үүнд:<br>• Дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн “Бэлтгэл-1” бүлгийн Бадамдашийн аав Пүрэвсүрэн, “Цагаан хясаа” шүдний эмнэлгийн эмч “Бэлтгэл-1” бүлгийн Ариунбиелэлийн ээж Сайнзаяа, ОБЕГ-ийн мэргэжилтэн Арвинбаяр нартай хамтран бусад эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулав. |
| **Тулгарсан бэрхшээл эрсдэл:** | • Тохижилтын ажил хийхэд зориулагдсан төсөв хүрэлцдэггүй, санхүүгийн асуудлыг хамт олны хүч, дотоод нөөц бололцоо, эцэг эхийн ажил мэргэжлийг ашиглах шаардлага тулгарсан.<br>• Эцэг эхийн оролцоо хангалтгүй, цаг баримтлах чадвар муу байсан боловч засварын ажлын үр дүнг ойлгон, хэрэгжилтийн явцад идэвхтэй оролцож эхэлсэн.<br>• Дэмжих багийн гишүүдэд мэдээллээ жигд түгээж чадаагүйгээс төлөвлөсөн ажлууд хойшлогдох, цаг хугацаа алдах зэрэг бэрхшээлийг фейсбүүк хаяг үүсгэн шийдвэрлэсэн. |
| **Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс** | • Дүүргийн “Цахилгаан түгээх сүлжээ” ХҮТ нь манай цэцэрлэгтэй залгаа байрладаг, цахилгаанчин мэргэжилтэй иргэдийн хүүхдүүд тус цэцэрлэгт олноор хамрагддаг байсан нь эцэг эхийн хүчийг ашиглах боломж байлаа.<br>• Дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааг сурталчлах “Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээг улирал бүр зохион байгуулдаг нь 28 багш ажилтныг нэг баг болон дотоод нөөц бололцоогоо ашиглан төлөвлөсөн ажлыг цаг хугацаанд нь хийж хэрэгжүүлэхэд түлхэц болсон.<br>• Багш нар хүүхдийн эрүүл, аюул осолгүй байдлыг хангах, хүүхэд хамгааллын чиглэлээр цахим хичээл бэлтгэн, фейсбүүк хуудсаар эцэг эх, хүүхдэд хүргэж ажилласнаар эцэг эх, асран хамгаалагчдаас дэмжлэг туслалцаа авах нэг хөшүүрэг болсон.<br>• Эцэг эхчүүд үр хүүхдүүдийнхээ төлөө сэтгэл гаргах зөв хандлагатай болсон.<br>• Хороо, ТББ, мэргэжлийн байгууллагууд нь төрийн байгууллагуудтай нягт хамтран ажилладаг, тулгамдаж буй асуудлыг хамтран шийдвэрлэхэд оролцсон нь амжилтад эергээр нөлөөлөв. |

| | |
|---|---|
| | • Сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчны (MNS6558:2015) стандартын талаар багш нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан нь тулгамдаж буй асуудалд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлон түүнийг шийдвэрлэх арга хэмжээг төлөвлөхөд ихээхэн дөхөм үзүүлсэн.<br>• Төслийн зөвлөх баг болон бусад мэргэжлийн хүмүүсийн байнгын зөвлөгөөг авч хамтран ажилласан явдал дээрх ажлыг амжилттай гүйцэтгэхэд нөлөөлсөн. |
| **Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс** | • Барилгын засварын ажил нь зөвхөн цэцэрлэгийн удирдлага, багш, ажилтны анхаарах асуудал хэмээн эцэг эх үзэж дээрх үйл ажиллагаанд оролцохгүй хойргоших хандлага ажиглагдаж байсан тул үйл ажиллагааны эхлэлийг тавихаас өмнө харилцан зөвлөлдөж, хамтын оролцоо, харилцан ойлголцлыг бий болгоход анхаарах<br>• Дотоод хяналтыг өдөр бүр хийж, үйл ажиллагаагаа сайжруулж байх<br>• Сургалтын орчныг бүрдүүлэх чиглэлээр батлагдсан хууль тогтоомж болон орчны стандартын талаар багш ажилтан, эцэг, эхэд сургалт зохион байгуулах, хийгдэж байгаа ажлын талаар оролцогч талуудад тухай бүр мэдээлж байх |
| **Холбоо барих Хаяг** | **Сонгинохайрхан дүүргийн 19-р хороо, 21-р хороолол, Үйлдвэрчний эвлэлийн гудамж, 148 дугаар цэцэрлэг**<br>Утас:70182287 э-шуудан: tsetserleg_148@yahoo.com<br>Эрхлэгч: Д.Мөнхтуяа, утас 94033888, tuya_duger@yahoo.com<br>Арга зүйч: Нямхүү, утас 99401699, |

## БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДУЛААЛГЫН ЯВЦАД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

| | |
|---|---|
| **Зорилго** | Эцэг эхийн оролцоонд тулгуурлан хүүхдүүдийн сурч хөгжих тохилог, дулаан орчныг бүрдүүлэх |
| **Нөхцөл байдал, тулгамдсан асуудал** | • 30 жилийн насжилттай барилгын чанар муудан, анги танхим хүйтэн, өвөлд цонх цантан, гадна орчин харагдахгүй, цантсан цонхноос шал руу ус урсаж хүүхэд хальтарч унах аюултай байсан.<br>• Хана хөлөрч, ус урсдаг тул цахилгааны холболт, унтраалга, залгуурууд чийгтэж, элэгдэж муудсан. |

| | |
|---|---|
| | Дээвэр дээрх агааржуулалтын яндан хоолой муудаж, дотогш нурж, сувгаа тагласнаас агааржуулалт муу явагддаг.<br>• Дээвэр дулаан алдагдалтай учраас 2 давхарт байрлах урлаг танхим, 3 бүлэг, 2 өрөөний хана, тааз чийгтэн хөлөрч, мөөгөнцөртөж, ханын будаг ховхорч унадаг.<br>• 2 давхрын 1 бүлэгт нэмэлтээр цахилгаан халаагуур ашигласнаас цэцэрлэгийн цахилгааны төлбөр өндөр гардаг байсан. Хүүхдүүд зузаан хувцастай учир хөдөлгөөн нь хязгаарлагдмал, хүйтэн ангид байснаар ханиад томуу хүрч, 11- 2 дугаар сар хүртэлх хугацаанд хүүхдийн ирц 50 хувь хүртэл буурдаг.<br>• Цэцэрлэгийн зүгээс мөөгөнцөртсөн ханыг зориулалтын бодисоор цэвэрлэж, аваарын хаалгыг гадна талаас эсгийгээр дулаалах, цонхны дулаалгын наалтыг шинэчлэх зэргээр шаардлагатай арга хэмжээг авч ирсэн. |
| **Зорилтот бүлэг** | Тус цэцэрлэгийн 28 багш ажилтан, 2-5 насны хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчид |
| **Шалгуур үзүүлэлт** | • Дэмжих багийн гишүүд дулаалгын их засварын ажилд 3 шатны үнэлгээ хийж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд нь засан сайжруулж ажилласан байдал<br>• “Сургалт хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын дүрэм”-ийн хэрэгжилтийн байдал<br>• Хүүхэд болон багш, ажилтны өвчлөл буурсан байдал<br>• Цэцэрлэгийн цахилгааны төлбөр хэмнэгдсэн байдал<br>• Тогтвортой байдлыг хангасан байдал |
| **Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат** | • Дэмжих багийн гишүүд, гүйцэтгэгч компанийн удирдлагууд, төслийн хяналтын инженер, нийт багш, ажилтнууд барилгын их засвар, дулаалгын ажлын явцад нийт 64 хоногийн хугацаанд өдөр тутмын хяналтыг хийсэн.<br>• Барилгын өнөөгийн нөхцөл байдлын талаарх ерөнхий дүгнэлтийг гаргаж, их засварын ажлыг гүйцэтгэхэд анхаарах зүйлсээ тодорхойлов.<br>• Барилгын их засвар, дулаалгын ажлын явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр барилгын ажлын зурагт шаардлагатай өөрчлөлтүүдийг тухай бүр оруулж, зөвшилцлийн хуудсаар баталгаажуулж, шийдвэрлэж ирсэн.<br>**Тухайлбал:** |

| | |
|---|---|
| | • Ажлын зурагт цонх баруун талд салхивчтай, салхивчийн 60 хувь доод талдаа онгойдог, дээд тал нь онгойдоггүй байсныг өөрчилж, 40 хувь нь доод талдаа онгойхгүй, 60 хувь нь дээд талдаа онгойхоор, цэвэрлэгээ хийхэд гарын зөв талд байхаар ажлын зурагт өөрчлөлтийг оруулав.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу шатыг гадна болон дотор талд хийсэн.<br>• Цахилгаанчин мэргэжилтэй аавын тусламжтайгаар нийт 6 бүлгийн цахилгааны холболт, унтраалга, залгуурын бүрэн бүтэн байдлыг шалгуулан, шаардлагатай засвар үйлчилгээг хийсэн.<br>• Засварын явцад хуучин 50 ширхэг цонхыг эвдрэл багатайгаар салган авч, Нийслэлийн өмчийн ашиглалтын газарт хүлээлгэн өгөв.<br>• Багш ажилчид дулаалгын ажлын явцад цонхны амлагаа хийх аргад суралцаж, “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага MNS 6558:2015 стандарт-ыг уншиж судлав.<br>• “Автобустай аялал”-д оролцож, төсөлд хамрагдаж байгаа бусад цэцэрлэг, сургуулиудын ололт амжилтаас харилцан суралцаж, туршлагаа хуваалцан, урам зориг авлаа.<br>• Тулгамдсан хоёр асуудлыг шийдвэрлэхийн тулд ажлын төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний дагуу нөлөөллийн ажлыг зохион байгуулж, цахим хэлбэрээр уриалга 1, зөвлөмж 3, танилцуулга 1, тайлан 2 тус тус боловсруулж, эцэг эх, багш ажилтан, олон нийтэд түгээсэн. |
| **Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд)** | • Цэцэрлэгт дулаалгын их засвар хийгдсэнээр хүүхдийн өвчлөл өнгөрсөн оныхтой харьцуулахад 2020 оны 10 дугаар сарын байдлаар 20 хувиар буурч, өрөөний хэм +24, чийгшил 40 хувьтай болж, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм мөрдөгдөж байна.<br>• Хүүхдийн эрүүл, аюулгүй байдалд багшийн санаа зовнилт арилж, өдрийн дэглэмийн дагуу бүх үйл ажиллагааг зохион байгуулснаар хүүхдийн мэдлэг, чадвар, дадал сайжирсан.<br>• Анги танхим дулаан болсон нь эцэг эхийн сэтгэл ханамжид сайнаар нөлөөлж, эцэг эх өөрсдийн санаачилгаар аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцох болов. |

| | |
|---|---|
| | • Цахилгааны төлбөрийг өмнөх оны 10-р сартай харьцуулахад 2020 оны төсөв 38.1 хувийн хэмнэлттэй гарсан байна.<br>• Багш, ажилтнууд барилгын дулаалгыг стандартын дагуу хэрхэн хийж гүйцэтгэх талаар мэдлэг төсөөлөлтэй болж, ахуй амьдралдаа хэрэгжүүлэх чадвар дадлыг эзэмшсэн. |
| **Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд** | • Дэмжих багийг бүлгүүдийн “Эцэг эхийн зөвлөл”-тэй холбож өгснөөр бусад эцэг эхэд нөлөөлж, тэдний саналыг ажилдаа тусган хэрэгжүүлснээр эцэг эцэг эх, багш, цэцэрлэг, олон нийтийн хамтын ажиллагаа сайжирсан.<br>• Цэцэрлэгт мөрдөгдөж буй дүрэм, журамд эцэг эхийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх зүйл заалтыг нэмж оруулсан.<br>• Нийт багш ажилтны саналын дагуу ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүлж, ажлын төлөвлөгөөгөө боловсруулж хэвшсэн. |
| **Тулгарсан бэрхшээл эрсдэл:** | • Хөрөнгө мөнгө саатсан шалтгаанаар засварын ажил удааширч, төлөвлөсөн хугацаандаа дуусаж чадалгүй хойшилсон.<br>• Зураг төслийг нарийвчилж гаргаагүйгээс зурагт өөрчлөлт оруулахаар зөвшилцөх, ярилцах, уулзах гэх мэт асуудлуудаас болж засварын ажил удаашрах, цаг алдах явдал гарсан.<br>• Эцэг эхчүүдийг цэцэрлэгээс зохиогдож буй аливаа ажилд хамруулахад хойрго, оролцоо бага, тогтмол цөөн тооны хүмүүс оролцдог байсан.<br>• Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүнг нийт 6 бүлгийн фейсбүүк группээр дамжуулан өдөр тутам мэдээлж байсан боловч, оролцоо хангалтгүй байв. |
| **Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс** | • Дэмжих багийн гишүүд цэцэрлэгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйд суралцаж, дадлага туршлагатай болсноор, үр дүнг нь хэрэгжүүлж, ажил сайжруулахад хувь нэмрээ оруулж байна<br>• Цэцэрлэгийн удирдлагын зүгээс бичиг баримт боловсруулахад зөвлөн тусалж, төслийн зүгээс байнга заавар зөвлөмж өгч байсан.<br>• Тулгамдаж буй асуудлыг зөвхөн удирдлага, багш, ажилтан нуруундаа үүрэх бус эцэг эх, төр болон төрийн бус байгууллагуудын хүч бололцоог ашиглан, тэдэнтэй хамтран ажиллав. |

| | |
|---|---|
| | • Багш нар хүүхдийн аюул осолгүй байдлыг хангах, хүүхэд хамгааллын чиглэлээр цахим хичээл бэлтгэн, бүлгийн фейсбүүк хуудсаар эцэг эх, хүүхдэд түгээж ажилласнаар үйл ажиллагаанд татан оролцуулах нөхцөл бүрдсэн. |
| **Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс** | • Дэмжих багийн гишүүд анхнаасаа төслийн үйл ажиллагаанд оролцсоноор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх талаар бүрэн ойлголттой болж энэ нь хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл явц, чанарт эергээр нөлөөлдөг.<br>• Үнэлгээ хийх хяналтын хуудасны асуумжаа цомхон энгийн асуулгатай, нийтлэг, дүгнэж болохуйц, оновчтой, ойлгомжтой байх талаас нь анхаарах<br>• Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад эрх зүйн баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах<br>• Дэмжих багийн гишүүдийг сонгохдоо өөрийнх нь саналыг харгалзан үзэх, гүйцэтгэх үүрэг хариуцлагыг нь сайтар ойлгуулах |
| **Холбоо барих утас, хаяг** | **Сонгинохайрхан дүүргийн 19-р хороо, 21-р хороолол, Үйлдвэрчний эвлэлийн гудамж, 148 дугаар цэцэрлэг**<br>Утас:70182287 э-шуудан: tsetserleg_148@yahoo.com<br>Эрхлэгч: Д.Мөнхтуяа, утас 94033888, tuya_duger@yahoo.com<br>Арга зүйч: Нямхүү, утас 99401699, |

## БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДУЛААЛГЫН АЖЛЫН ЯВЦАД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Дүүрэг: Сонгинохайрхан Байгууллага: 148 дугаар цэцэрлэг

Огноо: 2020 оны 7 дугаар сарын 30-ны өдөр

| **БАРИЛГЫН ЗАСВАРЫН АЖЛЫН ҮЙЛ ЯВЦ ЭХЭЛСНЭЭС ХОЙШ ЦУГЛУУЛАХ МЭДЭЭЛЭЛ** | | | |
|---|---|---|---|
| **Шалгуур** | | **Тэмдэглэгээ** | **Тайлбар/дэлгэрэнгүй** |
| 3.1 | Барилгын зураг төсөлд тэмдэглэгдсэн бүх цонх, гадна | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа | - “Fine window” ХХК нь барилгын цонх тус бүрийн хэмжээг авлаа. Дэмжих багийн |

| | | | |
|---|---|---|---|
| | хаалгыг шинэчлэх үйл явц | ○ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | гишүүдийн зүгээс цонхны тавцангийн хурц ирмэгийг дугуйруулах, цонхны таславчийн дээд талд 60 хувь нь салхивч гаргах талаар ажлын зурагт өөрчлөлт оруулахаар цонх үйлдвэрлэгч компанитай харилцан тохиролцож зөвшилцлийн хуудсыг боловсруулллаа.<br>- Барилгын зураг төсөлд туссаны дагуу нийт 50 ширхэг цонхыг шинэчлэн, цонхыг хөөсөөр раманд бэхэлсэн.<br>- Цонх шинэчлэх ажлын явц дунд шатандаа явагдаж байна.<br>- Барилгын гадна хаалга шинэчлэх ажил огт эхлээгүй байна. |
| 3.2 | Цонх, хаалганы байрлал түүний ус тусгаарлалт, битүүмжлэлийн үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | - Цонхны замын өргөн: 7.2<br>- Давхар шилний тоо: 3<br>- Цонхны хүрээний таславчийн тоо: 7<br>- Үйлдвэрлэсэн байгууллагын нэр**:** “Fine window” ХХК<br>- Цонхны ус тусгаарлалт огт хийгдээгүй. |
| 3.3 | Гадна ханыг иж бүрэн, зохих зузаанаар дулаалах үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | - Дулаалгын хөөсөнцрийн зузаан: 15 см<br>- Нягт: Стандартын дагуу<br>- Грунт: БНСУ-д үйлдвэрлэсэн. 18л CN-190-1<br>- Хөөсөнцрийн цавуу: Belive-25 кг<br>- Чулуут замаск нь гарал үүслийн гэрчилгээтэй.<br>- Гадна ханыг иж бүрэн, зохих зузаанаар |

| | | | |
|---|---|---|---|
| | | | дулаалах үйл явц дунд шатандаа явагдаж байна. |
| 3.4 | Дээврийн дулаалгыг иж бүрэн хийх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ **Ажил эхлэх шатандаа**<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | - 8 ширхэг яндан өрөхөөс 6 ш янданг буулган өрсөн. Үлдсэн 2 янданг буулгах шаардлагагүй.<br>- Баруун хэсгийг тоосгоор өндөрлөсөн. Заалны дээд талын дээврийн өндөрлөгөө өрсөн. |
| 3.5 | Цонхны амлагаа болон дотор тавцангууд бүрэн хийгдэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ **Огт эхлээгүй**<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | - Цонхны тавцан солигдоогүй.<br>- Цонхны амлагаа болон дотор тавцангууд огт эхлээгүй |
| 3.6 | Халаалтын системийг зургийн дагуу гүйцэтгэх үйл явц | ○ **Огт тусгагдаагүй**<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 3.7 | Сантехникийн тоноглолууд иж бүрэн, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан эсэх | ○ **Огт тусгагдаагүй**<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 3.8 | Дээвэрт ус нэвтрэхгүй битүүмжлэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ **Огт эхлээгүй**<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | - Дээвэрт ус нэвтрэхгүй битүүмжлэх, дулаалгын ажил эхлээгүй байна. |
| 3.9 | Цэвэр, бохир усны шугам шаардлагатай стандартын дагуу хийгдэх үйл явц | ○ **Огт тусгагдаагүй**<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 1. | **Ажиглагдсан зөрчил, дутагдал:**<br>- Суулгасан 1 шинэ цонхны салхивч цууралт өгсөн. | | |

| | |
|---|---|
| | - Гал тогооны агааржуулагчийн хоолойг гадагш гаргах тооцоолол хийгдээгүй, бусад цонхны адилаар хэмжээ авснаас салхивчийг солих шаардлага тулгарсан. |
| 2. | **Цаашид анхаарах зүйлс:**<br>1. Цонх тус бүрд хэмжээ авч, цонхны тавцанг хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс суурилуулах (хурц ирмэгийг дугуйруулах)<br>2. Гал тогооны агааржуулагчийн хоолойг гадагш гаргах салхивч болон цуурсан салхивч, нийт 2 салхивч солих<br>3. Камерын утсанд хоолой суулгаж, фасадын гадна ил байрлуулах<br>4. Цонхны тавцанг солихдоо паарыг эвдэхгүй байх<br>5. Шинээр солигдох хаалгыг цайвар өнгөөр сонгож, суурилуулах |
| 3. | **Барилгын их засвар, дулаалгын явцын талаарх ерөнхий дүгнэлт:**<br>• Барилгын их засвар, дулаалгын ажилд хэрэглэгдэх бараа материалын нийлүүлэлтэд “Дэмжих баг”-ийн гишүүд өдөр бүр хяналт тавин ажиллаж байна. Засварыг материалын чанар стандарт шаардлагад нийцсэн, тохирлын гэрчилгээтэй, лабораторийн шинжилгээний бичигтэй б<br>• Барилгын зураг төсөлд туссан бүх цонх, гадна хаалгыг шинэчлэх үйл явц дунд шатандаа явагдаж байна. Цонхны таславчийг баруун талд гаргаж, 60 хувийг салхивч байхаар тооцож цонхыг хийлгэсэн болно. (ажлын зурагт зүүн талд байсан болно.) Шинээр суурилуулах 50 цонх нь стандартын дагуу цонхны замын өргөн 7.2, давхар шилний тоо 3, хүрээний таславчийн тоо 7 гэсэн үзүүлэлттэй үйлдвэрлэгдсэн байна. Цонхны тавцан солигдоогүй, амлагаа болон дотор тавцангууд огт эхлээгүй. Хуучин 50 ширхэг цонхыг эвдрэл гэмтэлгүй буулган, Нийслэлийн өмч ашиглалт удирдлагын газарт актлуулах хүсэлтийг албан бичгээр явуулав.<br>• Барилгын гадна хаалга шинэчлэх ажил огт эхлээгүй байна.<br>• Гадна ханыг иж бүрэн, зохих зузаанаар дулаалах үйл явц дунд шатандаа, БНСУ-д үйлдвэрлэгдсэн CN-190-1 стандартын грунт, 15 см зузаантай дулаалгын хөөс, Believe маркийн хөөсөнцрийн цавууг тус тус ашиглаж байна. Цэцэрлэгийн ар талын ханыг хусаж цэвэрлэн, грунтээ түрхэж хатаагаад, хөөсөө ам даруулан нааж, 1м2 талбайд 5-6 ширхэг хадаас байхаар бэхэлж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна.<br>• Дээврийн дулаалгыг иж бүрэн хийх үйл явц эхлэх шатандаа, агааржуулалтын 8 яндангаас зургааг буулгаж, тоосго шинээр өрж, шинэчилж байна. Баруун болон заалны дээд талын дээврийн өндөрлөгөө өрсөн. Дээвэрт ус нэвтрэхгүй битүүмжлэх, дулаалгын ажил эхлээгүй байна.<br>- г ү Нийт 50 цонх бүрэн солигдсон боловч амлагаа, тавцан суугдаагүй- 30% |

| | |
|---|---|
| | - Хаалга солих үйл явц -0%<br>- Суурийн дулаалга-0%<br>- Дээврийн дулаалга-10%<br>- Ханын дулаалга- 30%<br>- Дулаалгын их засварын ажил 20%-тай, стандартын дагуу явагдаж байна. Төслийн зөвлөх инженер С.Түвшинхүү, Д.Барсболд нар ирж, засварын ажлын явцтай танилцан заавар зөвлөгөө өгч ажилласан. Төслийн инженер В.Баясгалан өдөр тутмын хяналтыг тавин ажилласнаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулан, засварын ажил хэвийн явагдаж байна. |
| **Ажиглалт хийсэн хүний нэр, холбоо барих хаяг, утас:** | |
| Сонгинохайрхан дүүргийн 148-р цэцэрлэг.<br>Дэмжих багийн ахлагч Х.Нямхүү. Утас: 99401699 | |

## ЗӨВШИЛЦЛИЙН ХУУДАС

| |
|---|
| *Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 148 дугаар цэцэрлэгийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа ХАНЗОЛ ХХК нь "Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь" төслийн хүрээнд зохион байгуулалтад орсон "Дэмжих баг"-ийн гишүүдийн барилгын засвар, дулаалгын ажлын явцад хийсэн эцэг эхийн оролцоот, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, санал дүгнэлттэй танилцлаа.* |
| **Дэмжих багийн гишүүдийн тайланд туссан дараах зүйлсийг гүйцэтгэгч их засвар, дулаалгын явцад тусгаж ажиллахаа талууд харилцан зөвшилцлөө.** |
| **Гүйцэтгэгч компанийн зүгээс**:<br>• Цонхны таславчийн 60%-д салхивч гаргах,<br>• Гал тогооны агааржуулагчийн хоолойг гадагш гаргах салхивч болон цуурсан салхивч, нийт 2 салхивч солих<br>• Цонхны тавцанг хүүхдийн осол аюулгүй байдлыг харгалзан ирмэгийг дугуй байхаар захиалах<br>• Стандартын дагуу цэцэрлэгийн гадна, дотор талд налуу шат хийх<br>• Камерын утасны гадуур хоолой суулгах<br>• Барилгын хог хаягдлыг ачиж цэвэрлэх<br><br>**Цэцэрлэгийн зүгээс**:<br>• Дэмжих багийн гишүүдийг хуваарийн дагуу хяналт тавьж ажиллуулах<br>• Барилгын материал, багаж хэрэгсэл хадгалах өрөө тасалгаа бэлтгэх<br>• Ажлын зурагт тусгагдаагүй боловч зайлшгүй хийгдэх ажлын жагсаалтыг гаргаж, шийдвэрлүүлэх |

| Дэмжих багийн ахлагч | Хяналтын инженер | Компанийн захирал |
|---|---|---|
| Х.Нямхүү | Н.Түвшинтөгс | Д.Гомбожав |

## ЗӨВШИЛЦЛИЙН ХУУДАСНЫ БИЕЛЭЛТ БУЮУ ДҮГНЭХ ХУУДАС

*Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 148 дугаар цэцэрлэгийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа “ХАНЗОЛ” ХХК болон “Дэмжих баг”-ийн гишүүдийн харилцан зөвшилцсөн ажил үйлчилгээ нь доор дурдсан байдлаар биелэгдсэн байна.*

| Харилцагч талууд | Д/д | Зөвшилцсөн ажлууд | Ажлын биелэлт |
|---|---|---|---|
| Гүйцэтгэгч компанийн зүгээс | 1 | Цонхны таславчийн дээд хэсэгт 60 хувьд нь салхивч гаргах | Ажлын зурагт цонх баруун талд салхивчтай, салхивчийн 60 хувь доод талдаа онгойдог, дээд тал нь онгойдоггүй байсныг өөрчилж, 40 хувь доод талд онгойхгүй, 60 хувь дээд талдаа онгойхоор, цэвэрлэгээ хийхэд гарын зөв талд байхаар ажлын зурагт өөрчлөлтийг оруулж, цонхыг бэлэн болгов.<br><br>Гүйцэтгэл 100% |
| | 2 | Гал тогооны агааржуулагчийн хоолойг гадагш гаргах салхивч болон цуурсан салхивч, нийт 2 салхивч солих | Гал тогооны агааржуулагчийн хоолойг гадагш гаргах салхивчийг засварласан. Агааржуулагчийн моторыг хөөсөнцөр хананд бэхлэх боломжгүй болсон тул газарт тулгуур багана босгож, бэхэлсэн.<br><br>Нэг давхарт байрлах Бага бүлгийн хүлээн авах өрөөний цонхны цуурсан салхивч солигдоогүй.<br><br>Гүйцэтгэл 50% |
| | 3 | Цонхны тавцанг хүүхдийн осол аюулгүй байдлыг | Нийт 50 цонхны тавцанг хүүхдийн осол аюулгүй |

| | | | |
|---|---|---|---|
| | | харгалзан ирмэгийг дугуй байхаар захиалах | байдлыг харгалзан ирмэгийг дугуй болгож, суурилуулсан. Гүйцэтгэл: 100% |
| | 4 | Стандартын дагуу цэцэрлэгийн гадна, дотор талд налуу шат хийх | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зорчих налуу шат хийгдсэн боловч хүүхэд барих бариулгүй байгаа тул бариул нэмж хийлгэх шаардлагатай. Гүйцэтгэл: 80% |
| | 5 | Камерын утасны гадуур хоолой суулгах | Гадна хананд байгаа камерын утсанд хамгаалалтын хоолой суулгах ажил хийгдээгүй, ажлын зурагт тусгагдаагүй, хийх боломжгүй. Гүйцэтгэл: 0% |
| | 6 | Барилгын хог хаягдлыг ачиж цэвэрлэх | Барилгын хог хаягдлыг нийт 5 удаа ачиж цэвэрлэсэн. Цэцэрлэгийн зүгээс өдөр тутмын цэвэрлэгээг хийж, хамтран ажилласан. Гүйцэтгэл: 100% |
| Цэцэрлэгийн зүгээс | 7 | Барилгын материал, багаж хэрэгсэл хадгалах өрөө тасалгаа бэлтгэх | 1 давхрын “Бэлтгэл-2” бүлгийг гаргаж өгсөн. Манаач жижүүрүүд барилгын материал, багаж хэрэгслийн бүрэн байдлыг хариуцан ажилласан. Гүйцэтгэл: 100% |
| | 8 | Ажлын зурагт тусгагдаагүй боловч зайлшгүй хийгдэх ажлын жагсаалтыг гаргаж, шийдвэрлүүлэх | Ажлын зурагт тусгагдаагүй боловч зайлшгүй хийгдэх ажлын жагсаалтыг гаргаж, шийдвэрлүүлэх ажлыг холбогдох хүмүүстэй хамтран зохион байгуулав. Үүнд:<br>1. Ар талын галын шатны тавцанг өргөн болгож, хүүхдэд аюул, осолгүй байхаар ярилцан шийдвэрлэсэн.<br>2. Цонхны дотор амлагаанд хөөс ашиглаж, дулаалга |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хийхээр шийдвэрлэсэн. Хуучин амлагаа нь засварлах боломжгүй, хөөсөөр тэгшлэх шаардлага үүссэн.<br>3. Дээврийн СИ төмрийн бэхэлгээг 2 дахин нэмэгдүүлсэн.<br>Гүйцэтгэл: 100% |
| | 9 | Дэмжих багийн гишүүдийг хуваарийн дагуу хяналт тавьж ажиллуулах | Дэмжих багийн гишүүд нь 2020 оны 07-р сарын 13 аас 10-р сарын 25 хүртэл хугацаанд хуваарийн дагуу хяналт тавьж ажилласан.<br>Гүйцэтгэл: 100% |
| Дүгнэлт: | | | |
| Барилгын гүйцэтгэгч “*ХАН ЗОЛ*” ХХК-тай Дэмжих багийн гишүүдийн харилцан зөвшилцсөн нийт 9 ажлын 6 нь 100 хувь, 1 нь 80 хувь, 1 нь 50 хувь, 1 ажил огт хийгдээгүй.<br>Нийт Зөвшилцлийн хуудаст тусгагдсан нийт ажил 81,1 хувийн биелэлтэй байна. | | | |
| Биелэлтийг дүгнэсэн хүний нэр, холбоо барих хаяг, утас: | | | |
| Сонгинохайрхан дүүргийн 148-р цэцэрлэг.<br>Дэмжих багийн ахлагч Х.Нямхүү. Утас: 99401699 | | | |

# ЗУРГИЙН ЦОМОГ



















# НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 147 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ




## БИДНИЙ ТУХАЙ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн 147 дугаар цэцэрлэг нь 18 дугаар хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамжинд байрладаг. 1991 онд 14 бүлэг 330 хүүхдийн хүчин чадалтай, 53 багш, ажилтантай сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаагаа эхэлснээс хойш 30 дахь хичээлийн жилдээ хамран сургах тойргийн 730 гаруй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгож байна.

Манай цэцэрлэг 100 хувь мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан ба багш нарын 40 хувь нь магистр, 60 хувь нь бакалавр, тэргүүлэх 8, заах аргач 9, нийт 17 багштай ажиллаж байна. Тэдний амжилт бүтээлийг үнэлж төрийн дээд “Алтан гадас” одонгоор 3, “Хөдөлмөрийн Хүндэт” медалиар 10, БШУЯ-ны шагнал “Боловсролын тэргүүний ажилтан” цол тэмдгээр 13, “Хүндэт жуух бичиг”-ээр 9 багш ажилтан тус тус шагнагдсан.

## БИДНИЙ АМЖИЛТ

- 2006 онд Нийслэлийн тэргүүний цэцэрлэг
- 2014 онд Нийслэлийн “Замын хөдөлгөөний цагаан толгой” наадамд тэргүүн байр

- 2016 онд Монгол улсын гавьяат тамирчин, Олон улсын их мастер Д.Эрдэнэбилэгийн нэрэмжит БЗД-ийн цэцэрлэгийн хүүхдүүдийн “Зуун буудалт” даамны аварга шалгаруулах тэмцээнд тэргүүн байр
- 2016 оны “Замын хөдөлгөөний цагаан толгой-2016” наадамд Баянзүрх дүүрэгт тэргүүн байр
- 2017 онд Нийслэлийн төрийн өмчийн индексийн урамшуулал, шилдэг цэцэрлэг
- 2017 онд Нийслэлийн “Замын хөдөлгөөний цагаан толгой” уралдаанд дэд байр
- 2017 онд Баянзүрх дүүргийн “Уран хөдөлгөөнт гимнастикийн” тэмцээнд тэргүүн байр
- 2017 онд Нийслэлийн өмчийг эзэмшигч тэргүүний байгууллага
- 2018 онд Нийслэлийн “Замын хөдөлгөөний цагаан толгой” наадамд тусгай байр
- 2018 онд Баянзүрх дүүргийн тэргүүний цэцэрлэг
- 2019 онд Архивын улсын үзлэгт тэргүүн байр
- 2019 оны Баянзүрх дүүргийн “Уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнд” тэргүүн байр
- 2019 онд Нийслэлийн эрүүл мэндийг дэмжигч, нэгдүгээр зэргийн байгууллага
- 2019 онд Ногоон байгууламж, байгальд ээлтэй шилдэг ногоон байгууламжтай цэцэрлэг
- 2019 онд Хүүхэд гэр бүлд ээлтэй цэцэрлэг
- 2020 онд Нийслэлийн төрийн өмчийн индексийн урамшуулал, шилдэг цэцэрлэг

## “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хэрэгжилт манай цэцэрлэгт



**Х.Чимэдцэрэн (Нийслэлийн Баянзүрх дүүргийн тэргүүний 147 дугаар цэцэрлэгийн эрхлэгч):**

Бид “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөлд хамрагдан, цэцэрлэгийн барилгын дулаалга, их засвар ажлаа гүйцэтгүүлсэндээ баяртай байна.

Манай цэцэрлэг 1990 онд баригдсан, барилгын чанар муудан, анги танхимууд маш хүйтэн байснаас гадна нийт анги танхимын 60 гаруй хувь нь цан цохиж, хөгц мөөгөнцөртэй байсан нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих, тав тухтай тохилог орчин бүрдүүлэхэд хүндрэлтэй байсан.

Төслийн нэг онцлог нь цэцэрлэгийн их засвар, дулаалгын ажил хийхээс гадна цэцэрлэгийн арга зүйч, багш, ажилтан, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн “Дэмжих баг” байгуулан “Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ” хийх аргачлалыг эзэмшүүлсэн явдал байлаа. Засварын явцад “Дэмжих баг” хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хамтарч ажилласан нь барилгын их засвар, дулаалгын ажлыг цаг хугацаандаа чанартай хийж гүйцэтгэхэд чухал ач холбогдолтой байсан.

**Н.Алагцэцэг (Нийслэлийн Баянзүрх дүүргийн тэргүүний 147 дугаар цэцэрлэгийн арга зүйч):**



“Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөлд хамрагдлаа гэсэн баяртай мэдээ сонсоод, төслийг хэрхэн хэрэгжүүлэх мэдээллийг хүлээн аваад нэлээд итгэл багатай ажлаа эхэлж байсан.

Цэцэрлэг маань 30 жилийн түүхтэй, хана таазаараа хөгц мөөгөнцөртсөн, цонх ханаараа дулаан их алддаг, бүлгүүдийн ариун цэврийн өрөөнөөс эвгүй үнэр их гардаг байв. Энэ нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих үйл ажиллагаанд хүндрэл учруулж байсан. Төслийн хүрээнд “Дэмжих баг”-ийг ахалж ажиллах хариуцлагатай, хүндтэй үүргийг хүлээн авч ажилласан. “Дэмжих баг” байгуулагдан ажилласнаар хамт олон, эцэг эхийн харилцаа, хандлага, хамтын ажиллагааг сайжирснаас гадна барилгын дулаалга, их засварын ажил чанартай хийгдэж, бидний зорьсон зорилго маань биелж, хүүхдүүдийн хувьд сурч хөгжих, ая тухтай, таатай орчин бүрдсэнд бид бүхэн сэтгэл хангалуун байна. “Дэмжих баг”-ийн гишүүд бид хүүхдэд байгаль, экологийн боловсрол олгох хичээл туршилтын талбайг шинэчлэн тохижуулж, энэхүү туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлж байгаадаа баяртай байна.



**Ц.Мөнхзул (Нийслэлийн Баянзүрх дүүргийн тэргүүний 147 дугаар цэцэрлэгийн багш):**

Манай цэцэрлэг энэ төсөлд хамрагдсанаар бага насны хүүхдийг эрүүл, аюулгүй, эрсдэлгүй орчинд сурч, хөгжих боломжийг бүрдүүлж чадлаа. Барилгын засвар эхлэхээс өмнө “Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ” хийх “Дэмжих баг” байгуулан барилгын их засвар, дулаалгын ажлыг хэрхэн хийх сургалтад хамрагдаж, барилгын их засвар, дулаалгын явцын талаарх мэдлэг, мэдээлэлтэй болж, цаашид амьдрал ахуйдаа ч хэрэглээ болгон ашиглаж байна. Төслийн үр дүнд хүүхдийн өвчлөл буурч, эцэг эхийн хандлага өөрчлөгдөн, сэтгэл ханамж нэмэгдэж байгаа нь мэдрэгдэж, бид бүхэн баяртай байна.



**Ш.Ганзориг (Нийслэлийн Баянзүрх дүүргийн тэргүүний 147 дугаар цэцэрлэгийн эцэг эхийн төлөөлөл):**

147 дугаар цэцэрлэгт миний 6 хүүхэд сурч хүмүүжиж, одоо эхнээсээ сургуулийн сурагчид болцгоож байна. Их засвар, дулаалгын ажил эхлэхээс өмнө цэцэрлэгийн анги танхимын дээврээс ус алддаг, хүйтэн, хөгц мөөгөнцөртэй, их тухгүй санагддаг байсан. Цэцэрлэгийн захиргаанаас уг төслийг хэрэгжих болсон талаар мэдээлэл өгч, “Дэмжих баг”-т орж ажиллах санал тавьсан. Зуны турш их зас

вар, дулаалгын ажилд хяналт тавихаас гадна цэцэрлэгийн ногоон байгууламж, туршлагын талбай, хүлэмжийг хүүхдийн сурч хөгжих, таатай орчин бүрдүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруууллаа. Төсөл хэрэгжсэнээр хүүхдүүдийн маань цэцэрлэг өнгө үзэмжтэй, дулаан тохилог, эрүүл аюулгүй орчин бүрдсэнд баяртай байна.

## БАГА НАСНЫ ХҮҮХЭД СУРЧ ХӨГЖИХ ТУРШИЛТЫН ТАЛБАЙ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ОРЧИН БҮРДҮҮЛЭХ НЬ

| | |
|---|---|
| Зорилго | Бага насны хүүхдэд байгаль, экологийн боловсрол олгох, танин мэдэх үйл ажиллагааг дэмжин, хөдөлмөрийн энгийн дадал, чадвар эзэмшүүлэх |

| | |
|---|---|
| Нөхцөл байдал, тулгамдсан асуудал | • Цэцэрлэгийн туршилтын талбай нь 44 $м^2$ , 900 гаруй хүүхэд ажиллахад талбайн хэмжээ бага, бүхий л хэсэг хайрга чулуу ихтэй, хүүхэд унаж бэртэх эрсдэл өндөртэй байсан.<br>• Ногооны талбайн арын ханаы тоосго нурсан, хүүхдийн дээрээс унах эрсдэлтэй.<br>• Туршилтын талбайд 4 нэр төрлийн ногоог нэг дор бөөнд нь тарьдаг, ногоо хоорондын зайг тусгаарлаагүй, нэг ангийн 50-60 хүүхэд нэгэн зэрэг тарьсан ногоогоо гараараа барьж, хүртэж, мэдрэх боломжгүй.<br>• Тарьсан ногоонуудад хаяг пайз байхгүй, туршилтын талбайд хэрэглэгдэх багаж хэрэгслийг тухайн орчинд байрлуулах боломжгүй.<br>• Хүлэмж нь 12 $м^2$ хэмжээтэй, бэхэлгээ суурилуулалт муутай, агаар сэлгэлтгүй, нэг хаалгатай учир 7-10 хүүхэд орсон тохиолдолд дараагийн хүүхдүүд зөрөх талбайгүй зэрэг нь сургуулийн өмнөх боловсролын орчны стандартад нийцэхгүй, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад хүндрэл үүсдэг байв.<br>Дээрх нөхцөл байдлаас улбаалан;<br>• Бага насны хүүхдийг бодит орчинд хүнсний ногоог хэрхэн тарьж ургуулах тухай мэдлэг чадвар олгох үйл ажиллагааг хангалттай түвшинд зохион байгуулж чаддаггүй байсан. |
| Зорилтот бүлэг | 14 бүлгийн 920 хүүхэд тэдний эцэг эх, асран хамгаалагч, 20 ажилтан |
| Шалгуур үзүүлэлт | • Цэцэрлэгийн туршилтын талбайн нэмэгдсэн тоо хэмжээ ($м^2$)<br>• Туршилтын талбай ашиглан зохион байгуулах сургалтад хамрагдах хүүхдийн тоо<br>• Туршилтын талбайд тарих хүнсний ногооны нэр, төрөл нэмэгдсэн тоо<br>• Хяналт-шинжилгээ, үнэлгээнд оролцсон эцэг эхийн тоо<br>• Цэцэрлэгийн үйл ажиллагаанд хамрагдсан эцэг эхийн оролцоо, хамрагдалтын хувь |
| | • Дэмжих багийн гишүүдийн хяналтын хуудасны тусламжтай илрүүлсэн, цэцэрлэгийн хүлэмж, ногоон байгууламж, туршилтын талбайд тулгамдаж байгаа асуудлуудыг нэгтгэв.<br>• Дэмжих багаараа тулгамдсан асуудлыг шийдэх, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан.<br>• Туршилтын талбай, хүлэмжийг сайжруулах “мөрөөдөл”-ийн зураглалаа гаргасан. |

| | |
|---|---|
| Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат | • Талбайн арын 240 $м^2$ ханын тоосгыг нөхөж цементлэн эмульсээр өнгөлөв. Дээд талыг нурахаас сэргийлэн төмрөөр бүрсэн.<br>• Ногооны талбайн хайрга, чулууг цэвэрлэн газрыг тэгшилж, 6 төрлийн ногоог тарихаар хэмжээг авч, ногоо тус бүрийн хоорондын зайг тусгаарласан 80 см-ийн өргөнтэй зам гарган цементлэв.<br>• Ногоо тарих хар шороо бууцаар газраа бэлтгэсэн.<br>• Хүлэмжийг агаар сэлгэх зориулалтаар 2 хаалгатай болгож, суурь бэхэлгээг сайжруулаад, ногоо тарихад хөрс шороог бэлтгэсэн.<br>• Талбайн арын хэсгээр тус бүр 1метр 20 см-ийн урттай 6 ширхэг модон сандлыг цементэд суулгаж байрлуулсан.<br>• Талбайд хэрэглэгдэх багаж хэрэгслийг хийх 2 ширхэг модон байшинг хийлээ.<br>• Багш, ажилчдынхаа дэмжлэгээр 6 нэр төрлийн хүнсний ногоог гадна талбайд, 3 нэр төрлийн нарийн ногоог хүлэмжид үр үрсэлгээгээр тарьсан.<br>• Ногоо тус бүр болон цэцэрлэгийн хашаан дахь мод бут бүрийн нэр төрлөөр нь ангилан хаягжуулж, пайз хийв. |
| Хүрсэн үр дүн (богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд) | • Цэцэрлэгийн туршилтын талбайн өмнөх хэмжээ 44$м^2$ байсан бол дараа нь 88 $м^2$ болж нэмэгдсэн.<br>• Туршилтын талбайд 60 хүүхэд сургалтад хамрагдах боломжтой болсон тэдийгүй 100-120 хүүхэд хамрагдан хичээл, туршилтын үйл ажиллагаанд хамрагдсан.<br>• Хүлэмждээ нэг төрлийн нарийн ногоо тарьдаг байсан бол сайжруулан засварласнаар 3 төрлийн ногоо тарьдаг болсон. Туршлагын талбайдаа 3 нэр төрлийн хүнсний ногоо тарьдаг байсан бол өргөтгөн 6 нэр төрлийн хүнсний ногоо тарьдаг болсон.<br>• Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилд анги бүрийн төлөөлөл 6 эцэг эх тогтмол хамрагдаж, нэгдсэн ойлголт, мэдээлэлтэй болсон. |

| | |
|---|---|
| Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд | • Цэцэрлэгийн дүрэм, дотоод журам, багш ажилчдын албан тушаалын тодорхойлолтод туршилтын талбайн аюулгүй байдал, сургалтын орчин болгон ажиллуулахад хэн, ямар үүрэг, хариуцлагатай байх тухай зүйл, заалт нэмэлтээр тусган оруулав.<br>• 2020-2021 оны хичээлийн жилийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулахдаа туршилтын талбай, хүлэмжид хүүхэд хэрхэн ажиллах, аюулгүй байдлыг хангах талаар бүлгийн бүх багш нарт зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллав.<br>• Бүлгийн багш нар өдөр тутмын зугаалгын явцад хүүхдүүддээ цэцэрлэгийн хашаанд байгаа мод, бутыг танилцуулан, тэдгээрийг таних, нэрлэх, арчилж ургуулах, хайрлаж, хамгаалахад дэмжин ажиллах зөвлөгөө бэлтгэж өгөв.<br>• Өглөөний хүлээн авалт болон оройн таралтын цагаар хүүхдүүдтэйгээ мод, бутыг ажиглан нэрлэх, хугалж гэмтээхгүй, зүлэг ногоон дээр гишгэхгүй байхыг хүүхдүүддээ сануулахыг эцэг эхчүүдэд зөвлөн, хамтран ажиллаж байна.<br>• Тарьсан ногоогоо хүүхдүүд багш, ажилчидтай хамтран хурааж, ургацын баяраа тэмдэглэн өдөрлөг зохион байгуулав.<br>• Хийсэн ажлаа сайн туршлага болгон баримтжуулж, бусдад түгээн дэлгэрүүлэх ажлыг цэцэрлэгийн төлөвлөгөөндөө тусгалаа. |
| Тулгарсан бэрхшээл, эрсдэл | • Ногоон байгууламж, зүлэг, бутны арчилгааны талаар мэргэжлийн хүнээс зөвлөгөө, дэмжлэг туслалцаа авч ажиллахад цар тахлын үе байсан учраас хүмүүсийг олноор цуглуулах нэгдсэн мэдээлэл өгөхөд хүндрэлтэй байсан.<br>• Оролцогч талууд өөрсдийн санаачилгаар аливаа зохион байгуулагдаж буй ажилд оролцохгүй байсан нь бэрхшээлтэй байсан. |
| Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс | • Багш ажилчид, эцэг эхэд байнгын дэмжлэг туслалцаа үзүүлж мэдээ мэдээллээр хангаж удирдан чиглүүлж байсан.<br>• Өндөржүүлсэн бэлэн байдлын үед багш нар бүлгийнхээ групп хуудас болон 147 гэсэн page хуудсаар дамжуулан эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилчдад фото зургийн хэлбэрээр хүргэж, өөрсдийн хийж хэрэгжүүлж буй ажлаа танилцуулж байсан.<br>• Бага насны хүүхдэд байгаль, экологийн боловсрол олгох чиглэлээр цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрт тусгаж, сургалт үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан. |

| | |
|---|---|
| | • Багш нар “Ногоон байгууламж”-ийн талаар цахим хичээл боловсруулж өөрийн мэдлэг боловсролоо дээшлүүлж үйл ажиллагаандаа тогтмол ашиглан ажиллаж байна. |
| Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс | • 2-5 настай хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан нарийн болон хүнсний ногооны тарих, арчлах талаар мэргэжлийн хүнээс зөвлөгөө зөвлөмж авч хэрэгжүүлэн ажиллах<br>• Хүүхдийг эрсдэлээс хамгаалах, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай<br>• Багш, ажилчдынхаа дунд нээлттэй яриа өрнүүлэн хийх ажлын талаар нэгдсэн ойлголт өгөх, аливаа ажилд эцэг эхийг өөрийн хүсэл сонирхол, санаачилгаар нь оролцуулахад анхааран ажиллах шаардлагатай. |
| Холбоо барих хаяг, лого | **Баянзүрх дүүрэг 13-р хороолол, 18-р хороо Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, Ц147**<br>Эрхлэгч Х.Чимэдцэрэн ажил утас: 976-11-456430, гар утас 99094053, Цахим хаяг: chimedtseren147@gmail.com<br>Аргазүйч Н.Алагцэцэг Утас: 99034480<br>Цахим хаяг: alagtsetseg.az147@gmail.com<br>Багш: Ц.Мөнхзул утас 99003239<br>Цахим хаяг: zulaaa0605@gmail.com |

## БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДУЛААЛГЫН ЯВЦАД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ, ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НЬ

| | |
|---|---|
| Зорилго | Цэцэрлэгт бага насны хүүхэд эрүүл, аюулгүй, эрсдэлгүй сурч хөгжих ая тухтай орчныг багш, ажилчид, эцэг эх, асран хамгаалагчийн хөндлөнгийн хяналт, оролцоотой бүрдүүлэх |
| Нөхцөл байдал, тулгамдсан асуудал | • Цэцэрлэгийн гадна талын фасад 30 жилийн насжилттай учир чанар нь муудаж цуурсан, дээвэр, хана, цонхноосоо цантаж дулаан байнга алддаг.<br>• Суурийн дулаалга хагарал цууралт ихтэй, дулаан алддаг учир бүлгүүд шалны давхар халаалт ашигладаг ч тодорхой үр дүнд хүрдэггүй.<br>• Өвөлдөө хүйтэн ангид олон цаг байдгаас шалтгаалан хүүхдүүд ханиад хүрэх, хоолой өвдөх асуудал байнга гардаг, өвчлөл 50-60 хувьд хүрдэг.<br>• Багш, ажилчид, хүүхдүүд анги танхимдаа даарч, тав тухгүй байх болсон.<br>• Дээврийн хар цаас хагарч урагдан, бүрэн бүтэн байдал алдагдан, ус чийг нэвчсэн. Бороо, цас орсон үед таазаар ус |

| | |
|---|---|
| | алддаг, бүх бүлгүүдийн өрөө тасалгаанд хөгц мөөгөнцөр үүссэн.<br>• Бүлгүүдийн агаар сэлгэлтийн систем муу учраас ангийн ариун цэврийн өрөө болон гал тогооны өрөөнөөс эвгүй үнэр гардаг.<br>• Нийт 148 цонхны 58 цонх модон, 90 цонх вакум боловч эвдрэл гэмтэл ихтэй, дулаан их алддаг, цонхны бороо, цасны хаялга стандарт бус байсан.<br>Дээрх нөхцөл байдлаас улбаалан;<br>• Бага насны хүүхдэд сурч, хөгжих ая тухтай орчныг бүрдүүлж чадаагүй байсан. |
| Зорилтот бүлэг | Цэцэрлэгийн нийт 730 хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, 53 багш ажилтан |
| Шалгуур үзүүлэлт | • Хүүхдийн өвчлөлийн тоо буурсан хувь<br>• Багш, ажилчдын чөлөө авалт болон өвчлөлийн тоо буурсан хувь<br>• Анги бүлэг давхар халаалт ашиглахгүй болсон өөрчлөлт<br>• Цэцэрлэгийн цахилгааны төлбөр буурсан хувь<br>• Хана таазаар дулаан алдагдал буурсан хувь<br>• Эцэг эхийн сэтгэл ханамжийн түвшин, хувиар |
| Хэрэгжүүлсэн үйл явц,үе шат | • Дэмжих багийн гишүүд барилгын их засвар дулаалгын явц болон материалын чанар, стандартын сургалтад хамрагдсан.<br>• Барилгын их засварын дулаалгын ажлын төлөвлөгөө гарган дэмжих багийн гишүүдэд танилцуулсан.<br>• Барилгын их засвар дулаалгын явцын хяналтын хуудастай танилцаж өөрийн онцлогт тохируулан хяналтын хуудсыг боловсруулсан. Дэмжих багийн гишүүд хяналтын хуудаст тэмдэглэл хөтлөн ажилласан.<br>• Нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулан баримтжуулан ажилласан.<br>• Боловсруулсан хяналтын хуудсаа дүгнэж, зөвшилцлийн хуудас боловсруулан “Эл эс би” компанийн удирдлагад танилцуулан баталгаажуулан ажилласан.<br>• “Эл эс би” ХХК-тай зөвшилдсөний үндсэн дээр дэмжих багаараа дахин хяналт тавин ажилласан.<br>• Барилгын их засвар дулаалгын явцын зөвшилцлийн хуудасны талаар дүгнэлт боловсруулсан. |
| Хүрсэн үр дүн (богино | • Хүүхдийн өвчлөлийн тоо 50 хувиар буурсан.<br>• Багш, ажилчдын чөлөө авалт болон өвчлөлийн тоо 90 хувиар буурсан. |

| | |
|---|---|
| хугацаанд гарсан өөрчлөлтүүд) | • Анги бүлгүүд давхар халаалт 100 хувь ашиглахгүй болсон.<br>• Хана таазаар дулаан алдагдах байдал 100 хувь буурсан. |
| Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд | Цэцэрлэгийн удирдлага, багш нарын зүгээс эцэг эхтэй хамтран хүүхдийн сурч хөгжих, эрсдэлгүй орчин бүрдүүлж байгаадаа сэтгэл хангалуун байна. Цаашид цэцэрлэгийнхээ “Загвар” ажил болгон тодорхой ажлуудыг санаачлан, төлөвлөгөө боловсруулж холбогдох баримт бичигтээ тусгав. Жишээлбэл:<br>• Цэцэрлэгийн барилгад жил бүр мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах<br>• Барилгын элэгдлийн үнэлгээг эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран жил бүр хийж байх<br>• Багш, ажилчид цэцэрлэгийн гадаад, дотоод орчинд байнга хяналт тавьж, үнэлгээ өгч ажиллах |
| Тулгарсан бэрхшээл, эрсдэл | • Хүүхдүүд зуны амралттай байсан тул эцэг эхчүүдийг ажилд татан оролцуулахад хүндрэлтэй байсан.<br>• Засварын ажил амралтын хугацаанд хийгдсэн тул багш ажилчдыг дуудаж ажиллуулах нь бэрхшээлтэй байсан<br>• Корона вирусийн халдварын өндөржүүлсэн бэлэн байдлын үе тохиосон тул багш, ажилтан, эцэг эх асран хамгаалагчидтай хамтран ажиллахад бэрхшээлтэй байсан.<br>• Байгаль, цаг агаарын бэрхшээл ажил жигд явагдахад бэрхшээл үүсгэж байлаа. |
| Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс | • Барилгын их засвар, дулаалгын талаар мэдээлэл өгөх сургалтад дэмжих багийн гишүүд хамрагдсан нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд ихээхэн ач холбогдолтой байсан.<br>• Зөвлөх баг болон хяналтын инженерийн үүрэг оролцоо энэ төрлийн үйл ажиллагааг зохион байгуулахад ихээхэн дэмжлэг болсон.<br>• Зөвлөх багийн зүгээс өгсөн зөвлөгөө нь тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой байлаа.<br>• Сар бүр хийсэн ажлын тайлангаа илгээж дараагийн ажилд тусган ажиллаж байсан.<br>• Гүйцэтгэгч компанитайгаа хамтран ажиллаж, зөвшилцөн эерэг харилцаа үүсгэн ажиллаж байсан нь амжилтад нөлөөлсөн. |
| Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс | • Хийсэн ажлаа бусад цэцэрлэгүүд болон мэргэжил нэгт багш нартаа түгээн дэлгэрүүлэх тал дээр хамтран ажиллах |

| | |
|---|---|
| | • Барилгын их засвар, дулаалгыг хэрхэн хийдэг талаар дэмжих багийн гишүүд нэгдсэн нэг ойлголттой болох<br>• Дэмжих багийн гишүүдийн хүлээх үүрэг, хариуцлагыг маш тодорхой болгох<br>• Дэмжих баг ажиллах хуваарь гарган, гишүүдийн ажиллах боломжийг уян хатан байдлаар зохицуулах<br>• Барилгын өмнөх үеийн зураг бодит байдлыг баримтжуулан авах |
| Холбоо барих хаяг, лого | **Баянзүрх дүүрэг 13-р хороолол, 18-р хороо Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, Ц147**<br>Эрхлэгч Х.Чимэдцэрэн ажил утас: 11-456430, гар утас 99094053<br>Цахим хаяг: Chimedtseren147@gmail.com<br>Аргазүйч Н.Алагцэцэг Утас: 99034480<br>Цахим хаяг: alagtsetseg.az147@gmail.com<br>Багш: Ц.Мөнхзул утас 99003239<br>Цахим хаяг: Zulaaa0605@gmail.com |

## БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДУЛААЛГЫН АЖЛЫН ЯВЦАД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Дүүрэг: Баянзүрх　　Байгууллага: 147 дугаар цэцэрлэг

Огноо: 2020 оны 7 дугаар сарын 21

| **БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДУЛААЛГЫН АЖЛЫН ЯВЦАД ХИЙХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ** | | |
|---|---|---|
| **Шалгуур** | | **Тайлбар/дэлгэрэнгүй** |
| 3.1 | Барилгын зураг төсөлд тэмдэглэгдсэн бүх цонх, гадна хаалгыг шинэчлэх үйл явц | Нийт 148 цонх суулгагдахаас 97 цонх суугдаж, ажил 60%-тай явагдаж байна. Амлагаа болон тавцан 30%-тай хийгдсэн. Гадна талын хаалга бүрэн солигдсон ба амлагаа хийгдээгүй байна. |
| 3.2 | Цонх, хаалганы байрлал түүний ус тусгаарлалт, битүүмжлэлийн үйл явц | Цонх 60%-тай суугдсан ч зарим цонх далий суугдсан, ус тусгаарлалт, битүүмжлэл дутуу хийгдсэн байна. |
| 3.3 | Гадна ханыг иж бүрэн, зохих зузаанаар дулаалах үйл явц | • Гадна талын дулаалгын ажил дууссан.<br>• Гадна фасадны ажил 50%-тай явагдаж байна.<br>• Өнгө гарган будаж эхэлсэн. Ажил 50%-тай явагдаж байна. |

| | | |
|---|---|---|
| | | • Суурийн дулаалга одоо эхэлж байна. |
| 3.4 | Дээврийн дулаалгыг иж бүрэн хийх үйл явц | • Дээврийн дулаалга 60%-тай явагдаж байна.<br>• Цутгалт баруун талдаа хийгдсэн, зүүн тал дутуу байна |
| 3.5 | Цонхны амлагаа болон дотор тавцангууд бүрэн хийгдэх үйл явц | • Цонхны тавцан, амлагаа хийх ажил 2 хоногийн өмнө эхэлсэн.<br>• Цонхны тавцан, амлагаа 30%-тай явагдаж байна. |
| 3.6 | Халаалтын системийг зургийн дагуу гүйцэтгэх үйл явц | Халаалтын систем 55%-тай явагдаж байгаа ч агаар сэлгэлтийн босоо шугам заслын ажил хийгдээгүй байна. Давхар хоорондын нүх бөглөөгүй үйл ажиллагаа удааширсан байдалтай байна. |
| 3.7 | Дээвэрт ус нэвтрэхгүй битүүмжлэх үйл явц | Дээврийн битүүмжлэлийн ажил 35%-тай явагдаж байна. Хар цаас, хөөсөнцөр хараахан хийгдээгүй байна. |
| 3.8 | Барилгын засварын ерөнхий чанар | Барилгын ерөнхий ажил сайн, стандартын дагуу чанартай материалаар хийгдэж байна. |
| 3.9 | Гадна ханын өнгө будаг ба түүний чанар | Гадна өнгө, будаг зураг төслийн дагуу чанартай сайн хийгдэж байна. Гадна хананы эмульсийг Польшийн Атлас брэндийн сайн чанарын материалаар хийж байна. |
| 1. | **Ажиглагдсан зөрчил, дутагдал:**<br>• Агаар сэлгэлтийн босоо хоолойн шугам заслын ажлыг хийж анги хоорондын шалны нүхийг бөглөж аюулгүй байдлыг хангах<br>• Хаалга, цонхны амлагаа болон тавцанг хийж дуусгах<br>• Цонхны тавцангийн доод талын хананы засварын ажлыг хийж эхлэх<br>• Барилгын ажил явуулж байгаа компаниуд гарсан хог хаягдлаа цаг тухай бүр нь цэвэрлэж, ачуулж байх<br>• Цэцэрлэгийн гадна үүдний аркийн засварыг хийх | |
| 2. | **Сайжруулах шаардлагатай зүйлс:**<br>• Цэцэрлэгийн бүртгэл эхлэх хугацаа ойртсон тул хурдавчилсан байдлаар хийх талаар ярилцаж ойлголцлоо.<br>• Цонхны амлагааг хийх<br>• Хаалганы амлагаа хийх<br>• Анги хоорондын шалны нүхийг бөглөх, агаар сэлгэлтийн босоо шугамын заслын ажлыг хийх<br>• Цонхны тавцангийн доод талын хананд засвар хийх<br>• Цэцэрлэгийн гадна үүдний аркийн засвар, гадна талаас ордог 2 ангийн гадна шат, явган хүний налуу шатыг хийж эхлэх | |
| 3. | **Барилгын их засвар, дулаалгын явцын талаарх ерөнхий дүгнэлт:**<br>Барилгын их засвар, дулаалгын ажил гэрээнд заасан графикт хуваарийн дагуу явагдаж байгаа боловч цонх суурилуулалт, цонхны амлагаа, цонхны доод талын тавцангийн хананы засвар, хаалганы амлагаа, агаар сэлгэлтийн босоо | |

| | |
|---|---|
| | хоолойн шугам засварын ажил, анги хоорондын шалны нүхийг бөглөж аюулгүй ажиллагааг хангах болон дээврийн дулаалгын ажил дунд зэрэг явагдаж байна. Цэцэрлэгийн гадна үүдний аркийн засвар, явган хүний налуу шат хийгдээгүй байна. 2020-2021 оны хичээлийн жил эхлэх дөхсөн тул засварын ажлын явцыг хурдасгахаар боллоо. |
| **Ажиглалт хийсэн хүний нэр, холбоо барих хаяг, утас** | |
| **Дэмжих багийн ахлагч:** Аргазүйч Н.Алагцэцэг Утас: 99034480<br>Цахим хаяг: alagtsetseg.az147@gmail.com | |

## ЗӨВШИЛЦЛИЙН ХУУДАС

| |
|---|
| *Нийслэлийн Баянзүрх дүүргийн 147 дугаар цэцэрлэгийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа “**ЭЛ ЭС БИ**” компани нь “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд зохион байгуулалтад орсон “Дэмжих баг”-ийн гишүүдийн барилгын засвар, дулаалгын ажлын төгсгөлд хийсэн эцэг эхийн оролцоот, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, санал дүгнэлттэй танилцлаа.* |
| **Дэмжих багийн гишүүдийн тайланд туссан дараах зүйлсийг гүйцэтгэгчийн зүгээс их засвар, дулаалгын төгсгөлийн шатанд бүрэн тусгаж ажиллахаа талууд харилцан тохиролцлоо.** |
| **Үүнд:**<br>• Барилгын дээврийн дулаалгын цутгалтыг баруун талд хийсэн ба үргэлжлүүлэн батлагдсан зураг төслийн дагуу зүүн талын дээврийг хийж гүйцэтгэх<br>• Хар цаас, хөөсөнцрийг шаардлага хангасан материалаар хийж дуусгах<br>• Дулаалгын ажил хийж дууссан<br>• Гадна фасадын ажил 50%-тай явагдаж байгаа<br>• Гадна талын өнгийг уусгаж будаж байгаа ба нүүрэн хэсгийн 2 талд нь дизайн оруулж улаан, шар, ногоон өнгөөр кант хийсэн.<br>• Дээврийн ус зайлуулах шугамыг стандартын дагуу шаардлага хангасан материалаар хийж гүйцэтгэх<br>• Цэцэрлэгийн гадна талаас ордог ангид хөгжлийн бэрхшээлтэй иргэд орж гарахад зориулагдсан налуу шат хийх<br>• Барилгын ажлыг хийх явцад барилгын материалыг буулгах, ачих, техник тоног төхөөрөмж орж гарах үед барилгын үндсэн хийц, ногоон байгууламж, хашаа хайсаар болгоомжтой орж гарах, гэмтээхгүй байхад анхаарах<br>• Барилгын ажлыг хийж гүйцэтгэх явцад гарсан хог хаягдлыг цаг тухай бүрд нь ачуулж холдуулж байх |

| | | |
|---|---|---|
| • Барилгын ажил хийж гүйцэтгэх явцад барилгын эргэн тойронд байгаа муу усны нүхийг таглахгүй чөлөөтэй байлгах<br>• Талбайн инженер, хяналтын инженертэй байнга эргэх холбоотой байж ХАБ-д хяналт тавьж ажиллах<br>• Засварын ажлын эхлэл, дунд, төгсгөлийн үйл явцыг танилцуулж, мэдээ мэдээллээр хангаж ажиллах<br>• Барилгын ажлыг гэрээнд заасан графикт хуваарийн дагуу хийж дуусгах<br>• Цэцэрлэгийн гадна үүдний аркийн засварыг хийх<br>• Цонхны тавцангийн доод талын хананд засвар хийх | | |
| **Дэмжих багийн ахлагч**<br>Арга зүйч:<br>Н.Алагцэцэг | **Хяналтын инженер**<br>Хяналтын инженер:<br>Д.Эрдэнэтуяа | **Компанийн захирал**<br>Компанийн захирал<br>Р.Эрдэнэбат |

## ДҮГНЭХ ХУУДАС

*Нийслэлийн Баянзүрх дүүргийн 147 дугаар цэцэрлэгийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа "Эл Эс Би" ХХК компани болон "Дэмжих баг"-ийн гишүүдийн харилцан зөвшилцсөн ажил үйлчилгээ нь дор дурдсан байдлаар биелэгдсэн байна.*

| Харилцагч талууд | № | Зөвшилцсөн ажлууд | Ажлын биелэлт |
|---|---|---|---|
| Гүйцэтгэгч компанийн зүгээс | 1 | Барилгын дээврийн дулаалгын цутгалтыг баруун талд хийсэн ба үргэлжлүүлэн батлагдсан зураг төслийн дагуу зүүн талын дээврийг хийж гүйцэтгэх | Барилгын дээврийн дулаалгын цутгалтыг батлагдсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгэсэн. Гүйцэтгэл: 100% |
| | 2 | Дээврийн ус зайлуулах шугамыг стандартын дагуу шаардлага хангасан материалаар хийж гүйцэтгэх | Дээврийн ус зайлуулах шугамыг зураг төслийн дагуу хийж битүүмжлэлийг бүрэн хангахаас гадна хуучин бөглөрсөн байсан шугамуудын бөглөөг гаргаж нөхөн сэргээж ажилласан. Гүйцэтгэл: 100% |
| | 3 | Гадна фасадын нүүрэн хэсгийн 2 талд нь дизайн оруулж улаан, шар, ногоон өнгөөр кант хийх. | Барилгын нүүрэн хэсгийн баруун зүүн талд улаан, шар, ногоон өнгийн кантыг 60*60 см-ийн хэмжээтэйгээр босоо маягаар хийж гүйцэтгэсэн. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Гүйцэтгэл: 100% |
| | 4 | Цэцэрлэгийн гадна үүдний аркийн засварыг хийх | Урд хойд хаалганы саравчны дээврийн засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Гүйцэтгэл: 100% |
| | 5 | Цэцэрлэгийн гадна талаас ордог ангид хөгжлийн бэрхшээлтэй иргэд орж гарахад зориулагдсан налуу шат хийх | Гаднаасаа ордог ангийн шатны зүүн хэсгийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, болон иргэд, эцэг эх асран хамгаалагчид үйлчлүүлэх налуу шатыг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэсэн.<br>Гүйцэтгэл: 80% |
| Цэцэрлэгийн зүгээс | 1 | Барилгын ажлыг хийх явцад барилгын материалыг буулгах, ачих, техник тоног төхөөрөмж орж гарах үед барилгын үндсэн хийц, ногоон байгууламж, хашаа хайсаар болгоомжтой орж гарах, гэмтээхгүй байхад анхаарах | Барилгын гүйцэтгэгч компани ногоон байгууламж, хашаа хайсыг гэмтээхгүй хог хаягдлыг цаг тухай бүрд нь ачиж ажилласан.<br>Гүйцэтгэл: 100% |
| **Дүгнэлт:** | | | |
| Барилгын гүйцэтгэгч “Эл Эс Би” ХХК-тай Дэмжих багийн гишүүдийн харилцан зөвшилцсөн 6 ажлаас 5 ажил бүрэн 100% биелж 1 ажил хагас 80% -ийн биелэлттэй, биелэлт 98%-тай байна. | | | |
| **Биелэлтийг дүгнэсэн хүний нэр, холбоо барих хаяг, утас:** | | | |
| **Дэмжих багийн ахлагч :** Аргазүйч Н.Алагцэцэг Утас: 99034480<br>Цахим хаяг: alagtsetseg.az147@gmail.com | | | |

# ЗУРГИЙН ЦОМОГ










# НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 88 ДУГААР СУРГУУЛЬ




## БИДНИЙ ТУХАЙ

Тус сургууль Улаанбаатар хотоос 22 километрийн зайд Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Хонхор тосгонд байрладаг.1964 онд байгуулагдсанаас хойш 56 дахь жилдээ 31 багш, 25 захиргаа, үйлчилгээ, харуул хамгаалалтын ажилтны бүрэлдэхүүнтэй 19 бүлгийн 446 хүүхдэд боловсролын үйлчилгээг үзүүлж байна.

Сургууль багшлах эрхтэй хүний нөөцөөр 100 хувь хангагдсан. Багш нарын 45 хувь нь залуучууд, 19 хувь нь тэргүүлэх зэрэгтэй , 36 хувь нь заах аргач мэргэжлийн зэрэгтэй. Төрийн дээд “Алтан гадас” одонгоор 2 багш, Засгийн газрын шагнал “Хөдөлмөрийн Хүндэт” медалиар 1 багш, 2 ажилтан; БШУЯ-ны шагнал “Боловсролын тэргүүний ажилтан” цол тэмдгээр 5 багш, “Хүндэт жуух бичиг”-ээр 9 багш тус тус шагнагдсан байна.

## БИДНИЙ АМЖИЛТ

- 2017 онд 11-р хорооны “Шилдэг аж ахуйн нэгж”
- 2018 онд Баянзүрх дүүргийн “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”
- 2018 онд Баянзүрх дүүргийн “Би Монгол Хүүхэд” тэмцээний III байр, хүрэл медаль
- 2016- 2019 онд 4 удаа өмч эзэмшүүлэх гэрээний биелэлт “А” үнэлгээтэй шалгагдсан

- 2015, 2019 оны архивын улсын үзлэгээр “А” үнэлгээтэй шалгагдсан.
- 2019 онд Баянзүрх дүүргийн “Цагаан гэрэл - Ногоон шугам” III байр, хүрэл медаль
- 2017-2019 оны Баянзүрх дүүргийн “Дэвжээ” тэмцээний хошой аварга
- 2019 онд “Баянзүрх дүүргийн тэргүүний сургууль”-аар шалгарсан.

**“Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хэрэгжилт манай сургуульд**



**С.Гэрэл (Нийслэлийн Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын 88 дугаар сургуулийн захирал):**

Манай сургуулийн барилгын их засвар, дулаалгын ажлыг “Саран инж” ХХК нь 455 сая төгрөгийн санхүүжилтээр суурь болон гадна фасадын дулаалга, 104 цонх, 5 хаалгыг сольж, дээврийг хучиж дулаалах, дотор засал, хэд хэдэн газрыг засварлах зэрэг иж бүрэн хийж гүйцэтгэлээ. Сурагчид сурч боловсрох, багш ажилчид ажиллахад хамгийн их тулгарч буй бэрхшээлтэй асуудал нь сургуулийн орчин хүйтэн байсан явдал юм. Сургуулийн орчныг сайжруулан шинэчлэн засварлаж, сурч, ажиллах ая тухтай, таатай орчин бүрдүүлэхэд хамтран ажилласан, төслийн баг, хөрөнгө оруулагч байгууллага, болон дэмжих багийн гишүүд эцэг эх, багш, ажилчдадаа талархаж байна. Энхрий бяцхан шавь нарт маань эрүүл, аюулгүй, таатай орчныг бүрдүүлэхэд дан ганц багш, ажилчдын хүчин чармайлтаар бус эцэг эх оролцон дэмжиж, хамтарч ажилласнаар маш олон эерэг хандлага, туршлага бий болсонд баяртай байна. Энэ төслийн онцлог нь барилгын их засвар, дулаалга хийсэн төдийгүй хүмүүсийн хооронд нөхөрсөг харилцааг бий болгож, түүний үндсэн дээр туршлага болохуйц ажлууд хийгдсэнд оршино.




**Ө.Өсөхбаяр (Нийслэлийн Баянзүрх д үүргийн тэргүүний 88 дугаар сургуулийн нийгмийн ухааны багш):**

Манай сургууль хүйтний улиралд жиндүү, удаан сууж хичээллэхэд тухгүй байдаг байсан. Төслийн хүрээнд хийгдсэн засварын дараа сургуулийн орчин дулаахан, тухтай болсонд тун таатай байна. Сурагч, багш, ажилчдын сурч, ажиллах таатай орчин бүрдсэн тул хүүхдүүдийнхээ ирээдүйн төлөө хамтдаа хичээн ажиллана гэж бодож байна.



**С.Бадамцэцэг (Нийслэлийн Баянзүрх дүүргийн тэргүүний 88 дугаар сургуулийн нягтлан бодогч):**

Манай сургуулийн хувьд 2015 онд дээвэрт засвар хийснээс хойш их засвар хийгдэж байгаагүй, урсгал засвараар дотоод орчинд хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр бага сага ажил хийгдэж байсан. Энэ жил дулаан алдагдлыг бууруулах зорилго бүхий төслийн үр өгөөжийг сургуулийн сурагч, багш, ажилтан бид бүгд хүртэж байна. Манай хамт олны хувьд засварын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг хугацааны туршид туршлага хуримтлуулсан, завгүй, ихийг сурч, мэдсэн үе байлаа. Сургуулийн барилгын засвар эдийн засгийн хувьд хэмнэлт хийгээд зогсохгүй сургуулийн сурагч, багш, ажилтнуудын эрүүл мэндийн хувьд том хөрөнгө оруулалт болж чадлаа.

**Ө.Амаржаргал (Нийслэлийн Баянзүрх дүүргийн тэргүүний 88 дугаар сургуулийн 10а ангийн сурагч Д.Мөнх-Эрдэнийн ээж):**



Сургуулийн барилгад засвар орохоос өмнө цонхоор дулаан их алддаг, хана тааз цантаж мөстдөг байснаас байнга дусаал дусаж шалан дээр ус тогтдог байсан нь хальтарч унах эрсдэл бий болгож хэцүү байдаг байв. Хана таазанд нь будаг шохой тогтохгүй ховхорч унадаг тул өнгө үзэмжээ алддаг байнгын засвар үйлчилгээ шаарддаг байсан. Засвар хийгдсэнээс хойш уур цан арилж, цонхоор дулаан алдахаа больж хана тааз хөлөрч мөөгөнцөр үүсэхгүй, будаг шохой нь ховхорч унахгүй болсон. Эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээ болон дэмжих багийн талаар ойлголттой болж дэмжих баг сургуулийн үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ хийдэг боллоо. Энэ хяналт-шинжилгээ, үнэлгээ нь сургуулийн ирээдүйн үйл ажиллагаанд маш чухал болохыг ойлгож авсан. Хүүхдүүдийн хувьд хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагдан сургууль дээрээ өдрийг өнгөрүүлэх дуртай болсон.

## ЭРСДЭЛГҮЙ ОРЧИН – ЭРҮҮЛ ХҮҮХЭД

| | |
|---|---|
| Зорилго | Сургуулийн орчны зорчих хэсгийн аюулгүй байдлыг хангаж, сурагчдыг эрсдэлээс хамгаалах |
| Нөхцөл байдал, тулгамдсан асуудал | • Сургуулийн хашаа руу орж, гардаг автомашины болон явган хүний хаалга нь зэрэгцэж оршдог.<br>• 68,5 метрийн урттай явган хүний зам, автомашин зорчих хэсгээс тусгаарлах хашлагагүй.<br>• Сургуулийн гадна орчинд замын хөдөлгөөний тэмдэг тэмдэглэгээ, урьдчилан сэргийлэх мэдээлэлтэй самбар байдаггүй.<br>• Сургуулийн урд талын автомашины зорчих хэсэгт хурд сааруулагч байхгүй. Сургуулийн зүүн талын гудамжны үзүүрийн огцом эргэлт дээр булангийн толь байдаггүй байсан.<br>• Сургуулийн хашааны доторх 80.3 $м^2$ талбайд багш, ажилчдын цөөхөн хэдэн машин орж зогсох боломжтой байсан нь гадна зогсох машины тоог нэмэгдүүлж, явган зорчигчдын зорчих хэсгийн талбайг багасгадаг. |

| | |
|---|---|
| | • Сургуулийн хашаан доторх машины зогсоол нь тэмдэг, тусгаарлах шугамгүй тул тухайн талбай дээр хүүхдүүд чөлөөтэй зорчдог байсан.<br>Дээрх нөхцөл байдлаас үүдээд сургуулийн орчинд сурагчид замын хөдөлгөөний эрсдэлд орох аюул үүсээд байсан нь манай сургууль нэг тулгамдсан асуудал байлаа. |
| Зорилтот бүлэг | 446 сурагч, тэдний эцэг эх, 56 багш, ажилчид |
| Шалгуур үзүүлэлт | • Сургуулийн зорчих хэсгийн аюулгүй байдлын талаарх сэтгэл ханамжийн судалгаа (хэмжих нэгж хувиар, суурь он 2020.10 сар)<br>• Замын тэмдэг тэмдэглэгээ (хэмжих нэгж тоо ширхэг)<br>• Сургуулийн гадна орчин дахь хүүхдийн зорчих хэсгийн хэмжээ (хэмжих нэгж метр квадратаар)<br>• Төсөл хэрэгжсэний өмнөх болон дараах үеийн нөхцөл байдлын харьцуулалт (Хяналтын хуудас, фото зургаар) |
| Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат | • Сургуулийн гадаад орчны аюулгүй байдлыг үнэлэх, хяналт-шинжилгээний хуудсаа боловсруулсан.<br>• Дэмжих багийн гишүүдийг оролцуулан уулзалт зохион байгуулсан.<br>• Хяналтын хуудас ашиглан сургуулийн гадаад орчинд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.<br>• Сургуулийн орчим дахь хүүхдийн зорчих хэсгийн хэсгийн аюулгүй байдлыг бууруулах нь хамгийн тулгамдаж байгаа асуудал гэж дэмжих багийнхан үзэж, үнэлгээний үр дүндээ тулгуурлан хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулсан.<br>• Гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу материалын тооцоог гаргаж, эцэг эх, багш ажилчдад танилцуулан элс, хайрга, цемент, төмөр, будаг зэрэг материалыг тэдний дэмжлэгтэй цуглуулсан.<br>• Мужаан, барилгын засал чимэглэлийн мэргэжилтэй эцэг эхчүүдээс авсан саналын дагуу тэдний үндсэн ажлаас гадуур ажиллах цагийн хуваарь гарган ажилласан.<br>• Шинээр автомашины хаалга хийх газрын модыг өөр газар шилжүүлэн суулгаж, талбайг чөлөөлсөн.<br>• Сургуулийн гаднах автомашины хаалгыг зөөж, шинэ чөлөөлсөн талбайд суурилуулсан.<br>• “Саран инж” ХХК-ийн барилгын ажилчдаас холигчийг нь зээлэн зуурмаг бэлтгэж автомашин орох хэсгийг хатуу хучилттай болгов.<br>• Төмөр шонгоор явган хүний зам болон авто машины зогсоолыг тусгаарласан. Шон хооронд тороос татаж |

| | |
|---|---|
| | явган хүний зорчих хэсэг, автомашины зорчих хэсгийг тусгаарлав. Шонгоо будаж, орой дээр нь толгой гагнасан.<br>• Сурагч болон эцэг эхчүүдэд зориулан замын хөдөлгөөнд хэрхэн аюулгүй оролцох тухай сурталчилгааны самбарууд байршуулав.<br>• Дээрх үйл ажиллагааны талаарх туршлагаа сургуулийн веб хуудас, фейсбүүк групптээ байршуулж олон нийтийн хүртээл болгосон. |
| Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд) | • Сургуулийн хашаа руу орж гарах автомашин болон явган хүний хаалгыг тусад нь хийсэн.<br>• Явган хүн зорчих 68,5 м замыг автомашин зорчих хэсгээс тусгаарлах зорилгоор төмөр шон хооронд тороос татсан хашлагатай болгосон.<br>• Сургуулийн гадна орчинд замын хөдөлгөөний тэмдэг тэмдэглэгээ, урьдчилан сэргийлэх 4 мэдээллийн самбар байршуулсан.<br>• Сургуулийн урд талын автомашины зорчих хэсэгт хурд сааруулагч хийсэн.<br>• Сургуулийн зүүн талын гудамжны үзүүрийн огцом эргэлт дээр булангийн толь байрлуулсан.<br>• Сургуулийн хашаан доторх 80.3 $м^2$ талбайн хэмжээг нэмэгдүүлж 160.5 $м^2$ болгон автомашины зогсоолын тоог нэмэгдүүлсэн. Ингэснээр сургуулийн гадна зорчих хэсэгт тавих машины тоог бууруулж, явган зорчигчдын зорчих хэсгийн талбайг чөлөөлж өгсөн.<br>• Сургуулийн хашаан доторх машины зогсоолд тэмдэг байршуулж, тусгаарлах шугам хийж өгснөөр сурагчид аюулгүй байдлаа хангаж, автомашины зогсоолын хэсэгт чөлөөтэй зорчих байдлыг зогсоосон.<br>• Дээрх өөрчлөлтүүдийн үр дүнд сургуулийн орчинд сурагчдыг замын хөдөлгөөний эрсдэлээс сэргийлсэн аюулгүй орчин бүрдээд байна. |
| Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд | • Дэмжих багийн үйл ажиллагааг тогтворжуулах зорилгоор дэмжих баг, сургуулийн захиргааны хамтарсан уулзалтыг төсөл хэрэгжих хугацаанд тогтмол зохион байгуулсан.<br>• Сургуулийн дотоод журамд “Эцэг, эх асран хамгаалагч нь сард нэг удаа өөрийн хүүхдийн ангийн орчинд анги удирдсан багш болон эцэг эхийн зөвлөлтэй хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн сурагчдын аюулгүй байдлыг ханган, сурч хөгжих орчныг бий болгон ажиллана” гэсэн заалт оруулсан.<br>• Хяналт-шинжилгээ, үнэлгээний хуудсыг сургуулийн гадаад хэлний хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүний |

| | |
|---|---|
| | хүртээмжийг үнэлэхэд ашиглан үр дүнг нь сургуулийн захиргаа болон багш нарт танилцуулсны үр дүнд гадаад хэлний хичээлийн хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.<br>Сургуулийн анги, танхимд сурагчдыг эрсдэлээс сэргийлсэн орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд нийт 17 анги танхимд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж орчныг сайжруулах ажил хийж байна. |
| Тулгарсан бэрхшээл, эрсдэл | • Дэмжих багийн зарим гишүүд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйн сургалтад суугаагүй, үнэлгээний талаарх ойлголтгүй байсан учир, дэмжих багийн гишүүдэд сургуулийн зүгээс дахин сургалт зохион байгуулах шаардлага үүсгэсэн.<br>• Эцэг эхчүүдийн боловсролын түвшин ялгаатай, орлого бага, мэдээлэл авах боломж тааруу, сургуулийн үйл ажиллагаанд оролцох оролцоо сул байсан нь энэ ажлыг зохион байгуулахад эхний үед багагүй бэрхшээл, хүндрэлийг бий болгож байсан. |
| Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс | • Аажимдаа эцэг эхийн оролцоо нэмэгдэж эхэлсэн нь амжилт гаргахад нөлөө үзүүлсэн.<br>• Сургуулийн удирдлагын зүгээс үйл ажиллагааг сайн чиглүүлж ажилласан.<br>• Дэмжих багийн үйл ажиллагаа тогтвортой хэрэгжсэн.<br>• Хэн нэгнээс санхүүгийн тусламж авахаас илүүтэй байгаа нөөц бололцоондоо тулгуурлан, өөрт байгаа боломжоо ашиглан сургуулийн үйл ажиллагааг дэмжиж болдгийг эцэг эхчүүдэд ойлгуулсан нь амжилтад эергээр нөлөөлсөн. |
| Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс | • Байгууллага хөгжүүлэх стратеги төлөвлөгөө болон сургуулийн бусад бодлого, хөтөлбөрүүдийг шинэчлэх, нөхцөл байдлыг тодорхойлохдоо заавал дэмжих баг, эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээг зохион байгуулах нь зөв юм.<br>• Сургуулийн бүхий л үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үйл ажиллагааг сайжруулах<br>• Ажлын төлөвлөгөөндөө эцэг эхийн санал санаачилгыг тусган хэрэгжүүлэх, эргэн мэдээлдэг байх зохицуулалтыг сургуулийн дотоод журамд тусган захирлын тушаалаар баталгаажуулах<br>• Үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх бүх үйл явцад багаар ажиллах, санал солилцох, зөвлөлдөх, оролцооны зарчмыг дэмжин ажиллах |

| | |
|---|---|
| | • Өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчлан аль болох олон гэр бүл, эцэг эхийг хамруулж оролцоог нэмэгдүүлэхэд анхааран ажиллах<br>• Жил бүр зохион байгуулдаг тайлант өдөрлөгийн үеэр эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүнг танилцуулж, бусад эцэг эхийн саналыг тусгах |
| Холбоо барих хаяг, лого: | **Нийслэлийн Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Хонхор дахь Ерөнхий боловсролын 88 дугаар сургууль**<br>Цахим хаяг: e-bzd.mn 88-р сургууль<br>Захирал С.Гэрэл, Утас:99135148<br>Цахим хаяг: sededsurengerel@gmail.com<br>Нягтлан бодогч С.Бадамцэцэг Утас: 99287070<br>Цахим хаяг: badamtseseg0604@gmail.com |

## ХАМТЫН АЖИЛЛАГАА – ХАЛУУН ДУЛААН ОРЧИН

| | |
|---|---|
| Зорилго | Стандарт шаардлагад нийцсэн эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй сургалтын таатай орчныг бүрдүүлэх |
| Нөхцөл байдал, тулгамдсан асуудал | • Сургуулийн барилга 32 жил болсон, стандартын дагуу баригдаагүй, дулаан алдагдал ихтэй.<br>• Барилгын суурийн дулаалга нь хуучирч хагарсан, сургуулийн захын анги танхим, өрөө тасалгаанууд хүйтэн, сургалт явуулахад тухгүй байдаг учраас багш, ажилтан болон сурагчдын дунд өвчлөл их гардаг.<br>• Сургуулийн барилгын урд хэсгээр дулаалгын хөөсөнцөртэй бусад хэсэгт огт дулаалга хийгдээгүй, дотор ханын зарим хэсэгт ус чийгээс үүдэлтэй мөөгөнцөр үүссэн.<br>• Вакум цонхны шил нь хоёр давхар учир хөлөрч цантдаг, хүйтний улирал эхлэхэд шилэнд цуурал үүсэж эхэлдэг.<br>• Агааржуулалтын хоолойг сэтгэж цэвэрлээгүй удсан, өмнөх дулаалгын үеэр агааржуулалтын нүхийг бөглөсөн, хаалга муудаж, хуучирч зай завсар гарсан байсан.<br>• Дээврийн дулаалга муудсанаас болж таазны шохой эмульс тогтохгүй байнга хуурч унадаг, дээврийн ус зайлуулах хаялга нь хуванцар хоолойгоор хийгдсэн, өвөл хөлдөөд хавар болохоор цуурал үүсдэг.<br>• Сургуульд тулгамдаж буй асуудлын талаарх эцэг эхийн ойлголт тааруу, дулааны алдагдлыг шийдвэрлэх санхүүжилт байхгүй байсан. |

| | |
|---|---|
| | Дээрх нөхцөл байдал нь дулаан алдагдал ихтэй тав тухгүй байдлыг бий болгоход нөлөөлж байсан. |
| Зорилтот бүлэг | 446 сурагч, тэдний эцэг эх, 56 багш, ажилчид |
| Шалгуур үзүүлэлт | • Сургуулийн барилга байгууламж, орчин нөхцөлийн талаарх сэтгэл ханамжийн судалгаа (хэмжих нэгж хувиар)<br>• Орчны агаарын температур, чийгшлийн хэмжээ (хэмжих нэгж температур)<br>• Дулаалгын ажлын өмнөх ба дараах үеийн харьцуулалт (Хэмжих нэгж: хяналтын хуудсаар суурь он 2019.10 сар 2020.10 сар)<br>• Сурагч, багш, ажилтны дунд өвлийн улиралд гардаг өвчлөлийн хувь (эмчтэй хамтарч хийсэн судалгааны үр дүнгээр) |
| Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат | • Төсөл хэрэгжих байгууллагаар сонгогдон, захирал сургалтад хамрагдан, сургууль дээрээ сургалт зохион байгуулсан.<br>• Захирлын тушаалаар дэмжих багийг байгуулан дэмжих багийн гишүүдээ чадавхжуулах сургалтад 4-5 удаа хамруулсан.<br>• Дэмжих багийн гишүүд хяналт-шинжилгээ, үнэлгээний хуудас боловсруулж, тухайн хуудасны дагуу хяналт хийж дүгнэлт гаргасан.<br>• Хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх мэдээллийг 11 дүгээр хорооны иргэд, сурагчдын эцэг эх, асран хамгаалагчдад түгээсэн.<br>• Багш ажилчид, дэмжих багийн гишүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>• Үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх хуваарь боловсруулсан.<br>• Дэмжих багийн гишүүд барилгын засварын явцад өдөр тутам хяналт хийснээс гадна засварын ажлын эхэн, дунд, эцсийн шатанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.<br>• Үе шат бүрийн үнэлгээний дүгнэлтэд үндэслэн тухайн цаг үед тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар гүйцэтгэгч компанитай харилцан ярилцаж, зөвшилцөж ажилласан.<br>• Сар бүр хийсэн ажлынхаа тайланг боловсруулж холбогдох шатны байгууллагад тайлагнаж ажилласан. |
| Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд) | • Сургалтын орчин дулаахан болж багш ажилтан, сурагчдын дунд өвлийн улиралд зонхилон гардаг өвчлөл 36 хувиар буурсан. |

| | |
|---|---|
| | • Сургуулийн сургалтын орчин нөхцөлийн талаарх багш, ажилтан, сурагчдын сэтгэл ханамж өмнөх онтой харьцуулахад 23 хувиар нэмэгдсэн<br>• Таазны шохой, эмульс хуурч унахгүй болсон нь эдийн засгийн хувьд хэмнэлт бий болгон үйлчилгээний ажилчдын ажлыг хөнгөвчилсөн.<br>• Барилгын их засварыг чанар стандарт шаардлагад нийцсэн, тохирлын гэрчилгээтэй, лабораторийн шинжилгээний бичигтэй баталгаатай материалаар стандартын шаардлагад нийцсэн, батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэгч компани хийж гүйцэтгэсэн.<br>• Орчны агаарын температур 8-9 хэмээр нэмэгдсэн. |
| Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд | • Сургуулийн дотоод орчин болон сургалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаа бодит судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, тоо баримтаар баталгаажуулж шийдвэрлэх арга замыг багаараа эрэлхийлэх ажлыг эхлүүлж байна.<br>• Сар бүр сургуулийн захиргаа, дэмжих багийн гишүүдийн хооронд уулзалт зохион байгуулж сургалт зохион байгуулах, хийх ажлын төлөвлөгөө боловсруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээний хуудас боловсруулах, өөрсдийн үйл ажиллагааг тус хорооны иргэд, сурагчдын эцэг эх, асран хамгаалагчдад таниулах  ажлыг хийж байна. |
| Тулгарсан бэрхшээл, эрсдэл: | • Зуны улирал таарсан учраас багш, ажилчид ээлжийн амралтаа авсан нь мэдээлэл түгээх ажлыг удаашруулж байсан.<br>• Зарим үед дэмжих багийн гишүүн эцэг эхийн төлөөлөл өөрийн үндсэн ажлаа хийгээд дэмжих багийн үйл ажиллагаанд оролцож чадахгүй байсан нь дэмжих багийн төлөвлөгөөт ажил тасалдан төлөвлөгөөг өөрчлөхөд хүргэж байсан.<br>• Барилгын засвар хийхэд ашиглагдах материалын талаарх дэмжих багийн гишүүдийн мэдлэг дутмаг байсан нь хяналт тавихад бэрхшээл учруулж байв. |
| Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс | • Эцэг эхийн оролцоо сайн, удирдлагын чиглүүлэг сайн байсан.<br>• Дэмжих багийн үйл ажиллагаа тогтвортой хэрэгжсэн, давуу тал, нөөц боломжоо харж ашиглаж сурсан.<br>• Зөвлөх багийн зүгээс дэмжих багийн гишүүдэд зориулан хэд хэдэн удаагийн сургалт, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулсан нь гишүүдийн үйл ажиллагааны тогтвортой байдал хангагдахад эергээр нөлөөлсөн. |

| | |
|---|---|
| Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс | • Байгууллага хөгжүүлэх стратеги төлөвлөгөө болон сургуулийн бусад бодлого, хөтөлбөрүүдийг шинээр болон шинэчлэн боловсруулахдаа дэмжих баг, эцэг эхийн оролцоот хяналт- шинжилгээ, үнэлгээний аргыг хэрэглэх<br>• Сургуулийн бүхий л үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дахин сайжруулах, хөгжүүлэх<br>• Ажлын төлөвлөгөөндөө эцэг эхийн санал, санаачилгыг тусган хэрэгжүүлэх, эргэн мэдээлдэг байх зохицуулалтыг сургуулийн дотоод журамд тусган захирлын тушаалаар баталгаажуулах<br>• Үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх бүх үйл явцад багаар ажиллах, санал солилцох, зөвлөлдөх, оролцуулах зарчимд суурилан ажиллах<br>• Өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчлан аль болох олон эцэг эхийг хамруулж оролцоог нэмэгдүүлэх<br>• Жил бүр зохион байгуулдаг тайлант өдөрлөгтөө эцэг эхийн оролцоотой хийгдсэн ажлыг үнэлэх, бусдад танилцуулах, эцэг эхчүүдээ урамшуулах, бусад эцэг эхийн санаачилгыг нэмэгдүүлэх |
| Холбоо барих хаяг, лого: | **Нийслэлийн Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Хонхор дахь Ерөнхий боловсролын 88 дугаар сургууль**<br>Цахим хаяг: e-bzd.mn 88-р сургууль<br>Захирал С.Гэрэл, Утас: 99135148<br>Цахим хаяг: sededsurengerel@gmail.com<br>Нягтлан бодогч С.Бадамцэцэг, Утас: 99287070<br>Цахим хаяг: badamtsetseg0604@gmail.com |

**БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДУЛААЛГЫН АЖЛЫН ЯВЦАД ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Дүүрэг: Баянзүрх Сургууль: 88 дугаар сургууль
Огноо: 2020 оны 07 дугаар сарын 24

| **БАРИЛГЫН ЗАСВАРЫН АЖЛЫН ҮЙЛ ЯВЦ ЭХЭЛСНЭЭС ХОЙШ ЦУГЛУУЛАХ МЭДЭЭЛЭЛ** | | | |
|---|---|---|---|
| **Шалгуур** | | **Тэмдэглэгээ** | **Тайлбар/дэлгэрэнгүй** |
| 3.1 | Барилгын зураг төсөлд тэмдэглэгдсэн бүх цонх, гадна хаалгыг шинэчлэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | • Сургуулийн хаалттай байсан 4 цонхыг шинээр нээж, бусад 100 цонхыг сольж нийт 104 ширхэг суулгаад байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | • Гадна 5 хаалгыг бүгдийг сольж металл хаалга болгон шинэчилж байна. |
| 3.2 | Цонх, хаалганы байрлал түүний ус тусгаарлалт, битүүмжлэлийн үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | • Цонхны рамын өргөн: 7 см<br>• Давхар шилний тоо: 3<br>• Цонхны хүрээний таславчийн тоо: 5 |
| 3.3 | Гадна ханыг иж бүрэн, зохих зузаанаар дулаалах үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | • Хөөсөнцрийн зузаан.15 см<br>• Нягт: 19м$^3$<br>• Грунт: SAMHWA 2019/06/14<br>• Хөөсөнцрийн цавуу: 999 BLACK MIXTURE |
| 3.4 | Дээврийн дулаалгыг иж бүрэн хийх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | • Дээврийг хучилт хийгдэж, хар цаасаа нааж дууссан.<br>• Хар лакаар амсар дарах ажил хийгдэж байна.<br>• Даравч төмрийг хийж эхэлсэн. |
| 3.5 | Цонхны амлагаа болон дотор тавцангууд бүрэн хийгдэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | • Бүрэн суугдаж дууссан, дулаалга хийгдсэн. Цонхны тавцангуудыг хийж, амлагаа хийж эхэлж байна. |
| 3.6 | Халаалтын системийг зургийн дагуу гүйцэтгэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ **Ажил дуусах шатандаа** | • Гүйцэтгэгч байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр цайны газрын хойд хэсэг болон шинээр гаргасан аваарын шатанд 24 секц паар, 40 метр ф20 труба тавив. |
| 3.7 | Сантехникийн тоноглолууд иж бүрэн, хүүхдийн аюулгүй байдлыг хангасан эсэх | ○ **Огт тусгагдаагүй**<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа | |
| 3.8 | Дээвэрт ус нэвтрэхгүй битүүмжлэх үйл явц | ○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ **Ажлын явц дунд шатандаа**<br>○ Ажил дуусах шатандаа | Бетонон зуурмагийн хучилт хийгдэж дуусаад хөрсжүүлэлт хийгдэж байна. |

<table>
<tr><td>3.9</td><td>Цэвэр, бохир усны шугам шаардлагатай стандартын дагуу хийгдэх үйл явц</td><td>○ Огт тусгагдаагүй<br>○ Огт эхлээгүй<br>○ Ажил эхлэх шатандаа<br>○ Ажлын явц дунд шатандаа<br>○ Ажил дуусах шатандаа</td><td></td></tr>
<tr><td>1.</td><td colspan="3">Ажиглагдсан зөрчил, дутагдал:<br>• Цонхны таславч 7 байхаас 5 байсан. Гүйцэтгэгч байгууллагад мэдэгдсэн.<br>• Нийтийн бие засах газрын дээврийг төмөрлөх явцад завсар гарсан тул бага хэмжээний ус орсон байсан. Хяналтын инженерт харуулж шаардлагатай арга хэмжээг авав.<br>• Цайны газрын хойд хэсэгт дотор засал хийх явцад чийгтэй, нар үзэхгүй хүйтэн байдгаас замаск хатахгүй, нэмэлт халаагуур тавьж хатаасан.<br>• Барилгын засварын материалыг бороотой үед сайтар хучиж хамгаалаагүй тул зарим нь чийг авч норсон байсныг хэлж солиулсан.</td></tr>
<tr><td>2.</td><td colspan="3">Цаашид анхаарах зүйлс:<br>• Барилгын ажлыг хийх явцад материалыг буулгах, ачих, техник тоног төхөөрөмж орж, гарах үед барилгын үндсэн хийц, ногоон байгууламж, хашаа хайсаар болгоомжтой орж, гарах, гэмтээхгүй байхад анхаарах<br>• Барилгын ажлыг гүйцэтгэх явцад хог хаягдлыг тухай бүрд нь ачиж холдуулах<br>• Барилгын дээврийн болон гадна фасадын дулаалгын ажил хийх явцад байгалийн хүчин зүйлээс шалтгаалан ажлын бүтээмж муудахаас сэргийлж төлөвлөгөөг маш нарийн гаргаж ажиллах<br>• Барилгын дулаалгад ашиглагдаж байгаа бараа материалд сургуулийн удирдлага болон дэмжих багийн зүгээс хяналт тавих<br>• Барилгын материалын чанар, сурагчид болон багш ажилчдын эрүүл мэндэд ээлтэй, эргэн тойрны орчинд эрсдэлгүй, он удаан жилийн хугацаанд элэгдэл бага, тогтоц сайтай чанартай бараа материалаар хийлгэх<br>• Дэмжих баг болон удирдлагын хийсэн хяналт, барилгын материалын талаарх мэдээллээ харилцан тохиролцох, мэдээлэл солилцох ажлыг зохион байгуулах</td></tr>
<tr><td>3.</td><td colspan="3">Барилгын их засвар, дулаалгын явцын талаарх ерөнхий дүгнэлт:<br>2020 оны 7 сарын 24-ны өдрийн байдлаар барилгын их засвар, дулаалгын ажил төлөвлөсний дагуу гүйцэтгэгдэж байна. Талууд хамтран ажилласнаар стандартын шаардлагад нийцсэн, батлагдсан зураг төслийн дагуу зохион байгуулалт сайтай явагдаж байна. Барилгын дулаалгын ажлыг чанарын стандартад нийцсэн, шаардлага хангахуйц тохирлын гэрчилгээтэй, лабораторийн шинжилгээний бичигтэй баталгаатай материалаар гүйцэтгэж байна. Дээврийн дулаалгын 30%-ийг ам даруулж, зай завсрыг чигжиж хийсэн. Цонхны дулаалгын зурагт заасны дагуу шинээр суурилуулж хуучин цонхоо өмч хариуцах газар хүлээлгэн өгөхөд бэлэн болголоо. Суурийн дулаалгын ажил 20 хоногийн хугацаанд бүрэн хийгдэж дууссан ба хог хаягдлыг цэвэрлэж байна. Цайны газрын хойд хэсгийн мөөгөнцөртөж муудсан хэсгийг хусаж цэвэрлэн заслын ажлыг хийж эхэлсэн. Энэ хэсэг хүйтэн байдгаас цан цохиж байнга мөөгөнцөр үүсдэг тул нэмэлт халаалт тавиуллаа. Мөн аваарын шатны гарцыг нээж дотор заслын ажлыг хийж, цонхны хэсгийг хааж өрсөн тоосгыг авч, цонх</td></tr>
</table>

| | |
|---|---|
| | суурилуулсан. Мөн халаалт нэмж тавиулсан. Хуучин спорт заалны хүзүүвчийг даамны сонгон хичээллэдэг байсан жижиг өрөөтэй нэгтгэн том өрөө болгон засварлаж байна.<br>Барилгын дээвэр - 90%<br>Цонх суулгалт - 100%<br>Суурийн дулаалга - 100%<br>Цонхны амлагаа болон дотор засал - 80%<br>Ханын дулаалга - 55%<br>Гадна хаалга шинэчлэх ажил - 100%<br>Нийт засварын ажлын гүйцэтгэл 87.5% - тай явагдаж байна. |
| **Ажиглалт хийсэн хүний нэр, холбоо барих хаяг, утас** | |
| Баянзүрх дүүргийн 88-р сургуулийн Дэмжих багийн ахлагч Л.Даваамаа<br>Утас: 88022838 | |

**ЗӨВШИЛЦЛИЙН ХУУДАС**

*Нийслэлийн Баянзүрх дүүргийн 88 дугаар сургуулийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа САРАН ИНЖ ХХК нь “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хүрээнд зохион байгуулалтад орсон “Дэмжих баг”-ийн гишүүдийн барилгын засвар, дулаалгын ажлын явцад хийсэн эцэг эхийн оролцоот, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, санал дүгнэлттэй танилцлаа.*

**Дэмжих багийн гишүүдийн тайланд туссан дараах зүйлсийг гүйцэтгэгч их засвар, дулаалгын явцад тусгаж ажиллахаа талууд харилцан зөвшилцлөө.**

**Гүйцэтгэгч компанийн зүгээс**:

- Магадалшгүй ажлыг сургуулийн удирдлага болон дэмжих багийнхантай хамтран тодорхойлов.

**Үүнд:**

  - Нэг болон хоёрдугаар давхрын таазыг засварлах
  - Аваарын шатыг засварлах
  - Цайны газрын таазыг засварлах
  - Цайны газрын агааржуулалтын хоолойн сэнсийг хүчин чадал өндөртэй сэнсээр солих
- Дээрх асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтээ Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын Газарт тавих
- Агааржуулагч хоолойг өндөрлөж өрлөг өрөх
- Цонхны эргэн тойронд нөхөөс хийх
- Даамны өрөөнд хулдаас наах
- Сургуулийн дотор талын төлөвлөсөн газруудад шинээр хаалга суурилуулах
- Барилгын хог хаягдлыг Саран инж ХХК өөрийн хөрөнгөөр ачиж, цэвэрлэх

**Сургуулийн зүгээс**:

- Нийтийн бие засах газрын агааржуулалтын хоолойг өндөр болгох, өөрөө эргэдэг сэнс тавих

| | | |
|---|---|---|
| ▪ Анги танхимын цонхны тавцан, амлагаар хийхэд саад болзошгүй ханaнд тогтоогдсон тавиурыг авч чөлөөлөх<br>▪ Дэмжих багийн гишүүд хуваарийн дагуу хяналт тавьж ажиллах<br>▪ Тавьсан хяналтын дагуу гарсан зөрчил дутагдалд авсан арга хэмжээг дэмжих багийн ахлагчид тогтмол мэдээлэх | | |
| **Дэмжих багийн ахлагч**<br>Л.Даваамаа | **Хяналтын инженер**<br>С.Сарантуяа | **Компанийн захирал**<br>О.Дагвадож |

## ЗӨВШИЛЦЛИЙН ХУУДАСНЫ БИЕЛЭЛТ БУЮУ ДҮГНЭХ ХУУДАС

| | | | |
|---|---|---|---|
| *Нийслэлийн Баянзүрх дүүргийн 88 дугаар сургуулийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа САРАН ИНЖ ХХК болон “Дэмжих баг”-ийн гишүүдийн харилцан зөвшилцсөн ажил, үйлчилгээ дор дурдсан байдлаар биелэгдсэн байна.* | | | |
| **Харилцагч талууд** | **Д/д** | **Зөвшилцсөн ажлууд** | **Ажлын биелэлт** |
| Гүйцэтгэгч компанийн зүгээс | 1 | Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын Газарт хүсэлт тавьснаар дараах ажлууд хийгдэж байна. | ▪ Нэг болон хоёрдугаар давхрын таазыг засварлах<br>▪ Аваарын шатыг засварлах<br>▪ Цайны газрын таазыг засварлах<br>▪ Цайны газрын агааржуулалтын хоолойн сэнсийг хүчин чадал өндөртэй сэнсээр солих<br>Ажлууд жигдэрч хараахан эхлээгүй, гүйцэтгэл 25% |
| | 2 | Агааржуулагч хоолойг өндөрлөж өрөх | Агааржуулалтын хоолойг өндөрлөж өрж байна.<br>Гүйцэтгэл: 80% |
| | 3 | Цонхны эргэн тойронд нөхөөс хийх | Цонхны эргэн тойронд нөхөөс хийж өрөө тасалгаа, анги танхимын ханыг өнгийн дагуу будаж янзалсан<br>Гүйцэтгэл: 100% |
| | 4 | Даамны өрөөнд хулдаас наах | Даамны өрөөнд хулдаас наасан.<br>Гүйцэтгэл: 100% |
| | 5 | Сургуулийн дотор талд төлөвлөсөн газруудад шинээр хаалга суурилуулах | Сургуулийн дотор талд нийтдээ 6 ширхэг модон хаалга суурилуулсан.<br>Гүйцэтгэл: 100% |
| | 6 | Саран инж ХХК нь өөрийн хөрөнгөөр барилгын хог хаягдлыг ачиж, цэвэрлэх | Саран инж ХХК нь өөрийн хөрөнгөөр барилгын хог хаягдлыг ачиж, цэвэрлэсэн.<br>Гүйцэтгэл: 100% |

| | | | |
|---|---|---|---|
| Сургуулийн зүгээс | 7 | Нийтийн бие засах газрын агааржуулалтын хоолойг өндөр болгох мөн өөрөө эргэдэг сэнс тавих Дэмжих багийн гишүүд хуваарийн дагуу хяналт тавьж ажиллах | Гүйцэтгэгч байгууллагатайгаа харилцан тохиролцсон. Нийтийн бие засах газрын агааржуулалтын хоолойг өндөр болгож, өөрөө эргэдэг сэнс тавиулсан. Гүйцэтгэл: 100% |
| | 8 | Анги танхимын цонхны тавцан, амлагаар хийхэд саад болзошгүй хананд тогтоогдсон тавиурыг авч чөлөөлөх | Анги танхим, өрөө тасалгааны цонхны тавцан, амлагаар хийхэд саад болзошгүй хананд тогтоогдсон тавиурыг авч чөлөөлсөн. Гүйцэтгэл: 100% |
| | 9 | Дэмжих багийн гишүүд хуваарийн дагуу хяналт тавьж ажиллах | Дэмжих багийн гишүүд хуваарийн дагуу хяналт тавьж ажилласан. Гүйцэтгэл: 100% |
| | 10 | Тавьсан хяналтын дагуу гарсан зөрчил дутагдалд авсан арга хэмжээг дэмжих багийн ахлагчид тогтмол мэдээлэх | Тавьсан хяналтын дагуу гарсан зөрчил дутагдалд авсан арга хэмжээг дэмжих багийн ахлагчдаа тогтмол мэдээлж ажилласан. Гүйцэтгэл: 100% |
| **Дүгнэлт:** | | | |
| Барилгын гүйцэтгэгч “САРАН ИНЖ” ХХК-тай Дэмжих багийн гишүүдийн харилцан зөвшилцсөн 10 ажлаас 8 ажил бүрэн 100% биелж, 1 ажил 25% биелэлттэй, нөгөө ажил 80%-тай байна. | | | |
| **Биелэлтийг дүгнэсэн хүний нэр, холбоо барих хаяг, утас:** | | | |
| Баянзүрх дүүргийн 88-р сургуулийн Дэмжих багийн ахлагч Л.Даваамаа Утас: 88022838 | | | |

## ЗУРГИЙН ЦОМОГ


















# НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 115 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ



## БИДНИЙ ТУХАЙ

Баянзүрх дүүргийн 115 дугаар цэцэрлэг нь 5 дугаар хороонд байрладаг. 1987 онд 6 бүлэг, 120 хүүхдийн хүчин чадалтай, 31 багш, ажилчидтай байгуулагдсан. 2016 онд өргөтгөлийн барилга баригдаж 6 бүлэг, 2018 онд Батлан хамгаалах яамны дэргэдэх “Цоглог” салбар цэцэрлэг тус тус ашиглалтад орж, 71 багш ажилтантай, 17 бүлэгт 700 гаруй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгож байна. Мэргэжлийн боловсон хүчнээр 100 хувь хангагдсан, нийт багш нарын 75 хувь нь бакалавр, 25 хувь нь магистр зэрэгтэй. Цэцэрлэгийнхээ онцлогийг тусгасан сургалтын үзэл баримтлалтай. Бидний эрхэмлэх зүйлс “Хүүхэд бүрд - баяр баясгалан, инээд хөөрийг, Эцэг эх бүрд-итгэл найдварыг, Багш бүрд-урам зориг” өгөхөд чиглэсэн байдаг. Хүүхэд бүр урлан бүтээх, үйл хийж байх явцдаа хөгжинө гэсэн чиглэлийг баримталдаг.

## БИДНИЙ АМЖИЛТ

- 1999 онд Баянзүрх дүүргийн “Тэргүүний цэцэрлэг”

- 2010 онд Нийслэлийн Хүүхдийн төлөө газрын “Хүүхдэд ээлтэй байгууллага”
- 2010 онд Нийслэлийн Хүүхэд залуучуудын газрын “Хүүхдийн авьяасыг дэмжигч байгууллага“
- 2012 онд “Дүүргийн тэргүүний цэцэрлэг”
- 2013 онд “Нийслэлийн Шилдэг ногоон байгууламжтай цэцэрлэг”- Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Байгаль хамгаалах сан, Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газар
- 2016 онд “Нийслэлийн тэргүүний цэцэрлэг”
- 2016 онд Баянзүрх дүүргийн “Боловсролын шилдэг байгууллага”-аар тус тус шалгарсан.

## “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн хэрэгжилт манай цэцэрлэгт



**Ё.Жаргалмаа (Нийслэлийн Баянзүрх дүүргийн 115 дугаар цэцэрлэгийн эрхлэгч):**

Манай цэцэрлэгийн барилга 33 жил болсон, барилгын хийц чанар муудсан, дулаан алдагдал ихтэй, чийг үнэртдэг, хөгц мөөгөнцөр үүссэн байдалтай байсан. Үүнээс үүдэн хүүхдүүд өвчлөмтгий, багш ажилчид тав тухгүй орчинд ажиллаж байсан. “Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөлд манай цэцэрлэг хамрагдсанаар энэ бүх асуудлыг шийдэж, хүүхдүүд маань дулаахан, тав тухтай орчинд сурч хөгжиж, багш ажилчид, эцэг эхчүүд сэтгэл хангалуун байна. Энэ төслийн онцлог нь барилгын дулаалга, их засварыг хийгээд зогсохгүй эцэг эхчүүдийн оролцоонд тулгуурлан цэцэрлэгийн орчин нөхцөл, барилгын засварын явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, засварын ажлыг чанартай гүйцэтгэж, хүүхдийн сурч хөгжих таатай орчныг бий болгоход чухал нөлөө үзүүлсэн. Засварын ажлыг хариуцлагатай, чанартай гүйцэтгэсэн бөгөөд хяналтын инженер Д.Эрдэнэтуяа тухай бүрд нь хяналт тавьж барилгын компанитай хамтарч ажилласан. Төслийн багаас “Дэмжих баг”-ийн гишүүдийг чадавхжуулж ажиллаж байсан нь цаашид эцэг эхийн оролцоог чухалчилж, аливаа хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг тооцож алдаа дутагдлаа засаж сайжруулахын чухлыг ойлгууллаа.



**Ц.Наранжаргал (Нийслэлийн Баянзүрх дүүргийн 115 дугаар цэцэрлэгийн арга зүйч, дэмжих багийн ахлагч):**

Манай цэцэрлэгийн цонх, хаалга, дээврээс маш их дулаан алддаг, дулааны улиралд ус бороо нэвчиж, дусаал их гоождог байсан. Энэхүү төслийн хүрээнд бидэнд тулгамдаад байсан дээрх бэрхшээлүүд шийдэгдэж дулаахан, саруулхан танхимдаа тав тухтай сурч хөгжих хүүхдүүдээ хараад багш ажилчид болон эцэг эхчүүд маань маш их сэтгэл хангалуун байна. Энэхүү төслийн хүрээнд эцэг эх, багш, ажилчдын төлөөллөөс бүрдсэн “Дэмжих баг” байгуулагдан төсөл хэрэгжих хугацаанд “Эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ”-г таван удаа хийж хүүхдийн сурч хөгжих эрүүл аюулгүй, таатай орчин бий болгох үүднээс цэцэрлэгийн дотоод, гадаад орчинд эрсдэл бүхий хэсгүүдийг илрүүлэн, засаж сайжруулах төлөвлөгөө гарган өөрчлөлт хийсэн. Төсөл хэрэгжсэнээр эцэг эхийн үүрэг, оролцоо нэмэгдэж шүүмжлэгч, ажиглагч биш хамтрагч, санаачлагч болон өөрчлөгдөж цэцэрлэгийн үйл ажиллагаанд оролцож, багшийн болон цэцэрлэгийн явуулж буй ажлыг дэмжиж хамтарч ажиллах сонирхолтой болсон. “Дэмжих баг”-т хамтран ажилласан эцэг эхчүүд маань бусад эцэг эхчүүдэд эергээр нөлөөлөн тэдний оролцоо ямар чухал болохыг бодитоор харуулж чадсанд баяртай байна.



**Н.Шүрэнцэцэг (Нийслэлийн Баянзүрх дүүргийн 115 дугаар цэцэрлэгийн багш):**

Манай анги цонхоороо дулаан алддаг, дээврээс ус гоождог, мөөгөнцөр үүссэн байсан. Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан урсгал засвар жил бүр хийдэг байсан ч асуудлыг бүрэн гүйцэд шийдвэрлэж чаддаггүй байлаа. 2019-2020 онд манай цэцэрлэг гадна дулаалга, цонх, хаалга, дээврийн дулаалгад их засвар хийсэн. Багш ажилчид дулаахан таатай орчинд ажиллаж, хүүхдүүд маань эрүүл аюулгүй орчин сурч хөгжих болсонд сэтгэл хангалуун байна. Бид эцэг эх, багш, ажилтнаас бүрдсэн “дэмжих баг” бүрдүүлэн чадавхжуулах шат дараатай сургалтад хамрагдан, барилгын их засвар, дулаалгын талаарх мэдлэгтэй болоод зогсохгүй, эцэг эхтэй хамтран, хяналтын хуудас боловсруулан хамтран үнэлгээг хийж өөр хоорондоо харилцах ярилцан,

тулгарсан бэрхшээлийг даван туулах боломжийг эцэг эхчүүдтэйгээ хамтран эрэлхийлж байсан нь хамгийн чухал зүйл байлаа.

**Т.Бадамсүрэн (Нийслэлийн 115 дугаар цэцэрлэгийн дэмжих багийн гишүүн, дунд “Б” бүлгийн Г.Хангалын ээж):**



Манай цэцэрлэг "Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь" төслийн хүрээнд барилгын дулаалгын иж бүрэн ажил хийгдсэн. Энэ төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх дэмжих багт орж ажилласан. Манай цэцэрлэгийн хувьд тендер шалгаруулалтын явцад маргаан гарч, ажил эхлэх хугацаа нэлээд хойшилж эхэлсэн ч амжилттай хэрэгжиж дууссан. Барилгын засварын ажлын явцад гүйцэтгэгч компанийн зүгээс мэдээллээр сайн хангаагүй, төслийн багийн зүгээс цаг хугацааны хувьд зохион байгуулалтын ажлууд хоцорч хийгдсэн гэж үзэж байна. Гэхдээ барилгын дулаалгын ажил төсөл хэрэгжих хугацаанд багтаж дууссан. Цэцэрлэгийн барилгын дээврийн дулаалга, гадна ханын дулаалгын ажил, цонх хаалгыг дулаан алдагдал хамгийн бага үзүүлэлттэй материалаар хийгдсэн, зураг төсөлд заагдсан цонх хаалгаар сольж иж бүрэн хийгдсэн. Энэ ажлын хүрээнд барилгын дулаалга, материал технологийн талаар маш их мэдлэг хуримтлуулж авлаа. Бас боловсролын байгууллагын үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог хангаснаар хамтын ажиллагаа сайжирч, үл ойлголцол арилах эерэг үр дүн харагдаж байгаа нь сайхан байлаа. Бидний бяцхан үрс даарахгүй, өвчин тусахгүй, дулаан тухтай сурч боловсрох болсонд туйлын баяртай байна.

## ТОГЛООМЫН ТАЛБАЙН ТОХИЖИЛТ

| | |
|---|---|
| Зорилго | Бага насны хүүхдийн тоглох хэрэгцээг хангах эрсдэлгүй орчныг цэцэрлэгийн гадна талбайд бүрдүүлэх, хүүхдийн сонирхол хэрэгцээнд тулгуурласан тоглоом хэрэглэгдэхүүнтэй болох |
| Нөхцөл байдал, тулгамдсан асуудал | • Тоглоомын талбайн тоглоом хэрэглэгдэхүүн шаардлага хангахгүй, эвдрэл гэмтэлтэй<br>• Тоглоомын талбай зөөлөвч хамгаалалтгүй, хатуу цементэн талбайтай<br>• Тоглоомын талбайг тойрсон мод бутны хэлбэр алдагдсан.<br>• Тоглоомын талбайд 2 муу усны нүх байдаг зэрэг нөхцөл байдлаас хамааран дараах асуудал тулгамдаж байсан.<br>Үүнд:<br>• Хүүхдийн тоглох хэрэгцээ хангагдаагүй |

| | |
|---|---|
| | • Тоглоомын талбай дээр унаж бэртэх эрсдэлтэй<br>• Мод бут хүүхдийн нүд рүү орж хатгах, нүүрийг нь урах эрсдэл үүссэн<br>• Муу усны нүхэнд унаж бэртэх зэргээр сургуулийн гадаах орчинд хүүхдэд ээлтэй орчин бүрдээгүй байсан. |
| Зорилтот бүлэг | 13 бүлгийн хүүхэд, эцэг, эх, багш, ажилчид |
| Шалгуур үзүүлэлт | • Тоглоомын талбайн ойролцоох худаг, муу усны нүхэнд зориулалтын баталгаатай хаалт, хамгаалалт хийсэн байх<br>• Ногоон байгууламжийн мод бутыг хэлбэржүүлэх, засан сайжруулсан байх<br>• Тоглоом хэрэглэгдэхүүнийг бүрэн солих, шинэчилсэн байх<br>• Тоглоомын талбайд зөөлөвч бүхий хамгаалалт хийсэн байдал |
| Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат | • Эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх дэмжих баг байгуулсан.<br>• Дэмжих багаараа чадавхжуулах сургалтад хамрагдсан.<br>• Тоглоомын талбайд эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.<br>• Илэрсэн зөрчил дутагдал болон тэдгээрийг хэрхэн засан сайжруулах талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн.<br>• Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан гүйцэтгэх ажлын төлөвлөгөө боловсруулсан.<br>• Томоохон ажлуудыг хийж гүйцэтгэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлсон.<br>• Төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.<br>• Байгууллагын багш, ажилчид, эцэг, эхийн оролцоонд тулгуурлан боломжит ажлуудыг хийж гүйцэтгэсэн. |
| Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд) | • Тоглоомын талбай дахь эргэн тойрны мод бут ногоон байгууламжийг тайрч хэлбэржүүлсэн.<br>• Тоглоомын талбайн ойролцоох худаг, муу усны нүхэнд хүүхдэд эрсдэл үүсгэхээргүй зориулалтын хамгаалалт хийсэн.<br>• Тоглоомын талбайг бүрэн сольж шинэчлэх хүсэлтийг холбогдох газруудад хүргүүлсэн.<br>• Тоглоомын талбайг сольж шинэчлэх төсөв батлагдаж “Тэнгисийн шүр” ХХК хийж гүйцэтгэхээр гүйцэтгэлийн зураг гарч засварын материалын татан буулгасан. |
| Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд | • Цэцэрлэгийн хөдөлмөрийн дотоод журмын 3.35-д “Багш ажилтан байгууллагын эд хөрөнгийг зүй зохистой хэрэглэх, ашиглах, эвдрэл гэмтэл учруулсан тохиолдолд засварлах, өөрийн болон нийтийн өмчийн ашиглалтын байдалд |

| | |
|---|---|
| | хуваарийн дагуу хяналт үнэлгээ хийдэг байх” гэсэн заалтыг нэмэлтээр оруулсан.<br>• Тоглоомын талбайд эрсдэл бүхий орчин нөхцөл байгаа эсэхийг өглөө, оройд тогтмол хянаж жижүүр хүлээлцэх дэвтэрт тэмдэглэдэг болсон.<br>• Цэцэрлэгийн багш, ажилчдыг “Хандлагаа өөрчилье” сургалтад хамруулсан. |
| Тулгарсан бэрхшээл, эрсдэл: | • Санхүүгийн нөхцөл боломж хомс байсан<br>• Цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эхчүүдийн оролцоо бага байсан<br>• Эцэг эхчүүд болон дүүрэг, нийслэлийн удирдлагууд цэцэрлэгийн тулгамдаж байгаа асуудлын талаар мэдээ мэдээлэл, төсөөлөл муу байлаа.<br>• Орчин бүрдүүлэхэд хөрөнгө мөнгө их шаардагдсан.<br>• Цэцэрлэгт эрсдэлгүй орчин бүрдүүлэхэд үйл ажиллагааны чиглэлээр мэргэжлийн ажилтан байхгүй. |
| Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс | • Дэмжих багийн гишүүд бусад эцэг эхчүүдэд нөлөөлж бодит байдлыг эцэг эхчүүдэд болон холбогдох хүмүүст танилцуулж санхүүгийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд туслах боломжтой байгууллагуудын жагсаалтыг гаргасан.<br>• Харьяа 5 дугаар хорооны удирдлага, Баянзүрх дүүргийн иргэдийн төлөөлөгчид, Нийслэлийн засаг даргын тамгын газарт цэцэрлэгийн гадна талбайн нөхцөл байдлыг танилцуулж, засаж янзлахад тусламж үзүүлэхийг хүсэж 2-3 удаа албан бичиг, захидал илгээсэн бөгөөд бидний хүсэлтийг нааштайгаар хүлээн авч шийдвэрлэсэн.<br>• Цэцэрлэгийн удирдлагын зүгээс шийдвэр гаргах түвшний хүмүүсийг байгууллага дээр урьж, өнөөгийн нөхцөл байдлыг танилцуулсан. Ажилчдынхаа нөөц бололцоонд тулгуурлан засан сайжруулах боломжит зүйлсийг засаж, гадаа талбайн хэсгийг ажилчдыг баг болгон хуваан, талбайн хэсгүүдийг хуваарилан өгч янзалсан. |
| Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс | • Гурвалсан гэрээ болон бусад бичиг баримт дээр эцэг эхчүүдийн оролцоог тусгаж, гэрээ хийх үедээ эцэг эх, асран хамгаалагчдад тэдний хүлээх үүрэг, хариуцлагыг сайтар танилцуулах<br>• Эцэг эхчүүдийн оролцоог дэмжих, дэмжих багийн гишүүн эцэг эхчүүдээр цэцэрлэгийн үйл ажиллагаа болон сургалтын үйл ажиллагааг явуулахад бэрхшээлтэй байгаа зүйлсийг багш, ажилчдын хамтаар илрүүлж, тэдгээрийг шийдэх боломжийг хамтран эрэлхийлэх, эцэг эхчүүдийн идэвхтэй |

| | |
|---|---|
| | төлөөллийг бий болгон бусад эцэг эхчүүдэд нөлөөлөх боломжийг бүрдүүлэх<br>• Санхүүгийн хөрөнгө оруулалтыг шийдэж өгөхөд дэмжлэг үзүүлэх, боломжит төрийн болон төрийн бус байгууллагууд руу хүсэлт илгээх<br>• Байгууллагын бүхий л үйл ажиллагаанд хамт олны оролцоо чухал гэдгийг тайлбарлах, цэцэрлэгт тулгамдаад байгаа асуудлыг танилцуулж, хамт олноороо шийдвэрлэх боломжийг хэлэлцэх, багаар хамтран ажиллах зэргээр хамт олны оролцоог нэмэгдүүлэх |
| Холбоо барих хаяг | **Нийслэлийн Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо 115 дугаар цэцэрлэг**<br>Эрхлэгч: Ё.Жаргалмаа, Утас-99021497, jak.anir@gmail.com<br>Арга зүйч: Ц.Наранжаргал, Утас-88284161, naraajargal888@gmail.com |

## БАРИЛГЫН ЗАСВАР ЭХЛЭХИЙН ӨМНӨХ ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

| | |
|---|---|
| Зорилго | Бага насны хүүхдийг эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих тав тухтай, дулаан нөхцөлийг бүрдүүлж, эцэг эхчүүдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх |
| Нөхцөл байдал, тулгамдсан асуудал | • Манай цэцэрлэгийн барилга 33 жилийн насжилттай, дулаан алдагдал ихтэй, гадна талын өнгө шавардлагаа хуулран унасан байсан.<br>• Барилгын дээврийн хар цаас маш их нөхөөстэй, хагарч, урагдсан бүрэн бүтэн байдал алдагдсан, хар цаасны завсраар ус чийг нэвчсэн.<br>• Дотор талын бүх анги танхим, өрөө тасалгааны тааз, агааржуулалтын нүх норсон, шохой будаг нь хуурларсан улмаар хөгц, мөөгөнцөр ургасан.<br>• Аваарын хаалгаар маш их дулаан алдагдалтай, хаалганууд элэгдсэн. Барилгын гадна талын булангуудын залгаас цуурсан.<br>• Анги танхим, өрөө тасалгааны шалнууд олон жилийн элэгдэлтэй, энхэл донхол үүссэн.<br>Дээрх нөхцөл байдлаас үүдэн хүүхдүүдийн хувьд эрүүл, аюулгүй сурч хөгжих орчин нөхцөл бүрдээгүй. |
| Зорилтот бүлэг | 13 бүлгийн хүүхэд, эцэг, эх, багш, ажилчид |
| Шалгуур үзүүлэлт | • Дээврээс ус гоожих байдлыг бүрэн зогсоож, дээврийг битүүмжлэх |

| | |
|---|---|
| | • Анги танхимын хана таазыг хөгц мөөгөнцөргүй, агааржуулалт сайтай болгох<br>• Дээврийн хар цаасны даравч төмрийг стандартын дагуу зөв хийх<br>• 52 цонхыг стандартын шаардлага хангасан чанартай цонхоор сольж, стандартын дагуу суурилуулах<br>• Гадагшаа гардаг нэг давхрын 4 хаалга болон ангиудын 7 аваарын хаалгыг дулаалгатай, чанартай төмөр хаалгаар солих<br>• Дээврийн ус зайлуулах шугамыг стандартын дагуу шаардлага хангасан материалаар хийж гүйцэтгэх<br>• Барилгын гадна талын хөөсөнцөр дулаалгыг зургийн дагуу шаардлага хангасан материалаар чанартай, өнгө үзэмжтэй хийх<br>• Цэцэрлэгийн төв хаалганд хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчиход зориулагдсан налуу шат хийх<br>• Гадна талын аваарын шатуудыг стандартын дагуу бүрэн солих |
| Хэрэгжүүлсэн үйл явц, үе шат | • Эцэг эхийн оролцоот хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх дэмжих багийг байгуулсан.<br>• Дэмжих багийн гишүүдийг нэг ойлголт, мэдээлэлтэй болгох үүднээс барилгын дулаалгын ажил хийх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чадавхжуулах сургалтад хамруулсан.<br>• Барилгын засвар эхлэхийн өмнөх эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг дэмжих багийн гишүүд биe дааж хийсэн.<br>• Дэмжих багийн гишүүд хяналтын хуудастай танилцан, хоорондоо ярилцаж ойлголт мэдээллээ нэгтгэсэн.<br>• Хяналт-шинжилгээ, үнэлгээг нэгтгэж нэгдсэн тайлан зөвлөмж боловсруулж дүгнэлтдээ тулгуурлан, зөвшилцлийн хуудас боловсруулсан.<br>• Барилгын гүйцэтгэгч компанитай харилцан ярилцаж, зөвшилцлийн хуудсыг баталгаажуулсан.<br>• Барилгын засварын явцад дэмжих багийн гишүүд өдөр тутмын хяналт болон эхний, дунд, эцсийн шатны хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн.<br>• Шат бүрийн үнэлгээний дүгнэлтэд үндэслэн тулгарсан асуудлыг гүйцэтгэгч компанитай харилцан зөвшилцөж ажилласан.<br>• Зөвшилцлийн хуудсан дээр заагдсан ажлууд хэрхэн хэрэгжсэн талаар дүгнэх хуудас боловсруулан баримтжуулсан. |

| | |
|---|---|
| Хүрсэн үр дүн (Богино хугацаанд гарсан өөрчлөлтүүд) | • Барилгын дулаан алдагдал буурч, өнгө үзэмжтэй болсон.<br>• Дээврээс ус гоожих асуудалгүй болж муудсан хар цаас бусад материалыг хуулж, сэндвичэн дээврийг бүрэн хийж гүйцэтгэсэн.<br>• Анги танхимын хана таазны мөөгөнцрийг цэвэрлэж, ариутгалын бодис цацаж, агааржуулалт хэвийн явагдаж байна.<br>• Парпед төмрийг стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.<br>• 52 ширхэг цонхыг стандартын шаардлага хангасан, чанартай цонхоор сольж, стандартын дагуу суурилуулсан.<br>• Гадагшаа гардаг 1 давхрын 4 хаалга болон ангиудын 7 аваарын хаалгыг дулаалгатай, чанартай төмөр хаалгаар сольсон.<br>• Дээврийн ус зайлуулах шугамыг стандартын шаардлага хангасан материалаар хийж гүйцэтгэсэн.<br>• Барилгын гадна талын хөөсөнцөр дулаалгыг зургийн дагуу шаардлага хангасан материалаар чанартай, өнгө үзэмжтэй хийсэн.<br>• Цэцэрлэгийн төв хаалганд хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих зориулалтын налуу шат хийсэн.<br>• Гадна талын аваарын шатуудыг стандартын дагуу бүрэн сольсон. |
| Үр дүнг тогтворжуулахаар хийсэн алхмууд | • Дэмжих багийн гишүүд болон багш, ажилчид засварын явцад өдөр бүр хуваарийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр харилцан тохиролцож төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн.<br>• Цэцэрлэгийн дотоод хяналт шалгалтын комисс эцэг эхийн төлөөлөлтэй хамтран хагас жилд нэг удаа барилгад үзлэг хийж, үр дүнг багш ажилчид, эцэг эхчүүдэд танилцуулж гарсан зөрчил дутагдлыг арилгуулж байхаар төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна.<br>• Цэцэрлэгийн хөдөлмөрийн дотоод журмын 3.35-д “Багш ажилтан байгууллагын эд хөрөнгийг зүй зохистой хэрэглэх, ашиглах, эвдрэл гэмтэл учруулсан тохиолдолд засварлах, өөрийн болон нийтийн өмчийн ашиглалтын байдалд хуваарийн дагуу хяналт үнэлгээ хийдэг байх” гэсэн заалтыг шинээр оруулсан.<br>• Багш ажилчдын ашиглаж байгаа нийтийн эзэмшлийн талбайн өмч хөрөнгийг ариг гамтай хэрэглэж, засан сайжруулж байгаа талаар улирлын ажлыг дүгнэх үнэлгээнд оруулсан. |

| | |
|---|---|
| Тулгарсан бэрхшээл, эрсдэл: | • Эцэг эх, багш ажилчдын барилгын их засвар, дулаалгын талаарх мэдлэг боловсрол дутмаг байсан.<br>• Хяналт-шинжилгээ, үнэлгээг бүрэн хийгээд эргээд үр дүнг нь тооцож, зөрчил дутагдлыг арилгах тал дээр ач холбогдол өгдөггүй байсан нь бидэнд ихээхэн бэрхшээл болж байв.<br>• Дэмжих баг, гүйцэтгэгч компанийн хооронд бага зэргийн үл ойлголцох байдал үүсэж байсан.<br>• Хугацаа давчуу, зураг төсөлд зарим чухал зүйлсийг тусгаагүй байсан нь бэрхшээлтэй байлаа. |
| Амжилтад нөлөөлсөн хүчин зүйлс | • Төсөл эхэлснээс хойш төслийн багийн зүгээс өгсөн зөвлөгөө, заавар, чиглүүлэг, үе шаттай чадавхжуулах сургалтад хамрагдсанаар нэгдсэн ойлголт төсөөлөлтэй болж төслийг амжилттай хэрэгжүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлсэн.<br>• Дэмжих багийн гишүүдээр ажилласан хоёр эцэг эх барилгын чиглэлээр ажилладаг мэргэжлийн хүмүүс байсан нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд ихээхэн дөхөмтэй байсан.<br>• Хяналтын инженер засварын ажлын явцад өдөр тутам хяналт хийж, засварын ажлыг чанартай, стандартын дагуу хийж гүйцэтгэхэд чухал нөлөө үзүүлсэн.<br>• Дэмжих багийн гишүүд 3 шатлалт хяналт-шинжилгээ,үнэлгээ хийж засварын ажлын явцад тулгамдсан асуудал болон стандарт бус хийгдэж байгаа зүйлсийг илрүүлэн тухай бүрд нь засаж сайжруулж байсан. |
| Түгээн дэлгэрүүлэхэд анхаарах зүйлс | • Засварын зураг гарахаас өмнө эцэг эхийн оролцоот үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж барилгын зурагт оруулах саналыг эцэг эхчүүд болон тухайн байгууллагын багш ажилчдаас авахад анхаарч ажиллах нь үр дүнтэй.<br>• Эцэг эхчүүдийн оролцоог цэцэрлэгийн бүхий л үйл ажиллагаанд чухалчлах, тэдний санал бодлыг сонсох шаардлагатай.<br>• Төрийн болон төрийн бус өмчийн байгууллагад тулгамдаад байгаа асуудлаа бодит нөхцөл байдал, баримт нотолгоонд тулгуурлан тухай бүрд нь танилцуулж, тусламж дэмжлэг авах боломжийг эрэлхийлэх хэрэгтэй |
| Холбоо барих хаяг | **Нийслэлийн Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо 115 дугаар цэцэрлэг**<br>Эрхлэгч: Ё.Жаргалмаа, Утас-99021497, jak.anir@gmail.com<br>Арга зүйч: Ц.Наранжаргал, Утас-88284161, naraajargal888@gmail.com |

## БАРИЛГЫН ИХ ЗАСВАР, ДУЛААЛГЫН АЖИЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨХ ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООТ ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Дүүрэг: Баянзүрх Байгууллага: 115 дугаар цэцэрлэг

Огноо: 2020 оны 6 дугаар сарын 9-ны өдөр

| | | |
|---|---|---|
| **Их засвар, дулаалгын ажил эхлэхээс өмнөх барилгын нөхцөл байдлын ерөнхий мэдээлэл** | | |
| 1 | Барилгын ашиглалтад орсон огноо | 1987.08.01 |
| 2 | Өмнө нь хэдэн удаа, ямар засвар үйлчилгээ хийгдсэн | |
| Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 2003 онд дулааны дотор шугам сүлжээнд сантехникийн их засвар хийгдсэн. | | |
| 3 | Барилгын өнөөгийн нөхцөл байдал | |
| • 33 жилийн настай уг барилга нь дулаан алдагдал ихтэй, гадна талын шавардлагаа хуударсан, унасан байдалтай.<br>• Барилгын дээврийн хар цаас маш их нөхөөстэй, хагарч урагдан бүрэн бүтэн байдал алдагдсан, хар цаасны завсраар ус чийг нэвчсэн.<br>• Дотор талын бүх анги танхим, өрөө тасалгааны тааз, агааржуулалтын нүх норсон, шохой будаг нь хуударсан, улмаар хөгц, мөөгөнцөр ургасан.<br>• Ааварын хаалгаар маш их дулаан алдагдалтай, хаалгануудын эд анги муудсан, элэгдсэн.<br>• Барилгын гадна талын булангуудын залгаас цуурсан.<br>• Барилгын анги танхим өрөө тасалгааны шалнууд олон жилийн элэгдэлтэй. | | |
| 4 | Барилга нь иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй бат бөх тогтвортой, галын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор хөнөөлийг хязгаарласан эсэх | |
| • Чийг мөөгөнцөр ихтэй учир хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй орчин нөхцөл бий болсон.<br>• Агааржуулалт муу, агааржуулалтын хоолойнуудын шавар шохой унаж битүүрсэн.<br>• Ааварын шат стандарт биш огцом, хүүхдийн хөл шатны гишгүүрийн завсраар орох эрсдэлтэй.<br>• Галын аюулгүй байдал хангагдаагүй цахилгааны утас ил залгаас холбоос ихтэй, аянга зайлуулагч, газардуулга байхгүй.<br>• Шал цуурсан зарим хэсгээр цөмрөх эрсдэл үүссэн. | | |
| 5 | Цахилгаан хангамж, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй байгаа эсэх аянга зайлуулагч, газардуулгатай эсэх | |

| | |
|---|---|
| | • Цахилгааны эх үүсвэр нэгдсэн шугамд холбогдсон<br>• Газардуулга нүдэнд ил харагдах зүйлгүй<br>• Щитний өрөө жижиг<br>• Галаас хамгаалах, гал гарсан үед хэрэглэх хэрэгсэл маш дутмаг |
| 6 | Барилгын дээврийн өнөөгийн нөхцөл байдал, дээвэр дээр харилцаа холбооны ямар нэг антен тоног төхөөрөмж байрлуулсан эсэх, бэхэлгээ аюулгүй байдал хангагдсан эсэх |
| | • Барилгын дээврийн нөхцөл маш муу, хуучирч муудсан, язралттай сольж сайжруулах, шинэчлэх шаардлагатай.<br>• Телевизорын хоёр антены нэг нь бэхлэгдээгүй байна.<br>• Цахилгааны утаснууд замбараагүй байрласан, шалбарсан, залгаа ихтэй байгаа нь галын аюул үүсгэхээр байна. |
| 7 | Барилгын суурь болон суурийн дулаалгын өнөөгийн байдал |
| | • Барилгын үндсэн хийц ерөнхийдөө сайн.<br>• Суурийн дулаалгын байдал хэвийн (харагдах байдал)<br>• Барилгын суурь урд хэсгээрээ хагарал өгсөн.<br>• Барилгын булан залгааснууд хооронд хагарал үүссэн. |
| 8 | Барилгын халаалтын төрөл |
| | ○ **Нийтийн халаалт** |
| 9 | Барилгын дулаан алдагдал хамгийн ихтэй хэсэг, шалтгаан, таамаглал |
| | • Барилгын дулаан алдагдал дээвэр, цонх, хаалганаас шалтгаалж байгаа гэж үзэж байна.<br>• Дээвэр, цонх, аваарын хаалгануудыг зайлшгүй сольж сайжруулах шаардлагатай, маш их дулаан алддаг.<br>• Хаалга, цонх өвөлдөө цантдаг, зун борооны дусаал маш ихээр гоождог. |
| 10 | Барилгад хөгц, мөөгөнцөр, чийгшил тогтсон байгаа эсэх (аль аль хэсэгт, ямар хэсэгтэй тогтсон байгааг нарийвчлан тэмдэглэх) |
| | • Барилгын дээврийн хэсэгт буюу анги танхимын тааз, хана, ариун цэврийн өрөөний 820м$^2$ талбайн хана, таазанд хөгц мөөгөнцөр ургасан.<br>• Ихэнх ангиуд дүүжин тааз хийж далдалсан, аваарын гарцын ойр орчинд хуулга нааж хөгц, чийгийг далдалсан.<br>• 2 давхрын анги танхимын өрөө тасалгаанаас нийт 450 м$^2$ талбайд чийг хуримтлагдаж, хөгц мөөгөнцөр үүссэн байлаа.<br>• 1 давхрын ангиудын дээвэр, аваарын хаалганы орчим нийт 370м$^2$ талбайд чийг хуримтлагдаж хөгц мөөгөнцөр ургасан байна. |
| 11 | Цонхны бодит байдал (нийт цонхны тоо үүнээс вакум болон модон цонхны тоо, цонхны эвдрэл гэмтэл, рамын өргөн, давхар шилний тоо зэргийг тэмдэглэх) |

| | |
|---|---|
| | • Том-44<br>• Жижиг-8<br>• Бүгд вакум буюу хуванцар рамтай, 2 давхар шилтэй<br>• Рамын өргөн 50 мм орчим байсан.<br>• Цонхны хүрээ, резин жийрэг илэгдсэн, рамуудын хүрээний хооронд зай завсар үүссэн.<br>• Цонхны хуванцар рамыг цоолж янз бүрийн утас (кабель, холбооны) сүвлэсэн байдалтай. |
| 12 | Барилгын гадна хаалганы тоо, эвдрэл гэмтэл, дулаан алдагдал байгаа эсэх |
| | • Вакум - 7ш<br>• Бүргэд- 4ш<br>• Вакум хаалга нь 2 давхар шилтэй, дан хийгдсэн. Нүдээр харахад дулаан алдагдал ихтэй гадна талын хэсэгт зай завсар их, хагарсан байдалтай.<br>• Ангид байгаа аваарын хаалга болон гадна талд дулаалгатай төмөр хаалга хийх шаардлагатай.<br>• Гадагшаа гардаг нэг давхрын 4 хаалганы эд анги муудсан, төмөр хэсгүүд хөндийрч хооронд нь зай завсар үүссэн, жийрэг резинүүд илэгдсэн байдалтай байна. |
| 13 | Барилга нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан эсэх |
| | • Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан орц гарц хийгдээгүй.<br>• Давхар хооронд зориулалтын хэрэгслээр тоноглогдоогүй.<br>• Ангиудын ариун цэврийн өрөөнд ХБИ-д зориулсан тоноглол хийгдээгүй. |
| Барилгын өнөөгийн нөхцөл байдлын талаарх ерөнхий дүгнэлт | |
| | • Барилын нөхцөл байдал тааруу, зайлшгүй засан сайжруулах шаардлагатай.<br>• Дээврийн хар цаас бүхэлдээ хагарч цуурсан.<br>• Хаалганууд муу завсар зай ихтэй, эд ангиуд нь элэгдэж муудсан.<br>• 33 жилийн хугацаанд нэг удаа дулааны дотор шугамд сантехникийн их засар хийгдсэн, өөр засвар хийгдэж байгаагүй.<br>• 2 давхрын анги танхим, өрөө тасалгаануудад тэр чигтээ борооны ус гоождог, дээвэр хана дагаж хөгц мөөгөнцөр үүссэн, нэг давхрын анги танхимуудын дээвэр, аваарын хаалга, хана дагаж чийг хуримтлагдаж хөгц мөөгөнцөр үүссэн. |
| Барилгын их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэхэд анхаарах зүйлс | |
| | • Дулаалгын ажлыг хийж гүйцэтгэхдээ стандартын шаардлага хангасан чанартай материал сонгон хийж гүйцэтгэх<br>• Дээврийн ажлын үед хар цаасны даравч төмрийг стандартын дагуу зөв хийх<br>• Цонхнуудыг стандартын шаардлага хангасан чанартай цонхоор сольж, стандартын дагуу суурилуулах |

- Гадагшаа гардаг 1 давхрын 4 хаалга болон ангиудын 7 аваарын хаалгыг дулаалгатай, чанартай, төмөр хаалгаар солих
- Дээврийн дулаалгыг стандартын дагуу, батлагдсан зургаараа хийж гүйцэтгэх
- Дээврийн ус зайлуулах шугамыг стандартын дагуу шаардлага хангасан материалаар хийж гүйцэтгэх
- Барилгын гадна талын хөөсөнцөр дулаалгыг зургийн дагуу шаардлага хангасан материалаар чанартай хийх
- Гадна фасадын дулаалгыг хийхдээ цонх, хаалганы хүрээнд тааруулан зүслэг болон цавуут зуурмагийг түрхлэгийг стандартын дагуу хийж гүйцэтгэх
- Барилгын гадна болон доторх хананы будаг, замаск, шавар, шохой хууларч хөндийрснийг засаж өнгөлөх
- Аянга зайлуулагч, газардуулгыг стандартын дагуу хийх
- Цэцэрлэгийн 2 талын гарцад хөгжлийн бэрхшээлтэй иргэд орж гарахад зориулагдсан налуу шат хийх
- Цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын борооны дусаал гоождог 150м$^2$ талбайн дээврийн хэсгийг янзлах
- Гадна талын аваарын шатнуудыг стандартын дагуу бүрэн солих
- Цэцэрлэгийн өргөтгөл, хуучин барилга 2-ыг ижил өнгөтэй болгож будах
- Барилгын ажил хийх явцад дээвэр дээр байгаа холбоо харилцааны утас, кабелийг таслахгүй болгоомжтой шилжүүлэн байрлуулах
- Барилгын ажлыг хийх явцад барилгын материалыг буулгах, ачих, техник тоног төхөөрөмж орж гарах үед барилгын үндсэн хийц, ногоон байгууламж, хашаа хайсаар болгоомжтой орж гарах, гэмтээхгүй байхад анхаарах
- Барилгын ажлыг хийж гүйцэтгэх явцад барилгын хог, хаягдлыг тухай бүрд нь ачиж холдуулах
- Барилгын ажил хийж гүйцэтгэх явцад барилгын эргэн тойронд байгаа худаг муу усны нүхийг таглахгүй чөлөөтэй байлгах

## ЗӨВШИЛЦЛИЙН ХУУДАС

*Нийслэлийн Баянзүрх дүүргийн 115 дугаар цэцэрлэгийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа "Ган хэлхээ констракшн" ХХК нь "Монгол дахь барилга байгууламжийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь төслийн хүрээнд зохион байгуулалтад орсон "Дэмжих баг"-ийн гишүүдийн барилгын засвар, дулаалгын ажил эхлэхийн өмнө хийсэн эцэг эхийн оролцоот, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, санал дүгнэлттэй танилцлаа.*

| | | |
|---|---|---|
| **Дэмжих багийн гишүүдийн тайланд туссан дараах зүйлсийг гүйцэтгэгчийн зүгээс их засвар, дулаалгын эхлэлийн шатанд бүрэн тусгаж ажиллахаа талууд харилцан тохиролцлоо.** | | |
| • Дулаалгын ажлыг хийж гүйцэтгэхдээ стандартын шаардлага хангасан чанартай материал сонгон хийж гүйцэтгэх<br>• Дээврийн дулаалгыг стандартын дагуу, батлагдсан зургаараа хийж гүйцэтгэх<br>• Гадна фасадын дулаалгыг хийхдээ цонх, хаалганы хүрээнд тааруулан зуслэг болон цавуут зуурмагийн түрхлэгийг стандартын дагуу хийж гүйцэтгэх<br>• Барилгын ажлыг хийх явцад барилгын материалыг буулгах, ачих, техник тоног төхөөрөмж орж гарах үед барилгын үндсэн хийц, ногоон байгууламж, хашаа хайсаар болгоомжтой орж гарах, гэмтээхгүй байхад анхаарах<br>• Барилгын ажил хийж гүйцэтгэх явцад барилгын эргэн тойронд байгаа худаг муу усны нүхийг таглахгүй чөлөөтэй байлгах<br>• Барилгын ажил хийх явцад дээвэр дээр байгаа холбоо харилцааны утас, кабелийг таслахгүй болгоомжтой шилжүүлэн байрлуулах | | |
| Дэмжих багийн ахлагч<br>Ц.Наранжаргал | Хяналтын инженер<br>Д.Эрдэнэтуяа | Компанийн захирал<br>Д.Батдорж |

## ЗӨВШИЛЦЛИЙН ХУУДАСНЫ БИЕЛЭЛТ БУЮУ ДҮГНЭХ ХУУДАС

*Нийслэлийн Баянзүрх дүүргийн 115 дугаар цэцэрлэгийн их засвар, дулаалгын ажлыг гүйцэтгэж байгаа “Ган хэлхээ констракшн” ХХК болон “Дэмжих баг”-ийн гишүүдийн харилцан зөвшилцсөн ажил доорх байдлаар биелэгдсэн байна.*

| № | Зөвшилцсөн ажлууд | Ажлын биелэлт |
|---|---|---|
| 1. | 2. Дулаалгын ажлыг хийж гүйцэтгэхдээ стандартын шаардлага хангасан чанартай материал сонгон хийж гүйцэтгэх | Барилгын материалыг стандартад нийцсэн, тусгай зөвшөөрөлтэй газраас нийлүүлсэн.<br>Гүйцэтгэл 100% |
| 3. | Барилгын дээврийн дулаалгыг стандартын дагуу, батлагдсан зургаараа хийж гүйцэтгэх | Барилгын дээврийн ажлыг зургийн дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд зурагт тусгагдаагүй ус зайлуулах хоолойг хийсэн.<br>Гүйцэтгэл 100% |
| 4. | Гадна фасадын дулаалгыг хийхдээ цонх, хаалганы хүрээнд тааруулан зуслэг болон цавуут зуурмагийг түрхлэгийг стандартын дагуу хийж гүйцэтгэх | Гадна талын фасадын дулаалгын ажлыг стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.<br>Гүйцэтгэл 100% |

<table>
<tr><td>5.</td><td>Барилгын ажил гүйцэтгэх явцад барилгын эргэн тойронд байгаа худаг, муу усны нүхийг таглахгүй чөлөөтэй байлгах</td><td>Барилгын ажил гүйцэтгэх явцад барилгын эргэн тойронд байгаа худаг муу усны нүхийг таглаагүй чөлөөтэй байсан.</td></tr>
<tr><td>6.</td><td>Барилгын ажлыг хийх явцад барилгын материалыг буулгах, ачих, техник тоног төхөөрөмж орж гарах үед барилгын үндсэн хийц, ногоон байгууламж, хашаа хайсаар болгоомжтой орж гарах, гэмтээхгүй байхад анхаарах</td><td>Барилгын ажлыг хийх явцад байгууллагын хашаа хайс, орчин тойронд гэмтэл үүсээгүй, зарим тохиолдолд барилгын хойно байрладаг хаалгыг салгаж орж гарч байсан, буцаагаад хуучин байсан хэвээр суурилуулсан.</td></tr>
<tr><td>7.</td><td>Барилгын ажил хийх явцад дээвэр дээр байгаа холбоо харилцааны утас, кабелийг таслахгүй болгоомжтой шилжүүлэн байрлуулах</td><td>Дээврийн засварыг хийх явцад холбоо харилцааны утаснуудыг засвар эхлэхээс өмнө салгаж буулгасан.</td></tr>
<tr><td colspan="3">Дүгнэлт:</td></tr>
<tr><td colspan="3">Барилгын гүйцэтгэгч “Ган хэлхээ констракшн” ХХК-тай Дэмжих багийн гишүүдийн харилцан зөвшилцсөн 6 ажлаас 6 ажил бүрэн 100% биелэлттэй байна.</td></tr>
<tr><td colspan="3">Биелэлтийг дүгнэсэн хүний нэр, холбоо барих хаяг, утас:</td></tr>
<tr><td colspan="3">Нийслэлийн Баянзүрх дүүргийн 115 дугаар цэцэрлэг Арга зүйч: Ц.Наранжаргал<br>Утас: 88284161</td></tr>
</table>

# ЗУРГИЙН ЦОМОГ








